номын сан

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10-11

— Харьяатын тухай Монгол Улсын хууль
— Боловсролын тухай Монгол Улсын хууль
— Дээд боловсролын тухай Монгол Улсын хууль
— Бага, дунд боловсролын тухай Монгол Улсын хууль
— Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
— Нөхөрлөл компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай Монгол Улсын хууль
— Төрийн нууцын жагсаалт батлах тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

1995 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1995 оны 10-11 сар № 10-11 /41-42/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Харъяатын тухай 1078
2. Хууль хүчингүй болсонд тооцох тухай 1089
3. Боловсролын тухай 1089
4. Дээд боловсролын тухай 1111
5. Бага, дунд боловсролын тухай 1122
6. Хууль хүчингүй болсонд тооцох тухай 1135
7. Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1136
8. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай 1136
9. Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай 1137
10. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай 1137
11. Зарлиг, зарлигийн заалт хүчингүй болсонд тооцох тухай 1138
12. Нөхөрлөл компанийн тухай болон хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1139
13. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1141
14. Төрийн нууцын жагсаалт батлах тухай 1144

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

15. Харъяатын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай №32 1162
16. Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай №42 1162
17. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг батлах тухай №43 1164
18. Хуучин Югославын Бүгд Найрамдах Македони Улстай дипломат харилцаа тогтоох тухай №44 1174
19. Улсын төвлөрсөн төсвийн 1994 оны гүйцэтгэлийг батлах тухай №45 1174
20. Монголбанкны 1994 оны тайлан тэнцэл, ашгийн хуваарилалт батлах тухай №46 1175
21. Төрөөс баримтлах мөнгөний бодлогыг хэрхэн биелүүлж байгаа тухай №47 1176
22. Төрийн хянан шалгах хорооны төсвийг батлах тухай №48 1178
23. Хууль зүйн байгын хорооны тавьсан саналын дагуу авах арга хэмжээний тухай №49 1178
24. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай №50 1179
25. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн тухай №51 1180
26. 1995 онд гүйлгээний сангаас аж ахуйн нэгжүүдэд худалдах алт, мөнгөний хэмжээг батлах тухай №53 1181
27. Хэрлэн, Өндөрхаан сумдыг нэгтгэж Хэрлэн сум байгуулах тухай №54 1181
28. Хотын нэрийг өөрчлөх тухай №55 1183
29. Нийслэлийн өдөр тогтоох тухай №56 1183
30. Шүүх байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэх тухай №57 1184
31. Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл байгуулах тухай №58 1184
32. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийг татан буулгах тухай №59 1185

33. Нийгмийн дэг журам хангах зарим арга хэмжээний тухай №60 1186

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

34. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг батлах тухай №109 1204
35. Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тайх уламжлалыг сэргээх санаачилгыг дэмжих тухай №110 1206
36. Чүлтэмсүрэнгийн Жаргалсайханд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №113 1209
37. Хүүхдийн соёл хүмүүжил, халамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай №119 1209
38. Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай №122 1211
39. Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай №123 1212
40. Зарим шүүхийн шүүгчдийг томилох тухай №126 1212

IY. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

41. Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай №02 1213
42. Цагдаагийн байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар №05 1229

Y. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

43. Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай №53 1235
44. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай №55 1268
45. Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох хөдөлмөрийн нөхцөлийн тухай №59 1273

46. Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №60 1274
47. Тэтгэвэр авагчдын нийтийн тээврийн унааны зардлын зарим хэсгийг нөхөн олгох тухай №61 1277
48. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №62 1277

YI. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

49. Тогтоолд нэмэлт оруулах тухай №230 1279
50. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай №245 1280

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРЬЯАТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэний харьяалал хийгээд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяатаас гарахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Харьяатын тухай хууль тогтоомж

1. Харьяатын тухай хууль тогтоомж нь үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд харьяатын тухай хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Монгол Улсын харьяат байх

1. Дор дурьдсан хүн Монгол Улсын харьяат байна.

1/ энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр Монгол Улсын харьяат байгаа;

2/1921 оны долдугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монгол Улсын харьяат байсан бөгөөд Монгол Улсын харьяатаас гараагүй хүмүүс;

3/ энэ хуулийн дагуу Монгол Улсын харьяат болсон.

2. Монгол Улсын харьяат гадаад улсад оршин суух нь иргэний харьяаллаа алдах үндэслэл болохгүй.

3. Гэрлэгсдийн аль нэг нь Монгол Улсын харьяат болох буюу харьяатаас гарах нь эхнэр буюу нөхрийн харьяатыг өөрчлөхөд хүргэхгүй.

4. Монгол Улсын харьяат хаана оршин сууж байгаагаас үл хамааран төрийн ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулна.

5. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

4 дүгээр зүйл. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх.

1. Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй.

2. Гадаад улсын харьяат нь Монгол Улсын харьяат болохыг хүсвэл тухайн улсынхаа харьяатаас гарсан байх шаардлагатай. Хэрэв тухайн гадаад улсын хууль тогтоомжид өөр улсын харьяат болсноор иргэний харьяаллаа алдахаар зохицуулагдсан бол тухайн улсынхаа харьяатаас гарсан байхыг шаардахгүй байж болно.

5 дугаар зүйл. Иргэний харьяаллыг гэрчлэх баримт бичиг

1. Монгол Улсын иргэний харяаллыг гэрчлэх баримт бичиг нь Монгол Улсын иргэний паспорт, түүнийг авах хүртэл хугацаанд төрсний гэрчилгээ байна.

2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, харьяалалгүй эцэг эхээс төрсөн хүүхдэд олгосон төрсний гэрчилгээг зөвхөн түүний төрснийг нотлох баримт бичиг гэж үзнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын харьяат байх, харьяат болох, харьяатаас гарах

6 дугаар зүйл. Монгол Улсын харьяат болох үндэслэл

Дор дурдсан үндэслэлээр Монгол Улсын харьяат болно:

1/төрснөөр;

2/Монгол Улсын харьяат болсноор;

3/харьяаллыг сэргээн тогтоосноор;

4/Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэлээр.

7 дугаар зүйл. Хүүхэд Монгол Улсын харьяат байх

1. Эцэг эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан үед төрсөн хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу түүний гадна төрснөөс хамаарахгүй Монгол Улсын харьяат байна.

2. Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна. Хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол хүүхдийн иргэний

харьяаллыг эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

3. Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь харьяалалгүй хүн байхад тэдний дундаас төрсөн хүүхэд хаана төрснөөс хамаарахгүйгээр Монгол Улсын харьяат байна.

4. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд эцэг, эх нь хоёулаа тогтоогдоогүй хүүхэд Монгол Улсын харьяат байна.

5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж буй харьяалалгүй эцэг, эх хоёрын дундаас төрсөн хүүхэд харьяалалгүй байна.

6. Харьяалалгүй хүний үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.

8 дугаар зүйл. Монгол Улсын харьяат болох

Гадаадын иргэн буюу харьяалалгүй хүн хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын харьяат болж болно.

9 дүгээр зүйл. Монгол Улсын харьяат болох нөхцөл

1. Монгол Улсын харьяат болохын тулд дараахь нөхцөлийг хангасан байна:

1/амьжиргааны зохих чадвар, эх үүсвэртэй байх;

2/Монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэлний талаар зохих мэдлэг эзэмшсэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр таваас доошгүй жил байнга оршин суусан байх;

3/ Монгол улсын харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хэсгийн 1,2-т заасан хүрээнд төрийн бодлогыг үндэслэн тогтоосон бусад тодорхой шалгуурыг хангасан байх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл нь насанд хүрээгүй хүн энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр иргэний харьяаллыг сэргээн тогтоолгож байгаа хүнийг Монгол Улсын харьяат болгох асуудлыг шийдвэрлэхэд хамаарахгүй.

10 дугаар зүйл. Монгол Улсын харьяат болгохоос татгалзах үндэслэл

1. Дор дурдсан үндэслэлээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгохоос татгалзана:

1/олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон;

2/Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулж байгаа бол;

3/олон улсын алан хядах байгууллагын гишүүн гэж зарлагдсан хүн;

4/ шүүхээр онц аюултай гэмт хэрэгтэн гэж тогтоогдсон;

5/ сэтгэл мэдрэлийн буюу гоц халдварт өвчтэй, мансууруулах бодис хэрэглэх донтой, архаг архичин гэдэг нь зохих журмаар тогтоогдсон;

6/ ял шийтгэл эдэлж байгаа бол;

7/ Монгол Улсын нутаг дэвсгэрээс албадан гаргагдсанаас хойш 10 жил өнгөрөөгүй бол.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь зохих журмын дагуу нотлогдсон бол Монгол Улсын харьяат болгохоос татгалзах тухай саналаа харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид уламжилна.

11 дүгээр зүйл. Монгол Улсын харьяатаас гарах

Энэ хуулиар тогтоосон журмын дагуу Монгол Улсын харьяат өөрийн хүсэлтийн дагуу Монгол Улсын харьяатаас гарч болно.

12 дугаар зүйл. Харьяатаас гаргахыг татгалзах

Дор дурьдсан үндэслэлээр Монгол Улсын харьяатаас гаргахыг татгалзаж болно:

1/ харьяатаас гарах тухай хүсэлт гаргасан хүн Монгол Улсын өмнө хүлээсэн буюу иргэн, байгууллагын ашиг сонирхолтой холбогдсон эд хөрөнгийн үүргээ биелүүлээгүй;

2/ харьяатаас гарах тухай хүсэлт гаргасан хүн гэмт хэрэг үйлдсэний улмаас сэжигтэн, яллагдагчаар татагдсан буюу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял эдэлж байгаа;

3/ харьяатаас гарах нь Монгол Улсын үндэсний болон нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахаар бол.

13 дугаар зүйл. Үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэх

1. Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.

2. Хэрэв гадаадын иргэн, эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах үед түүний иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно.

3. Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 насанд хүрсэн хүүхдийг тэдний хүсэлтээр Монгол Улсын харьяатаас гарахыг зөвшөөрч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох, иргэний харьяаллаа алдах

14 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох

1. Дор дурьдсан тохиолдолд Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтооно:

1/ үрчлэгдсэнтэй холбогдож Монгол Улсын иргэн энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр иргэний харьяаллаа алдсан;

2/ эцэг, эхийн нь харьяат өөрчлөгдсөнтэй холбогдож Монгол Улсын иргэн иргэний харьяаллаа алдсан бол 18 нас хүрснээс хойш таван жилийн дотор;

3/ 1921 оны долдугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монгол Улсын харьяат байсан бөгөөд аль нэг гадаад улсын харьяат болсон хүмүүс.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тохиолдолд иргэний харьяаллаа сэргээлгэхийг хүссэн хүн өргөдлөө харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3. Иргэний харьяаллыг сэргээн тогтоолгох тухай өргөдлийг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан Монгол Улсын Ерөнхийлөгчид гаргана.

4. Хэрэв гадаад улсын харьяат болох зорилгоор Монгол Улсын харьяатаас гарсан этгээд гадаад улсын харьяат болж чадаагүй бол өөрийн нь хүсэлтээр Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтооно.

15 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллыг алдах үндэслэл

1. Дор дурьдсан үндэслэлээр Монгол Улсын иргэний харьяаллыг алдана:

1/ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр;

2/ эцэг, эхийн иргэний харьяалал өөрчлөгдсөнөөр;

3/ өөрийн талаар хуурамч баримт бичиг, худал мэдээлэл бүрдүүлж Монгол Улсын харьяат болсон нь тогтоогдсоноор;

4/ Монгол Улсын олон улсын гэрээнд болон энэ хуульд заасан бусад үндэслэлээр;

5/ Монгол Улсын харьяатаас гарснаар.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан үндэслэлээр Монгол Улсын иргэний харьяаллыг алдах тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч түүнийг Монгол Улсын харьяат болгосон шийдвэрээ хүчингүй болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүүхдийн иргэний харьяалал өөрчлөгдөх

16 дугаар зүйл. Эцэг, эх хоёулаа буюу аль нэг нь Монгол Улсын харьяат болох тохиолдолд хүүхэд нь Монгол Улсын харьяат болох

1. Эцэг, эх нь хоёулаа Монгол Улсын харьяат болоход тэдний 16 нас хүрээгүй хүүхэд нь Монгол Улсын харьяат болно.

2. Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат болох тохиолдолд эцэг, эхийн хүсэлтээр тэдний 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат болж болно. Энэ тохиолдолд эцэг, эхийн бичгээр гаргасан үндэслэл бүхий тохиролцоо байна.

17 дугаар зүйл. Эцэг, эх хоёулаа буюу аль нэг нь Монгол Улсын харьяатаас гарах тохиолдолд тэдний хүүхдийг Монгол Улсын харьяатаас гаргахыг зөвшөөрөх

Эцэг, эх нь хоёулаа буюу аль нэг нь Монгол Улсын харьяатаас гарах тохиолдолд эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр гаргасан тэдний хүсэлтээр 16 нас хүрээгүй хүүхдийг нь Монгол Улсын харьяатаас гаргахыг зөвшөөрч болно.

18 дугаар зүйл. Хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөхөд түүний зөвшөөрлийг авах

16-18 хүртэл насны хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх тохиолдолд түүний бичгээр гаргасан зөвшөөрлийг авсан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Иргэний харьяаллын асуудлаархи төрийн байгууллагын эрх хэмжээ

19 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээ

Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд дор дурьдсан асуудлаар шийдвэр гаргана:

1/ гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгох;

2/ Монгол Улсын харьяатаас гаргах;

3/ Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох.

20 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ

1. Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдсон асуудлаар харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад Улсад оршин суугаа хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр бусад бичиг баримт, саналын хамт Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид өргөн барина.

2. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, иргэний харьяаллаа алдсан хүний нэгдсэн бүртгэлийг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

3. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг шийдвэрлэхэд тус улсын тагнуулын болон цагдаагийн төв байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ хуульд заасан журам, тус тусын чиг үүргийн дагуу оролцоно.

4. Тагнуулын төв байгууллага иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний талаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үүднээс дүгнэлт хийж, асуудлыг хэрхэн шийдвэрлүүлэхээр тодорхой санал гаргана.

5. Цагдаагийн төв байгууллага нь холбогдох албадаараа дамжуулан иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний иргэний бүртгэлийн талаар лавлагаа өгөх, бүртгэлд нэмэлт,

өөрчлөлт оруулах, түүнчлэн бусад асуудлаар санал дүгнэлт өгөх ажиллагаа тус тус явуулна.

6. Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь гадаад улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа мөн асуудлаар хүсэлт гаргасан хүний хувийн байдлыг тодорхойлж дүгнэлт гаргана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх журам

21 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах

1. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаархи хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргана.

2. Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, харьяатаас гарах тухай хүсэлт гаргагч энэ хуулийн 22 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар тогтоосон жагсаалтын дагуу зохих бичиг баримтыг бүрдүүлнэ.

3. Хэрэв өргөдөл гаргагч гэр бүлийн бусад гишүүний хамт Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарахыг хүсвэл өргөдлөө хамтран гаргаж болно.

4. Иргэнийхээ харьяадлыг өөрчилж буй эцэг буюу эх өргөдөлдөө 16 насанд хүрээгүй хүүхдийнхээ иргэний харьяаллыг өөрчлөх эсэх талаар бичсэн байна.

5. 16-18 нас хүрээгүй хүүхдийн Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаархи хүсэлтийг өөрийн нь зөвшөөрч гарын үсэг зурсны дагуу эцэг, эх, эсхүл түүний асран хамгаалагч буюу харгалзан дэмжигч нь гаргана.

22 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах журам

1. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, хэрэв гадаад улсад оршин суугаа бол Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, Монгол Улсын харьяатын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Ерөнхийлөгчид уламжилна.

2. Хүсэлтийг хүлээн авсан аймаг, нийслэлийн Засаг дарга уг хүний талаар тодорхойлолт, дүгнэлтийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас гаргуулан авна.

3. Хүсэлтийг хүлээн авсан аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг шалган тодорхой саналын хамт Монгол Улсын харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4. Монгол Улсын харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүний талаархи санал, дүгнэлтийг тагнуулын болон цагдаагийн төв байгууллагаас авсан байна.

5. Иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч, хянан хэлэлцэж, шийдвэр гаргах хугацаа зургаан сараас хэтрэхгүй байна.

6. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

23 дугаар зүйл. Иргэний харьяаллын асуудлаар дүгнэлт гаргах

1. Энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулж харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргана.

2. Иргэний харьяаллын асуудлаар гаргасан хүсэлтийн дагуу харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргахдаа хүсэлт гаргагчийн ашиг сонирхол, улсын үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, гаргасан өргөдлийн агуулга, харьяатын асуудлаар бусад байгууллагаас гаргасан тодорхойлолт болон санал, дүгнэлт түүнчлэн уг асуудлаар шийдвэр гаргахад ач холбогдол бүхий бусад баримт бичгийг тал бүрээс нь нягтлан үзэж, дүгнэлт өгнө. Дүгнэлтэд Монгол Улсын харьяат болгох, харьяатаас гаргах, иргэний харьяаллыг сэргээн тогтоох болон тэдгээрээс татгалзах үндэслэл, нөхцөлийг тодорхой зааж тусгасан байна.

3. Харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэний харьяаллын асуудлаар дүгнэлт гаргахад шаард-

лагатай баримт бичгийг төр, олон нийт, аж ахуйн аль ч байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авна.Эдгээр байгууллага, албан тушаалтан холбогдох баримт бичгийг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардсан хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Иргэний харьяаллын асуудлаар гарах шийдвэр

1. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллыг сэргээн тогтоолгох хүсэлтийг зөвшөөрөх тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг, татгалзах тохиолдолд захирамж гаргана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэний харьяаллын асуудлаар шийдвэр гаргаснаас хойш хагас жилийн дотор уг асуудлаар дахин гаргасан өргөдлийг хүлээн авахгүй.

25 дугаар зүйл. Харьяат болсон, харьяатаас гарсан тухай хугацааг тооцох

1. Монгол Улсын харьяат болгосон болон иргэний харьяаллыг сэргээн тогтоосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс хүсэлт гаргагчийг Монгол Улсын харьяат болсонд тооцно.

2. Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс хүсэлт гаргагчийг Монгол Улсын харьяатаас гарсанд тооцно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийг биелүүлэх байгууллага

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа хүний иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга, гадаад улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүний хувьд гарсан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох дипломат төлөөлөгчийн буюу консулын газар хариуцан биелүүлнэ.

2. Монгол Улсын харьяат болсон буюу иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон хүнд аймаг, нийслэлийн Засаг дарга Монгол

Улсын иргэний паспорт, холбогдох дипломат төлөөлөгчийн буюу консулын газар үндэсний гадаад паспорт олгоно. 16 насанд хүрээгүй хүүхдийн баримт бичигт Монгол Улсын харьяат байх эрхийн гухай тэмдэглэл хийнэ.

3. Монгол Улсын иргэний харьяаллаа алдсан тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүн Монгол Улсад оршин суух асуудлаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

27 дугаар зүйл. Иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

Иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийн биелэлтэд харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхий бусад байгууллагууд тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавина.

28 дугаар зүйл. Иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрт гомдол гаргах

Иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авахаас үндэсгүй татгалзсан, уг өргөдлийн шийдвэрлэх хугацааг годорхой шалтгаангүйгээр хэтрүүлсэн, сунгасан, хойшлуулсан, иргэний харьяаллын асуудлыг хянан хэлэлцэх болон мөнхүү асуудлаар гарсан шийдвэрийг биелүүлэх журмыг зөрчсөн тухай гомдлыг холбогдох дээд шатны нь байгууллагын албан тушаалтан болон шүүхэд гаргаж болно.

29 дүгээр зүйл. Харьяатын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Харьяатын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гүүгч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/иргэний харьяаллын асуудлыг хууль бусаар шийдвэрлүүлэх зорилгоор өөрийн болон бусад этгээдийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад хуурамч баримт бичиг бүрдүүлж ирүүлсэн этгээдийг 35000-50000 төгрөгөөр торгоно;

2/ иргэний харьяаллын асуудлаар гаргасан өргөдлийг энэ хуульд заасны дагуу хүлээн авч хянан, дүгнэлт гаргаж зохих журмын дагуу уламжлах үүрэг бүхий албан тушаалтан санаатайгаар хуурамч тодорхойлолт, дүгнэлт гаргасан бол буруутай этгээдийг 15000-50000 төгрөгөөр торгоно.

ЗО дугаар зүйл. Хуулийг дагаж мөрдөх

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 41 дүгээр зарлигаар батлсан "БНМАУ-ын харьяатын тухай хууль"-ийг харьяатын тухай Монгол Улсын хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДЭД ДАРГА **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь боловсролын тогтолцоо, үндсэн зарчим, агуулга боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх

хариуцлагыг тодорхойлж, иргэдийн сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Боловсролын тухай хууль, тогтоомж

1. Боловсролын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Боловсролын зорилго

Боловсролын зорилго нь иргэнийг бүх талаар нь хөгжүүлэн оюуны зохих чадавхитай, эрүүл чийрэг, шударга ёс, хуулийг дээдлэн сахидаг, эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, гоо зүйн мэдрэмж таашаалтай, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэнэ.

4 дүгээр зүйл. Боловсролын үндсэн зарчим, төрийн бодлого

1. Боловсролын үндсэн зарчим нь:

1/ Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт ёс заншил, шинжлэх ухаанд тулгуурлана;

2/ боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр олон хувилбартай, чөлөөтэй нээлттэй байна.

2. Боловсролын талаархи төрийн бодлого нь:

1/ боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;

2/ үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно;

3/ иргэдийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох нөхцөлөөр хангана;

4/ нийгэм иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдал, ардчилсан ёсонд харш, тэдгээрт сөрөг нөлөө бүхий сургалт зохион байгуулахыг хориглоно;

5/ иргэдэд сурч боловсроход нь адил тэгш эрх эдлүүлнэ;

6/ эмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана.

5 дугаар зүйл. Иргэдийн сурч боловсрох үндсэн эрх, үүрэг

1. Монгол Улсын иргэн бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл журмын дагуу төлбөргүй буюу төлбөртэйгээр сурч эзэмших ажил эрхлэхийн зэрэгцээ суралцах эрхтэй.

2. Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй.

6 дугаар зүйл. Боловсролын тогтолцоо

1. Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ.

2. Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтооно. Албан бус боловсролын агуулга чөлөөтэй байна.

7 дугаар зүйл. Боловсрол эзэмших арга хэлбэр

Иргэд боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно. Албан сургалт нь өдөр, орой, эчнээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно.

8 дугаар зүйл. Боловсролын баримт бичиг

1. Боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшин мэргэжлийг нотлох албан ёсны баталгаа мөн.

2. Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх, диплом/-ийг бүрдүүлэх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож, эрх бүхий байгууллага зохих түвшний боловсрол эзэмшсэн иргэдэд ямар арга, хэлбэрээр эзэмшсэнийг харгалзахгүйгээр олгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Боловсролын агуулга, стандарт

9 дүгээр зүйл. Боловсролын агуулга

Боловсролын агуулга нь суралцагчдын нас бие, сэтгэхүйн онцлог, авьяас сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээнд шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

10 дугаар зүйл. Боловсролын агуулгын түвшин, стандарт

1. Боловсролын агуулгыг түвшингээр нь сургуулийн өмнөх

болон бага, дунд, дээд гэж ангилна. Боловсролын агуулгыг бага болон дунд, дээд боловсролын тухай хуулиар тус тус тодорхойлж, стандартаар нарийвчлан тогтооно.

2. Боловсролын стандарт нь зохих түвшин /бага, дунд, дээд/-д суралцагчид зайлшгүй эзэмшсэн байх боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тус тус тодорхойлно.

3. Боловсролын стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, стандартчиллын төв байгууллага батална. Боловсролын стандартыг боловсруулахдаа мэргэжлийн олон нийтийн байгууллага, шинжээч нарыг оролцуулна.

4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр боловсролын стандартыг өөрчлөхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Боловсролын байгууллага

11 дүгээр зүйл. Боловсролын байгууллагын тогтолцоо

1. Боловсролын байгууллагын тогтолцоо нь боловсрол эзэмшүүлэх байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас бүрдэнэ.

2. Боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус байгууллага байна.

12 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн сургууль байна.

2. Цэцэрлэг нь хүүхдэд бага сургуульд орох хүртэлх насанд нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хүмүүжил-сургалтын байгууллага мөн. Цэцэрлэг нь ердийн, асрамжийн, сувиллын зэрэг хэв шинжтэй байна.

3. Ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалт-хүмүүжлийн байгууллага мөн.

Ерөнхий боловсролын сургууль нь бага, дунд гэсэн хэв шинж-

тэй, ердийн, тусгай, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалттай байна.

4. Техникийн болон мэргэжлийн сургууль нь суралцагчдад техник, технологи, мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол эзэмшүүлэх байгууллага мөн. Техникийн болон мэргэжлийн сургууль нь сургалт үйлдвэрлэлийн буюу үйлдвэр сургалтын төв хэлбэртэй байж болно.

13 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллага

Их, дээд сургууль, коллеж нь суралцагчдад дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн бөгөөд эрдэм шинжилгээ-сургалтын, сургалт-эрдэм шинжилгээний, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна.

Их сургууль нь сонгодог болон төрөлжсөн хэв шинжтэй байна.

14 дүгээр зүйл. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

1. Боловсролын хөгжил, агуулга, сургалтын арга технологийн шинжлэх ухааны үндсийг судлан боловсруулах, бүх шатны сургууль, сургалт явуулж буй бусад байгууллага, иргэдийг онол, арга зүй, судалгаа шинжилгээний мэдээллээр хангах, боловсролын удирдах ажилтан, багш нарын мэргэжил дээшлүүлэх, аймаг, нийслэлийн боловсролын төвийг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага байна.

2. Аймаг, нийслэлийн боловсролын төв нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн удирдах ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжил дээшлүүлэх, тэднийг онол арга зүйн мэдээллээр хангах, судалгаа шинжилгээ эрхлэх, албан бус арга замаар боловсрол, мэргэжил эзэмших, дээшлүүлэхэд нь иргэдэд туслах, бие даан боловсролоо дээшлүүлж байгаа иргэдийг сурах бичиг гарын авлага, шаардлагатай бусад мэдээллээр хангах үүрэг бүхий эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага мөн.

3. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага болон аймаг, нийслэлийн боловсролын төв нь түшиц цэцэрлэг, багa, дунд сургуультай байж болно.

4. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллагын дүрмийг Засгийн газар, аймаг, нийслэлийн боловсролын төвийн ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

15 дугаар зүйл. Боловсрол эзэмшүүлэх бусад байгууллага

1. Сургуулиас гадуур сургалт-хүмүүжлийн ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, хууль зүй, байгаль орчин, гоо зүй, эрүүл мэнд, гэр бүлийн болон ахуйн хүрээний асуудлаар түгээмэл хөтөлбөрийн дагуу хүүхэд насанд хүрэгчдэд нийтийн боловсрол эзэмшүүлэх, боловсрол мэргэжлээ дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2. Иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжил эзэмшүүлэх, дээшлүүлэх, мэргэжлийн түр сургалтыг бүх шатны сургууль, бусад аж ахуйн нэгж, байгууллага иргэд эрхэлж болно.

3. Мэргэжлийн түр сургалтаар эзэмшүүлэх мэргэжлийн жагсаалтыг Засгийн газар батлж, түр сургалт зохион байгуулах, зөвшөөрөл олгох журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

4. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн мэдэлд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тогтвортой эрхлэх бие даасан нэгжийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу байгуулан ажиллуулж болно.

5. Энэ зүйлийн 1, 2, 4-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс явуулж байгаа боловсрол, сургалтын ажлыг сургалтын байгууллагын үйл ажиллагаатай адилтгаж үзнэ.

6. Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна.

16 дугаар зүйл. Сургалтын байгууллага байгуулах

1. Сургалтын байгууллагыг зориулалтын барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, багшлах боловсон хүчнээр хангагдсан нөхцөлд өмчийн аль ч хэлбэрт үндэслэн үүсгэн байгуулж болно. Сургалтын байгууллага байгуулахдаа сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ авна.

2. Сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллага

1. Их, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн улсын чанартай сургууль байгуулахад боловсролын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн орон нутгийн чанартай сургууль байгуулахад аймаг, нийслэлийн Засаг дарга; цэцэрлэг байгуулахад сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно.

2. Сургалтын байгууллагыг өөрчлөх, шинэ мэргэжлээр сургалт, явуулах тусгай зөвшөөрлийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага олгоно.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх

1. Сургалтын байгууллага үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

1/ сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;

2/ сургалтын байгууллагын дүрэм;

3/ сургалтын төлөвлөгөө;

4/ мэргэжлийн тодорхойлолт;

5/ багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, эрдмийн зэрэг, цолын байдал;

6/ сургалт явуулах барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;

7/ санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа

8/ магадлан-итгэмжлэх байгууллагын дүгнэлт;

9/ сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцооны тухай танилцуулга.

2. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь үүсгэн байгуулагчийн ирүүлсэн баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

3. Үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрөл авснаас хойш 60 хоногийн дотор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичиг болон тусгай зөвшөөрлийг бүртгэх байгууллагад ирүүлнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичиг болон өргөдлийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.

5. Хэрэв тусгай зөвшөөрөл аваагүй буюу түүнийг энэ хуульд заасан журам зөрчиж авсан, бүртгүүлэхэд шаардагдах бусад баримт бичгийн бүрдэл дутуу бол бүртгэх байгууллага улсын

бүртгэлд бүртгэхээс татгалзаж, баримт бичгийг 30 хоногийн дотор үүсгэн байгуулагчид буцаана.

6. Сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

7. Монгол Улсад гадаадын, гадаадад Монгол улсын сургалтын байгууллага хамтарсан буюу дагнасан хэлбэрээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, асуудлыг энэ хуульд заасан журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа

1. Тусгай зөвшөөрлийн хугацааг сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд, дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан тогтооно.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд тухайн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

3. Хугацаа сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 6 сарын өмнө гаргана.

4. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага түүний хугацааг сунгах эсэхийг магадлан-итгэмжлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

1. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага дараахь үндэслэлээр үүнийг хүчингүй болгоно:

1/ тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон;

2/ боловсролын стандартыг зөрчсөн;

3/ нийгэм, иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд өөр нөлөө үзүүлж болзошгүй сургалт зохион байгуулсан болохь тогтоогдсон;

4/ улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 6 сарын дотор үйл жиллагаагаа явуулж эхлээгүй буюу үйл ажиллагаа нь 3 сараас дээш хугацаагаар тасалдсан;

5/ сургалтын байгууллага татан буугдсан;

6/ хуульд заасан бусад үндэслэл.

21 дүгээр зүйл. Сургалтын байгууллагыг татан буулгах

1. Сургалтын байгууллагыг дор дурдсан нөхцөлд татан буулгана:

1/ татан буулгах тухай сургалтын байгууллагын саналыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ай-

маг, нийслэлийн Засаг дарга зөвшөөрсөн;

2/ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

3/ татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

2. Сургалтын байгууллагыг татан буулгасан тухай шийдвэр гарснаас хойш 45 хоногийн дотор сургалтын байгууллагын удирдлага бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

3. Тухайн сургалтын байгууллагыг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

4. Сургалтын байгууллага татан буугдсантай холбоотойгоор үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэж, суралцагчдад учирсан хохирлыг арилгуулна.

22 дугаар зүйл. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага

1. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь бага, дунд, дээд боловсролын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний ажилд магадлан шинжилгээ хийж, сургалтыг эрхлэх шаардлага хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах эрхтэй, үйл ажиллагааныхаа орлогоор бүрэн санхүүжиж бие даан ажиллах хуулийн этгээд байна.

2. Магадлан-итгэмжлэх байгууллагад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон шинжээчид ажиллана. Шинжээчид нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дадлага, туршлагатай мэргэшсэн хүмүүс байна. Шинжээчдийг боловсрол, мэргэжлийн олон нийтийн болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаас нэр дэвшүүлж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулж, шинжээчийн эрх олгоно.

3. Магадлан-итгэмжлэх байгууллагын дүрэм, магадлан итгэмжлэх ажлын үнэлгээ, шинжээчийг сонгон шалгаруулах болзол, журмыг Засгийн газар тогтооно.

4. Магадлан-итгэмжлэх байгууллага магадлан шинжилгээ хийх ажлыг гэрээний үндсэн дээр явуулах бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргаснаас учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Боловсролын удирдлага

23 дугаар зүйл. Боловсролын удирдлагын тогтолцоо

1. Боловсролын удирдлагын тогтолцоо нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, сургалтын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрдэнэ.

2. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын төв нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас боловсролын хэргийг удирдах үйл ажиллагааг онол, арга зүйн судалгаа, шинжилгээний мэдээллээр хангах үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ боловсролын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

2/ сургуулийн өмнөх насны хүүхэд болон бүх шатны сургуульд суралцагчдыг сургаж хүмүүжүүлэх, иргэдэд боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, мэргэжлийн болон эрдмийн зэрэг, цолтой боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлын оновчтой тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх;

3/иргэдэд албан болон албан бус боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, тэдний боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;

4/ иргэдийн авьяас сонирхол, нийгмийн хэрэгцээ, шинжлэх ухаан, технологийн шаардлагад нийцүүлэн боловсролын агуулга, стандарт, удирдлагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;

5/боловсролын удирдах ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгчдийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлийн үндсэн дээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг

холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангах;

6/ цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг хүмүүжил, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн зориулалт бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгээр хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

7/ боловсролын төлөвлөлт, мэдээлэл, санхүүжилтэд мөрдөж буй зарчим, арга барил, журам, дүрэм, норм, нормативыг захзээлийн эдийн засгийн онцлогтой уялдуулан өөрчлөн боловсронгуй болгох;

8/ боловсролын стандарт, нормативын хэрэгжилтэд хяналт тавих, тогтоосон журмын дагуу сургалтын байгууллагыг аттестатчилах;

9/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийнх, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн улсын чанартай сургууль байгуулах, татан буулгах, их, дээд сургууль, коллежийн удирдлагыг томилох, өөрчлөх;

10/ их, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн сургуульд сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг зогсоох ажлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

11/ төрийнхөөс бусад өмчийн боловсролын байгууллагад хуульд заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

12/ боловсролын гадаад харилцааг өргөжүүлж, үр өгөөжийг дээшлүүлэх;

13/ хуульд заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ боловсролын хэргийг удирдах асуудлаар тухайн шатны болон доод шатны Засаг даргын тайланг хэлэлцэж, чиглэл, өгөх;

2/ орон нутгийн өмчийн сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

3/ зохих норматив үндэслэн боловсролын байгууллагын төсвийг баталж, түүний гүйцэтгэл, зориулалтад хяналт тавих;

4/ олон нийтийн санаачлагаар тухайн нутаг дэвсгэртээ байгуулагдсан боловсрол хөгжүүлэх сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

5/ хуульд заасан бусад бүрэн эрх.

26 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ боловсролын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/ иргэдэд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, иргэдэд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

3/ орон нутгийн өмчийн сургалтын байгууллага байгуулах асуудлыг энэ хуульд заасан журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх, батлагдсан төсвийг хуваарилан олгох, өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэдгээрийн хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах;

4/ өмчийн бусад хэлбэрийн боловсролын байгууллагад хууль, тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

5/ энэ хуульд заасан журмын дагуу сургалтын байгууллагад тусгай зөвшөөрөл гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх;

6/ багш, сурган хүмүүжүүлэгч, суралцагчдын нийгмийн баталгааг сайжруулах, тэдний хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, бусад дэмжлэг үзүүлэх;

7/ боловсролын байгууллагын үйл ажиллагаанд захиргааны хяналт тавих;

8/ боловсролын асуудлаар мэдээ, мэдээллийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

9/ хуульд заасан бусад бүрэн эрх.

27 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

Сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ боловсролын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/ хүүхдэд сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх, иргэдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах;

3/ орон нутгийн өмчийн сургалтын байгууллага байгуулах асуудлыг энэ хуульд заасан журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын бага, дунд сургуулийн захирал, эрхлэгчийг томилох, чөлөөлөх;

4/ ерөнхий боловсролын бүрэн бус дунд сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулийн захирлыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;

5/ энэ хуульд заасан журмын дагуу цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх;

6/ орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг тогтоох;

7/ батлагдсан төсвийг сургалтын байгууллагад хуваарилан хуульд заасан хугацаанд нь олгох, өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;

8/ өмчийн бусад хэлбэрийн боловсролын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг туслалцаа үзүүлэх;

9/ багш, сурган хүмүүжүүлэгч, суралцагчдын нийгмийн баталгааг сайжруулах, тэдний ажлыг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах, бусад дэмжлэг үзүүлэх, энэ асуудлаар холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

10/ боловсролын асуудлаар мэдээ, мэдээллийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу гаргаж байх;

11/ боловсролын хууль тогтоомж зөрчигчдөд хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэх;

12/ хуульд заасан бусад бүрэн эрх.

28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийнхөө хүүхдийг хамруулах;

2/ иргэдийнхээ боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3/ суурь боловсрол эзэмшээгүй иргэдэд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах;

4/ боловсролын хууль, тогтоомж зөрчигчдөд энэ хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэх.

29 дүгээр зүйл. Боловсролын байгууллагын удирдлага

1. Төрийн өмчид үндэслэсэн боловсролын байгууллагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл хуулиар эрх олгосон байгууллагаас томилсон захирал, дарга /эрхлэгч/ удирдана.

2. Өмчийн бусад хэлбэрийн боловсролын байгууллагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний дагуу үүсгэн байгуулагчийн томилсон захирал, дарга /эрхлэгч/ удирдана.

30 дугаар зүйл. Сургалтын байгууллагын өөрийн удирдлага

1. Сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг цэцэрлэг, бүх шатны сургуулийн дэргэдэх удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

2. Удирдах зөвлөл нь тухайн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд туслах, хяналт тавих үндсэн үүрэгтэй, багш, сурган хүмүүжүүлэгч, суралцагч, эцэг эх, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөлтэй байна.

3. Удирдах зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

31 дүгээр зүйл. Боловсролын захиргааны хяналт

1. Боловсролын захиргааны хяналтыг боловсролын хяналтын алба, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Боловсролын захиргааны хяналтын алба нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

2. Боловсролын захиргааны хяналтын алба нь боловсролын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, бүх шатны боловсролын стандарт, сургалт хүмүүжлийн ажилтай холбогдсон норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавина.

3. Боловсролын захиргааны хяналтын албанд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэл, улсын байцаагч ажиллана.

4. Боловсролын захиргааны хяналтын аймаг, нийслэлийн улсын байцаагчаар Засаг даргын Тамгын газрын боловсролын асуудал эрхэлсэн ажилтныг хавсруулан ажиллуулж болно. Аймаг, нийслэлийн улсын байцаагчийг боловсролын захиргааны хяналтын албаны ерөнхий байцаагчтай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

5. Боловсролын захиргааны хяналтын албаны дүрмийг Засгийн газар батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Боловсролын эдийн засаг

32 дугаар зүйл. Боловсролын төлөвлөлт, мэдээлэл

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагын оролцоотойгоор боловсролын хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан төлөвлөгөө, арга зүйг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүрэг боловсролын ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй байна.

3. Цэцэрлэг, сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага тогтоогдсон норм, нормативыг үндэслэн зориулалтот төлөвлөгөөтэй ажиллана.

4. Боловсролын байгууллага нь хууль, тогтоомжид заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргах боловсролын дээд шатны байгууллагад тайлагнана.

33 дугаар зүйл. Боловсролын санхүүжилт

1. Боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагын хангах хэмжээний төсвийг Улсын Их Хурал, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал батална. Боловсролын санхүүжилтэд улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зориулна.

2. Боловсролын байгууллага нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, боловсролын байгууллагын өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

3. Боловсролын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилчид, суралцагчдынхаа нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын нь дагуу шууд захиран зарцуулах эрхийг боловсролын тухайн байгууллагын захирал, дарга /эрхлэгч/ эдэлнэ.

4. Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төвлөрсөн болон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хэмжээг багасгахыг хориглоно.

5. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын төв нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, судалгааны ажлын төслийн зардлаар санхүүжина.

6. Суралцагчдад хөнгөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор сургалтын төрийн сан байгуулж ажиллуулна. Энэ сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар тогтооно.

7. Олон нийтийн үүсгэл санаачлагаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт боловсрол хөгжүүлэх сан байгуулж болно. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс энэ санд оруулсан хандивыг татвар ногдуулах орлогоос чөлөөлнө.

8. Боловсролд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

34 дүгээр зүйл. Төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилт

1. Төрийн өмчийн сургалтын байгууллагыг норматив зардлаар санхүүжүүлэх зарчим баримтлах бөгөөд их, дээд сургууль, коллежийг норматив тогтмол зардал болон сургалтын хөтөлбөрийн зардлын хэмжээгээр улсын төвлөрсөн төсвөөс; бага, дунд сургуулийг норматив тогтмол зардал болон нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээгээр орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

2. Нэг суралцагчид бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох зардлын норматив болон дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын

хөтөлбөрийн зардлын хэмжээг Засгийн газар нийтлэг ба сургуулийн байршил, хэв шинжээр хичээлийн жил бүр тогтооно.

3. Төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь дор дурдсан орлогоос бүрдэнэ:

1/ цэцэрлэгт орон нутгийн төсөв, эцэг, эх, асран хамгаалагчаас өгөх төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос;

2/ ерөнхий боловсролын сургуульд орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлогоос; дотуур байрны сурагчдын эцэг, эх, асран хамгаалагчаас өгөх төлбөрөөс;

3/ техникийн болон мэргэжлийн дунд сургуульд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос;

4/ их, дээд сургууль, коллежид улсын төвлөрсөн төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөвт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлогоос.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрт улсын төвлөрсөн буюу орон нутгийн төсвийн хөрөнгө болон бусад орлогын зохистой харьцааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Сангийн яамны саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно.

35 дугаар зүйл. Өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагын санхүүжилт

1. Өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, өөрийн үйл ажиллагааны болон бусад орлогоос бүрдэнэ.

2. Өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, тэдгээрийг багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

36 дугаар зүйл. Боловсролын материаллаг бааз, нийгмийн баталгаа

1. Сургалтын байгууллагын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, модон болон зөөлөн эдлэл нь багш, ажиллагчид суралцагчдын хөдөлмөрийн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

2. Сургалтын зориулалттай машин механизм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мал, эдэлбэр газарт татвар, төлбөр ногдуулахгүй.

3. Боловсролын байгууллага өөрийн харъяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

4. Цэцэрлэг, сургуулийн барилга, байгууламж, модон болон зөөлөн эдлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйлийн норм, нормативыг холбогдох хууль, тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран баталж мөрдүүлнэ.

5. сургалтын байгууллагыг зориулалтын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурах бичгээр хангах ажлыг үүсгэн байгуулагч хариуцан гүйцэтгэнэ.

6. Сургалтын байгууллагын барилга, байгууламжийг зориулалтын дагуу ашиглана.

7. Багш дор дурдсан баталгаагаар хангагдана:

1/ хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийнхээ онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр, тусламж авах;

2/ багшийн ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 21 өдөр байна. Хөдөлмөрийнх нь онцлогийг харгалзан багшид ажлын 27 өдрийн нэмэгдэл амралт олгоно. Хөдөлмөрийн хуульд заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт багшид хамаарахгүй;

3/ багшид мэргэжлийн болон эрдмийн зэрэг, цолны, ур чадварын болон бусад нэмэгдэл хөлс олгоно;

4/ орон сууц барих буюу худалдан авахад хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлэх;

5/ 25-аас доошгүй жил багшилсан багшид тэтгэвэрт гарахад нь нэг хичээлийн жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгоно;

6/ тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд багшид нэмэгдэл цалин, урамшил, бусад дэмжлэг үзүүлэх;

7/ хуульд заасан бусад баталгаа.

8. Суралцагч дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

1/ оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин буюу амьжиргааны түвшин доогуур суралцагчдыг дотуур байраар хангах;

2/ ерөнхий боловсролын бага, дунд сургуулийн дотуур байрны сурагчдыг төсөвт зардалд болон эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн орлогод багтаан хоол хүнс, зайлшгүй шаардлагатай ариун цэврийн бараагаар хангах. Өрхийн орлого, амьжиргааны түвшинг харгалзан тухайн сурагчийн дотуур байрны хоолны төлбөрөөс сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр хөнгөлөх, чөлөөлөх;

3/ сурагчдыг хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтаар сургуульдаа ирэх, гэртээ буцахдаа эцэг, эх, асран хамгаалагчийн зардал, хүсэлтээр унаагаар үйлчлэх арга хэмжээг сургуулийн захиргаа, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж болно;

4/ оршин суудаг газраасаа өөр аймаг, хотод суралцаж байгаа оюутны жилд 2 удаа орон нутагтаа ирж, очих зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөх;

5/ нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлыг тухайн нутгийн захиргааны байгууллагаас тогтоосон журмын дагуу хөнгөлөх, чөлөөлөх;

6/ суралцагчдад Засгийн газраас тогтоосон журмын дагуу эмнэлэг, нийтийн хоол, соёл, урлагийн болон ахуйн үйлчилгээгээр үйлчлэх зардлын хөнгөлөлт үзүүлэх;

7/ суралцагчдын онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, бие эрхтний согогтой, оюуны хомсдолтой суралцагчдыг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах;

8/ боловсролын удирдлагын болон багш мэргэжлээр сурч байгаа оюутанд төрийн сургалтын сангаас тэтгэлэг олгох;

9/ хуульд заасан бусад баталгаа.

9. Багш, суралцагчдад үзүүлэх нийгмийн халамж, хөнгөлөлт, нөхөх төлбөр, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Боловсролын харилцаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг

37 дугаар зүйл. Багш, сурган хүмүүжүүлэгчдийн эрх, үүрэг

1. Багш дор дурдсан эрхтэй:

1/ сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;

2/ сургалт-хүмүүжлийн ажилдаа шинжлэх ухааны арга барил, боловсролын стандартад нийцсэн сурах бичиг, сургалтын материалыг чөлөөтэй сонгон хэрэглэх;

3/ сургалт- хүмүүжлийн асуудлаар суралцагчид болон тэдний эцэг, эх, асран хамгаалагчдад шаардлага тавих, зөвлөлгөө өгөх;

4/ суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, тэдний авьяас, бие сэтгэцийн хөгжилтөд тодорхойлолт өгөх;

5/ суралцагчдыг сонгон суралцуулах, гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах;

6/судалгаа шинжилгээний ажил хийх, багшийн мэргэжлийн болон эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжлийн цол хүртэх;

7/ хүүхдийн эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон эцэг, эх, асран хамгаалагчдын талаар насанд хүрээгүй суралцагчаа төлөөлөн зохих байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

8/ үндсэн ажлын чөлөөт цагаар мэргэжил, сонирхлын дагуу бусад байгууллагад гэрээгээр ажиллах.

2. Багш дор дурдсан үүрэгтэй:

1/багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих;

2/ сургалт-хүмүүжлийн ажлыг амьдрал, үйлдвэрлэлтэй уялдуулан шинжлэх ухааны үндэстэй явуулах;

3/ онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх;

4/суралцагчдад бие даан боловсрол, мэргэжил эзэмших чадвар олгох, амьдрах арга ухаанд сургах;

5/хариуцсан ангийн суралцагчдын эрүүл мэндэд анхаарал тавих.

38 дугаар зүйл. Суралцагчийн эрх үүрэг

1. Суралцагчид дор дурдсан эрхтэй:

1/ суралцах нөхцөл бололцоогоор хангуулах;

2/ сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах;

3/ сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих;

4/суралцах хугацаа боломжийн талаар санал тавьж, шийдвэрлүүлэх, хэд хэдэн мэргэжил эзэмших;

5/ хууль тогтоомжид заасны дагуу тусламж, авах, хөнгөлөлт эдлэх;

6/ сургууль төгсөгчид гэрээнд өөрөөр заагаагүй бол эзэмшсэн буюу сонирхсон мэргэжлийн дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр чөлөөтэй сонгох.

2. Суралцагчид дор дурдсан үүрэгтэй:

1/ сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;

2/ багш, сурган хүмүүжүүлэгчдээс тавьсан шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх сургуулийн дотоод журмыг хүндэтгэн сахих.

39 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

1. Эцэг, эх, асран хамгаалагч дор дурдсан эрхтэй:

1/ хүүхдээ аль сургуульд ямар хэлбэрээр суралцуулахыг сонгох;

2/ боловсролын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;

3/ хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаар сургууль, багшаас гаргасан тодорхойлолттой танилцах.

2. Эцэг, эх, асран хамгаалагч дор дурдсан үүрэгтэй:

1/ хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх, боловсрол эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах, ажил мэргэжлээ сонгоход нь хүүхэддээ туслах;

2/ сургалт, хүмүүжлийн хувийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургууль, багшаас тавьсан сурган хүмүүжүүлэх шаардлагыг биелүүлэх;

3/ хүүхэддээ 17 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшүүлэх, суралцах хүсэл сонирхлыг нь хааж боогдуулахгүй байх;

4/ хүүхдийг гэр бүлийн орчинд сурган хүмүүжүүлэх арга барил эзэмших.

40 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

1. Аж ахуйн нэгж, байгууллага дор дурдсан эрхтэй:

1/ мэргэжилтэн бэлтгүүлэх, ажиллагчдын мэргэшлийг дээшлүүлэх захиалга өгөх, гэрээ байгуулах;

2/ гэрээ, захиалгаар суралцагчдын талаар санал гаргах, шаардлага тавих;

3/ хууль тогтоомжийн дагуу сургалт зохион байгуулах;

4/ боловсролын байгууллагыг бэхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, ивээн тэтгэснийхээ төлөө зохих хөнгөлөлт эдлэх.

2. Аж ахуйн нэгж, байгууллага дор дурдсан үүрэгтэй:

1/ зохих гэрээний дагуу суралцагчдыг хүлээн авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл бололцоогоор хангах;

2/ гэрээ, захиалгаар суралцагчдын сургалтын зардлыг төлөх;

3/ажиллагчдын сурч боловсрох, хүүхдээ сургаж хүмүүжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

41 дүгээр зүйл. Боловсролын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Иргэдэд суурь боловсрол олгох ажлыг хангалттай зохион байгуулсан, зохих арга хэмжээ аваагүй төрийн захиргааны болон боловсролын байгууллагын гэм буруутай албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

2. Боловсролын тухай хууль, тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

1/ энэ хуулийн 8 дугаар зүйлийг зөрчиж боловсролын баримт бичгийг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн гэм буруутай этгээдийг 10000-25000 төгрөгөөр торгож, хуурамч баримт бичгийг хураах;

2/ энэ хуулийн 36 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг зөрчсөн бол буруутай албан тушаалтныг 30000-40000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан үүргийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол 10000-25000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн бол 25000-50000 төгрөгөөр торгох;

5/ хууль тогтоомжид нийцүүлэн ажил үүргээ гүйцэтгэхэд нь багшид санаатайгаар саад учруулсан, багшийн нэр хүндийг гутаан доромжилсон этгээдийг шүүх 5000-25000 төгрөгөөр торгох;

6/ тусгай зөвшөөрөлгүйгээр сургалт-хүмүүжлийн ажил эрхэлсэн гэм буруутай этгээдийг 20000-50000 төгрөгөөр торгох;

7/ сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй үйл ажиллагаа явуулсан гэм буруутай этгээдийг 40000-50000 төгрөгөөр торгох;

8/ сургалтын үйл ажиллагаанаас өөр төрлийн үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн бол олсон орлогыг хураах, сургалтын байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийтгэлийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, боловсролын хяналтын улсын байцаагч ногдуулна.

42 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэдэд дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хууль тогтоомж

1. Дээд боловсролын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Дээд боловсролын зорилго

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэдэд дээд боловсрол эзэмшүүлэхэд чиглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын агуулга

4 дүгээр зүйл. Дээд боловсролын агуулга

1. Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, иргэний өндөр соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

2. Дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулга нь дор дурдсан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

1/ ерөнхий суурь хэсгийн агуулга суралцагчдад зайлшгүй мэдвэл зохих тодорхой шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;

2/ мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, дадал, шинжлэх ухааны үзэл бодол төлөвшүүлэх;

3/ мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагчдын тэдний авьяас сонирхол, нийгмийн болон захиалагчийн хэрэгцээнд нийцүүлэн тухайн мэргэжлээр сонгон мэргэшүүлэх.

3. Дээд боловсролын агуулга нь кредит цагийн хэмжээгээр ялгагдах боловсролын зэрэг /дипломын, бакалаврын, магистрын/-ийн, эрдмийн зэрэг /дэд доктор, доктор/- ийн [illegible]

тай байна. "Кредит цаг" гэж дээд боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгжийг хэлнэ. Энэ нь дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын үндэс мөн.

4. Дээд боловсролын агуулгын кредит цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон мэргэжлийн байгууллага тогтооно.

5 дугаар зүйл. Дээд боловсрол эзэмшигчдэд олгох баримт бичиг

1. Дээд боловсролын тодорхой шатны агуулгыг эзэмшигчдэд түүнийг нь гэрчлэн нотолсон үнэмлэх, дипломыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллага олгоно.

2. Гадаад оронтой боловсролын баримт бичиг харилцан зөвшөөрөлцөх асуудлыг магадлан-итгэмжлэх байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын байгууллага

6 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллага

1. Дээд боловсролын байгууллага нь их, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байна.

2. Их сургууль нь бакалаврын, магистрын боловсрол эзэмшүүлж, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх, эрдэм шинжилгээ-сургалт, сургалт-эрдэм шинжилгээ, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн байгууллага мөн. Их сургууль нь сонгодог болон төрөлжсөн хэв шинжтэй байна.

3. Дээд сургууль бакалаврын болон магистрын боловсрол эзэмшүүлэх сургалт-шинжилгээний байгууллага мөн. Дээд сургууль Их сургуулийн бүрэлдэхүүнд болон харьяалалд байж болно.

4. Коллеж нь дипломын болон бакалаврын шатны боловсрол эзэмшүүлэх сургалт-үйлдвэрлэлийн байгууллага мөн. Коллеж нь их, дээд сургуулийн бүрэлдэхүүнд болон харьяалалд байж болно.

5. Дээд боловсролын байгууллагын ангиллыг магадлан-итгэмжлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

7 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

1. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Дээд боловсролын байгууллага нь эрдэм шинжилгээний хүрээлэн, дадлагын газар, номын сантай байхаас гадна факультет, салбар, соёл-спортын төв, туршилт-дадлагын газар, судалгааны төв, хэвлэл-мэдээллийн алба зэрэг нэгжтэй байж болно.

2. Их сургууль нь бүрэлдэхүүндээ буюу харьяалалдаа эрдэм шинжилгээний хүрээлэн, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн сургууль, эрдэм шинжилгээ-сургалтын төв, гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын дунд сургууль буюу анги, бүлэгтэй байж болно. Ерөнхий боловсролын дунд сургууль буюу анги, бүлэг байгуулахдаа боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч үйлчлэх хүрээндээ зохион байгуулна.

3. Дээд сургууль, коллеж нь бүрэлдэхүүндээ буюу харьяалалдаа сургалт-эрдэм шинжилгээний төв, техникийн болон мэргэжлийн сургуультай байх бөгөөд зарим мэргэжлээр шаталсан сургалт зохион байгуулж болно.

4. Их, дээд сургууль, коллежид харьяалагдах боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага нь бие даасан хуулийн этгээд байна.

5. Дээд боловсролын байгууллага нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор эдгээр нэгжүүдийн нэгдэл хэлбэрээр зохион байгуулагдаж болно.

6. Дээд боловсролын байгууллага нь сургалт-эрдэм шинжилгээний зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, туслах аж ахуйтай байж болно.

7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр тодорхой аж ахуйн нэгж, байгууллагыг суралцагчдын сургалт-эрдэм шинжилгээ, дадлагын бааз болгож болно.

8 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагыг байгуулах, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах

1. Дээд боловсролын байгууллагыг Боловсролын тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.

2. Сонгодог их сургуулийг байгуулах, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

3. Төрийн өмчийн төрөлжсөн их, дээд сургууль, коллежийг байгуулах, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

4. Өмчийн бусад хэлбэрт үндэслэсэн их, дээд сургууль, коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлийг үндэслэн үүсгэн байгуулагч шийдвэрлэнэ.

5. Сургууль татан буугдсан нөхцөлд оюутны мэдлэг, чадварыг шалган тогтоох замаар адил мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг татан буугдсан сургууль, дээд боловсролын бусад байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Өөр сургуульд шилжин суралцах оюутан анги ухарч суралцах нөхцөлд гарах зардлыг татан буугдсан сургууль хариуцна.

6. Улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авааг үй нөхцөлд оюутан элсүүлэх, сургалтын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Дээд боловсролын сургалтын зохион байгуулалт

9 дүгээр зүйл. Их, дээд сургууль, коллежийн элсэлт

1. Их, дээд сургууль, коллежид бүрэн дунд түүнээс дээш боловсролтой хүмүүсийг элсүүлнэ.

2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн захиалга, их, дээд сургууль, коллежийн саналыг үндэслэн их, дээд сургууль, коллежийн тухайн жилд элсүүлэх элсэгчдийн тоо, сургах мэргэжлийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3. Их, дээд сургууль, коллежид оюутан, магистрант, аспирант, докторант элсүүлэх үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга зарчимд үндэслэнэ.

10 дугаар зүйл. Их, дээд сургууль, коллежийн сургалтын зохион байгуулалт

1. Их, дээд сургууль, коллежийн сургалт нь өдөр, орой эчнээ, зайнаас сургах болон экстернат хэлбэртэй байж болно.

2. Их, дээд сургууль, коллежийн өдөр, оройн сургалтын хичээлийн жил нь 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ.

3. Нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, байгалийн болон нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлд хичээлийн эхлэх хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрчилж болно.

4. Их, дээд сургууль, коллежийн сургалт нь мэргэжил бүрээр боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу явагдана. Сургалтын төлөвлөгөөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн сургуулийн захирал батална.

5. Их, дээд сургууль, коллежийн сургалтын зохион байгуулалт, үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөр, дүрмийг сургуулийн эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн захирал батална. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт нь 3, бакалаврын сургалт нь 4, хүн, малын их эмч 5-6, магистрын сургалт нь 1, 5, эрдмийн зэрэг /дэд доктор, доктор/-ийн сургалт нь 2-оос доошгүй жилийн хугацаатай байна.

6. Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон шалгалтын хугацааг сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулна.

11 дүгээр зүйл. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг үнэлж дүгнэх

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тооцсон журмын дагуу үнэлж дүгнэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын удирдлага

12 дугаар зүйл. Дээд боловсролын удирдлага

1. Дээд боловсролын хэргийг удирдах үүргийг улсын хэмжээнд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Боловсролын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дээд боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ дээд боловсролыг хөгжүүлэх асуудлаар хөтөлбөр, дүрэм, журам, төлөвлөгөө боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ дээд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг төрийн бодлогын хүрээнд уялдуулан зохицуулж, дэмжих, тэднийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах;

3/ төрийн захиргааны бусад төв байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах.

13 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын удирдлага

1. Сонгодог их сургуулийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас томилсон захирал удирдана.

2. Төрийн өмчийн төрөлжсөн их, дээд сургууль, коллежийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон захирал удирдана.

3. Өмчийн бусад хэлбэрийн их, дээд сургууль, коллежийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн үүсгэн байгуулагчийн томилсон захирал удирдана.

4. Захирал нь энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сургуулийн өдөр тутмын үйл ажилллагааг удирдаж, томилсон байгууллагын өмнө ажлаа тайлагнана.

5. Сургалт-эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зорилгоор их, дээд сургуульд эрдмийн зөвлөл, коллежид сургалт-арга зүйн зөвлөл ажиллана. Эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн дарга нь тухайн сургуулийн захирал байна.

6. Захирал нь тэнхим, лаборатори, эрдэм шинжилгээний нэгжийн саналыг үндэслэн эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батална.

7. Их, дээд сургууль, коллежид тухайн сургуулийг хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох, материаллаг

баазыг бэхжүүлэх, санхүүжүүлэх, сургалтын агуулга, арга хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийн талаар санал, дүгнэлт гаргах, зөвлөлгөө өгөх, сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий сургуулийн удирдах зөвлөл ажиллана.

8. Сургуулийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь оюутан болон тэнхим, лаборатори, бусад харьяа нэгж, байгууллага, холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, үүсгэн байгуулагч, захиалагч буюу тухайн сургуультай ажил төрлийн холбоотой аж ахуйн нэгж, байгууллага зэрэг олон нийтийн төлөөлөлтэй байна.

9. Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүний тоо, сонгох журмыг сургуулийн дүрэмд заана.

10. Сургуулийн удирдах зөвлөлийн ажиллах журмыг зөвлөлийн гишүүдийн хурлаар батална.

11. Сургуулийн удирдах зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно.

12. Захирлын дэргэд захиргааны зөвлөл ажиллаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын байгууллагын бүрэн эрх

14 дүгээр зүйл. Дээд боловсролын байгууллагын бүрэн эрх, үүрэг

Дээд боловсролын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн бодлогод нийцүүлэн сургуулийг хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

2/ сургалтын агуулга, арга хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг сонгож хэрэгжүүлэх;

3/ эрдэм шинжилгээ, судалгааны төсөлд оролцох;

4/ сургуулийн удирдах зөвлөлийг сонгож байгуулах;

5/ тогтоосон журмын дагуу сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, харьяа нэгж, байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

6/ суралцагчдыг элсүүлэх, төгсгөх асуудлыг зохих журмын

дагуу шийдвэрлэх;

7/багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, тэдний болон төгсөгчдийн мэргэжлийг дээшлүүлэх;

8/ багшид эрдмийн зэрэг, цол олгох асуудлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу шийдвэрлэх;

9/ бүс нутгийн болон олон улсын чанартай уулзалт, хурал, семинар зохион байгуулах;

10/ үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

11/ гадаадын болон дотоодын дээд сургууль, шинжлэх ухааны байгууллага болон бусад этгээдтэй гэрээ, хэлэлцээр хийх, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хорших, хамтран ажиллах зорилгоор эвлэлдэн нэгдэх, нийгэмлэг, холбоо, зөвлөл байгуулах, гишүүнээр элсэх;

12/ шаардлагатай гэж үзвэл шинээр элсэгчдэд зориулан бэлтгэл сургалт зохион байгуулах.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Багш, суралцагч

15 дугаар зүйл. Багш

1. Их, дээд сургууль, колллежид үндсэн мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заана.

2. Багшийн мэргэжил эзэмшээгүй их, дээд сургууль коллежийн орон тооны багш нь сурган хүмүүжүүлэх боловсрол эзэмшсэн байна.

16 дугаар зүйл. Багшийн эрх, үүрэг

1. Багш нь Боловсролын тухай хуульд заасан эрхээс гадна дараахь эрх эдэлнэ:

1/ төрийн захиргааны болон үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу зөвлөхөөр ажиллах;

2/ бүтээлийн чөлөө авах;

3/ сурган хүмүүжүүлэх хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх, эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авах, нийгмийн зохих хангамж, хөнгөлөлт эдлэх.

2. Багш нь Боловсролын тухай хуульд заасан үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

1/ эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах;

2/ мэргэжлийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд соёл, боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажилд туслах.

17 дугаар зүйл. Суралцагч

Их, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд суралцагчийг оюутан, магистрын шатлалд суралцагчийг магистрант, эрдмийн зэргийнхийг аспирант, докторант гэж тус тус нэрлэнэ.

18 дугаар зүйл. суралцагчийн эрх, үүрэг

1. Боловсролын тухай хуульд заасан эрхээс гадна суралцагч нь дараахь эрх эдэлнэ:

1/ их, дээд сургууль, коллеж, түүний салбар нэгжийн хичээлийн байр, номын сан, сургалт-эрдэм шинжилгээний лаборатори болон сургалтын бусад хэрэгслийг зохих журмын дагуу ашиглах;

2/зарим хичээлийг бие даан судалж дүгнүүлэх;

3/ эрдэм шинжилгээний ажил, бага хуралд оролцох;

4/ бүтээлээ хэвлүүлэхээр дэвшүүлэх;

5/ сургуулийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд шууд буюу төлөөлөн оролцох;

6/ магистрант нь оюутан, бакалаварт мэргэжлийн зөвлөлгөө өгөх, тэдний судалгааны болон дадлагын ажлыг удирдах, туслах;

7/ аспирант нь оюутанд хичээл заах, тэдний дадлагын болон эрдэм шинжилгээний ажлыг удирдах;

8/ докторант нь хичээл заах, аспирантын эрдэм шинжилгээний ажил удирдах.

2. Суралцагч нь Боловсролын тухай хуульд заасан үүрэг хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын эдийн засаг, нийгмийн халамж

19 дүгээр зүйл. Дээд боловсролын төлөвлөлт, мэдээлэл

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дээд боловсролыг хөгжүүлэх, их, дээд сургууль, коллеж нь сургуулиа хөгжүүлэх талаар ойрын болон хэтийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

2. Их, дээд сургууль, коллежийг мэргэжлийн хөтөлбөр, эрдэм шинжилгээний ажлын төслөөр санхүүжүүлэхээр төлөвлөнө.

3. Их, дээд сургууль, коллеж нь статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад өгнө.

4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын судалгаа, арга зүйн байгууллага нь их, дээд сургууль, коллежийг холбогдох мэдээллээр хангана.

20 дугаар зүйл. Дээд боловсролын санхүүжилт

1. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийг санхүүжүүлэх эх үүсвэр дараахь зүйлээс бүрдэнэ:

1/ улсын төсвийн хөрөнгө;

2/ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;

3/ суралцагчдын төлбөр;

4/ өөрийн аж ахуйн үйл ажиллагааны орлого;

5/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;

6/ зээл, тусламж;

7/ бусад эх үүсвэр.

2. Өмчийн бусад хэлбэрийн дээд боловсролын байгууллагад материаллаг баазыг бэхжүүлэх, багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрөөс зохих дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

21 дүгээр зүйл. Суралцагчдад төрөөс үзүүлэх нийгмийн халамж

1. Оршин суугаа газраасаа сургуульдаа тогтмол явах боломжгүй суралцагчдад Боловсролын тухай хуульд заасны дагуу дотуур байраар үйлчилнэ.

2. Өнчин, тахир дутуу болон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагчдад буцалтгүй тусламж, сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоно.

3. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчдад нэрэмжит стипенди олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөхүүлэн дэмжинэ.

4. Суралцагчдад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох журмыг Засгийн газар тогтооно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл.

22 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Дээд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчдөд Боловсролын тухай хуульд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

23 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэдэд сургуулийн өмнөх бо ıон бага, дунд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хууль тогтоомж

Бага, дунд Боловсролын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогто жийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын зорилго

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын зорилго нь иргэдэд ерөнхий, техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол, мэргэжил эзэмшүүлж, оюун ухаан, эрүүл мэнд, бие бялдар, гоо зүй, ёс суртахуун, эрх зүйн хүмүүжил, хүмүүнлэгийн ёсыг төлөвшүүлэх замаар хувь хүн хөгжин төлөвших, авьяас чадвараа нээн илрүүлэх, амьдралд бэлтгэхэд нь туслахад оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын агуулга

4 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх боловсролын агуулга

Сургуулийн өмнөх боловсролын агуулга нь хүүхдэд дараахь мэдлэг, чадвар, дадал хүмүүжлийн зөв хэвшил төлөвшүүлэхэд чиглэнэ:

1/ бие бялдрын хувьд эрүүл чийрэг, хэл яриа, хараа, сонсгол хэвийн, үндсэн хөдөлгөөн /алхах, гүйх, харайх,/-үүдийг зөв гүйцэтгэдэг, ариун цэвэр, эрүүл ахуйн анхны хэвшилтэй болгох;

2/ оюун ухаан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, хүмүүнлэг ёс, байгалийн юмс, үзэгдлийн талаар анхдагч зөв ойлголт олгох;

3/ хүрээлэн байгаа байгаль орчин, ан амьтан, эд юмс, үйл явдлыг дүрслэн зурах, урлан бүтээх, дуулах, хөгжимдөх, бүжиглэх талаархи анхны төсөөлөлтэй болгох;

4/ эцэг, эх, ах, дүү бусад хүмүүсийг хүндэтгэдэг, эелдэг харьцах, сайн, мууг ялгах чадвартай болгох;

5/ хамтач үзлээр хүмүүжүүлэх, бие даасан чанарыг нь хөгжүүлэх;

6/ бага боловсрол эзэмшихэд бэлтгэж, санаа бодлоо зөв илэрхийлэх бусдыг ойлгох, өөртөө үйлчлэх дадал, чадвартай болгох.

5 дугаар зүйл. Бага боловсролын агуулга

Бага боловсролын агуулга нь суралцагчдад дараахь мэдлэг, чадвар, дадал, зөв хүмүүжил эзэмшүүлж төлөвшүүлэхэд чиглэнэ:

1/ эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж бичих;

2/ тоог дөрвөн үйлдлээр бодох, түүнийг өдөр тутмын амьдра. ахуйн тооцоонд хэрэглэх;

3/ байгаль, хүрээлэн байгаа орчны үзэгдэл юмсын талаа зохих мэдлэг олгох;

4/ гоо зүй, үндэсний дэвшилт ёс заншил, соёлын өв уламжлал хүмүүнлэгийн ёс заншил, эрүүл ахуйн талаар зохих мэдлэг олгох

5/ өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга хамтач байдлыг эрхэмлэх үзэлтэй болгох.

6 дугаар зүйл. Суурь боловсролын агуулга

Суурь боловсролын агуулга нь суралцагчдад дараахь мэдлэг чадвар, дадал, хүмүүжил эзэмшүүлж төлөвшүүлэхэд чиглэнэ:

1/ эх хэл болон гадаад хэл, шинжлэх ухааны суурь мэдлэ эзэмшүүлж, түүний үндсэн дээр өөрийн авьяас, чадвараа цааши хөгжүүлж бие даан амьдрахад шаардлагатай мэдлэг, чадвар дадлыг олгох;

2/ гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтөний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрлах үзлээр хүмүүжүүлэх;

3/ гэр бүлийн амьдралын анхан шатны ойлголт, эр эмийн ёсны хүмүүжил, эрүүл ахуй соёлын төсөөлөлтэй болгох.

7 дугаар зүйл. Бүрэн дунд боловсролын агуулга

1. Ерөнхий боловсролын сургуулиар олгох бүрэн дунд боловсролын агуулга нь суралцагчдад дараахь мэдлэг, чадвар, дадал, хүмүүжил эзэмшүүлж төлөвшүүлэхэд чиглэнэ:

1/ байгалийн ухаан, нийгэм, хүмүүнлэгийн үндсэн ойлголт, хуулиудыг танин мэдүүлэх;

2/ эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар олгох, гадаад хэлний зохих мэдлэгтэй болгох;

3/ мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөхөд бэлтгэх;

4/ бие бялдраа хөгжүүлж, эрүүл чийрэг аж төрөх ёсыг сахидаг, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа зөв хөтлөх арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахих үзэл төлөвшүүлэх.

2. Техникийн болон мэргэжлийн сургуулиар олгох бүрэн дунд боловсролын агуулга нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна суралцагчдад техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол, мэргэжил эзэмшүүлэхэд чиглэнэ.

8 дугаар зүйл. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх хугацаа

1. Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдэд төрсөн цагаас нь ерөнхий боловсролын сургуульд орох хүртлэх хугацаанд эзэмшүүлнэ.

2. Бага боловсролыг 4, суурь боловсролыг 8, бүрэн дунд ерөнхий боловсролыг 10 жилд тус тус эзэмшүүлнэ.

3. Суралцагч эзэмшвэл зохих боловсролыг тогтоосон хугацаанаас өмнө эзэмшсэн бол дараагийн ангид дэвшүүлэх буюу анги алгасуулан суралцуулж болно.

4. Техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол эзэмшүүлэх хугацаа нь боловсролын түвшин, мэргэжлийн ялгаа, онцлогоос хамааран 1-4 жил байна.

9 дүгээр зүйл. Бага, дунд боловсролын сурах бичиг

Бага, дунд боловсролын агуулга, стандартад нийцүүлэн сурах бичиг зохиолгох, шинэчлэх, тэдгээрийг хэвлүүлэх болон сурах бичгээр хангах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

10 дугаар зүйл. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг дүгнэх, тэдэнд олгох боловсролын баримт бичиг

1. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг "Онц", "Сайн", "Дунд", "Хангалтгүй" гэсэн үнэлгээгээр дүгнэнэ.

2. Үнэлгээний өөр арга хэрэглэвэл түүнийг дээрх үнэлгээнд шилжүүлнэ.

3. Боловсролын тухай хуульд заасны дагуу ерөнхий боловсрол эзэмшигчдэд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг батламжилсан гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн үнэмлэх олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллага

11 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагын тогтолцоо

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагын тогтолцоо нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, техникийн

болон мэргэжлийн сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-иас бүрдэнэ.

12 дугаар зүйл. Цэцэрлэг

1. Цэцэрлэг нь 2-оос дээш насны хүүхдэд бие сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, хүмүүжлийн зөв хэвшил төлөвшүүлэх, асрах үүрэг бүхий хүмүүжил-сургалтын байгууллага мөн.

2. Цэцэрлэг нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүмүүжил-сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын агуулгыг эзэмшүүлнэ.

3. Цэцэрлэг нь аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн нэгж хэлбэрээр байж болно.

4. Цэцэрлэг нь боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллагаас зөвшөөрөл авч нэмэлт сургалт явуулж болно.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчдад мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

6. Асрамжийн болон сувиллын цэцэрлэгт мөрдөх журмыг боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

7. Цэцэрлэгт цэцэрлэгийн эрхлэгч, багш, багшийн туслах ажиллана.

8. Асрамжийн болон сувиллын цэцэрлэгт эмч ажиллаж болно.

13 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургууль

1. Ерөнхий боловсролын сургууль нь стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалт-хүмүүжлийн байгууллага мөн.

2. Ерөнхий боловсролын сургуулийг эзэмшүүлэх боловсролын түвшинг харгалзан бага, дунд, бүрэн дунд сургууль гэж ангилна.

3. Ерөнхий боловсролын сургууль нь салбар, анги бүлэгтэй байж болно.

4. Ерөнхий боловсролын сургууль нь эцэг, эх, асран хамгаалагч, суралцагчийн хүсэлт, захиргааны санаачилгаар гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулж болно.

Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт явуулснаас үүсэх нэмэгдэл зардлыг эцэг, эх, асран хамгаалагчаас авах төлбөрөөр нөхөж болно.

5. Гүнзгийрүүлэн сургах сургалтын төлөвлөгөө, хөтөлб зохион байгуулах хэлбэрийг сургуулийн сурган хүмүүжүү. зөвлөл батална. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь боловсрол асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгогдсон байгууллагаар зөвшөөрөгдсөн байна.

6. Гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалтыг мэргэжли зэрэгтэй багш зохион байгуулж явуулна.

7. Ерөнхий боловсролын сургуульд 8 настай хүүхдийг элсүүл Үүсгэн байгуулагчаас тогтоосон хяналтын тоонд багтаан 7 нас хүүхдийг элсүүлж болно.

8. Ерөнхий боловсролын сургууль насанд хүрэгчдэд ор эчнээ хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд ерөнхий боловс эзэмшүүлэх сургалт явуулж болно.

9. Орой, эчнээ хэлбэрээр сургалт явуулах харилцааг боло ролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захирга төв байгууллагаас хамтран батална.

10. Ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн э лэгч, багш ажиллана.

Суралцагчийн тооноос хамааран хичээлийн эрхлэгчгүй ба болно.

Багш хүрэлцэхгүй тохиолдолд багшийн туслах ажиллуу болно.

14 дүгээр зүйл. Ерөнхий боловсролын тусгай сургууль

1. Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сургуулийн на хэлгүй, дүлий, хараагүй болон оюун ухааны хомсдолтой хүүх хөнгөрүүлсэн хөтөлбөр, арга хэлбэрээр бага, суурь, бүрэн д ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалт-хүмүүжлийн байгуулл мөн.

2. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сур тойргийг тогтоох, аймаг, нийслэл сум, дүүрэгт салбар бү ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журмыг боловсро асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоно

3. Тусгай сургуулиудыг мэргэжил, арга зүйн удирдла хангах үүрэг бүхий мэргэжил, арга зүйн төв сургууль ажилл

Мэргэжил, арга зүйн төв-сургууль нь боловсролын асуу эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд ажилл

4. Ерөнхий боловсролын тусгай сургуульд захирал, хичээл эрхлэгч багш, эмч ажиллана. Тусгай сургуулиудыг мэргэж арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай сургууль

н тооны арга зүйч, эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж но.

. Ерөнхий боловсролын тусгай сургууль сургалт-үйлдвэрийн дадлагын газартай байна.

5 дугаар зүйл. Ерөнхий боловсролын төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн сургалттай сургууль

Ерөнхий боловсролын төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн галттай сургууль нь ерөнхий боловсролын стандартаас илүү үлгэ, хөтөлбөрийн дагуу суралцагчийн авьяас, чадварыг хөгжлэх зорилготой сургалт- хүмүүжлийн байгууллага мөн.

. Ерөнхий боловсролын төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн галттай сургууль нь суралцагчдад стандартаар тогтоосон овсролыг заавал эзэмшүүлнэ.

. Төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий овсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг туа сургуулийн сурган хүмүүжүүлэх зөвлөл батална.

ургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь боловсролын асуудал эрсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүнээс эрх н байгууллагаар зөвшөөрөгдсөн байна.

Төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий овсролын сургууль нь сургалт-хүмүүжлийн ажлыг зохион үүлах, өөрмөц арга, технологи бий болгох зорилгоор судалшинжилгээний ажил явуулж болно.

нэ тухай тайланг боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллагад хичээлийн жил бүр гаргаж өгнө.

Төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий овсролын сургууль элсэлт явуулах журмаа өөрөө тогтооно. элт нь нээлттэй байна.

Ерөнхий боловсролын төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн галттай сургууль нь төрөлжсөн буюу гүнзгийрүүлсэн сургалт үлснаас үүсэх нэмэгдэл зардлыг эцэг, эх, асран хамгаалагчаас төлбөрөөр нөхөж болно.

Ерөнхий боловсролын төрөлжүүлсэн буюу гүнзгийрүүлсэн галттай сургуульд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 7, 8, 9, 10 хэсэг хамаарна.

дугаар зүйл. Техникийн болон мэргэжлийн сургууль

Техникийн болон мэргэжлийн сургууль нь суралцагчдад

техник, технологи, мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалт-үйлдвэрлэлийн буюу үйлдвэрлэл-сургалтын байгууллага мөн.

2. Техникийн болон мэргэжлийн сургууль бүрэн дунд ерөнхий боловсрол эзэмшүүлж болно.

3. Техникийн болон мэргэжлийн сургууль өдөр, орой, эчнээ сургалттай байж болно.

4. Техникийн болон мэргэжлийн сургууль сургалт-үйлдвэрлэлийн дадлагын газартай байна.

5. Ерөнхий боловсролын зэрэгцээ мэргэжил эзэмшүүлдэг төрөлжсөн мэргэжлийн дунд сургууль байж болно.

6. Техникийн болон мэргэжлийн сургуульд суурь, эсхүл бүрэн дунд ерөнхий боловсролтой буюу түүнтэй адил түвшний боловсролтой иргэдийг элсүүлэн сургана.

7. Мэргэжлийн болон техникийн сургуульд захирал, хичээлийн эрхлэгч, багш ажиллана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагын сургалт-хүмүүжлийн ажлын зохион байгуулалт

17 дугаар зүйл. Цэцэрлэг, сургуулийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаа

1. Цэцэрлэг, сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ.

2. Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон улсын шалгалт авах хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3. Нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, байгалийн болон нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, техникийн болон мэргэжлийн сургуулийнхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрчилж болно.

4. Хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх дуусах болон суралцагчдын амралтын хугацааг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад нөхцөлд өөрчлөх, хичээлийг түр хугацаагаар хаахыг хориглоно.

18 дугаар зүйл. Цэцэрлэг, сургуулийн сургалт-хүмүүжлийн ажлын зохион байгуулалт

1. Цэцэрлэгийн хүмүүжил-сургалтын ажлыг бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгээр зохион байгуулж явуулна.

Хүүхдийн тоо хүрэлцэхгүй тохиолдолд холимог бүлгээр зохион байгуулж болно.

2. Ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн сургалт-хүмүүжлийн ажлыг анги, бүлгээр зохион байгуулна.

Гадаад хэл, мэргэжлийн сургалт дадлага, гүнзгийрүүлсэн сургалтыг дэд бүлэг, хэсгээр зохион байгуулж болно.

3. Цэцэрлэг, сургуулийн нэг ангид байх хүүхдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

4. Ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн долоо хоногт хичээллэх цагийн тоо, нэг хичээлийн үргэлжлэх хугацаа, завсарлагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

19 дүгээр зүйл. Сургуулийн дэг

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч дүрэмт хувцастай байна. Суралцагчийн дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын төрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

2. Ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн дунд сургуулийн суралцагч сургалт-хүмүүжлийн ажилдаа мөрдөх дүрэмтэй байна. Суралцагчийн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

20 дугаар зүйл. Хичээлээс гадуурхи сургалт-хүмүүжлийн ажил

1. Хичээлээс гадуурхи сургалт-хүмүүжлийн ажил нь суралцагчдын танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг батжуулан баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг хөгжүүлэх, ёс суртахуун, гоо зүй, эрх зүй, бие бялдрын хүмүүжлийг төлөвшүүлэхэд чиглэнэ.

2. Хичээлээс гадуурхи сургалт-хүмүүжлийн ажлын үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийг боловсролын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн болон олон нийтийн байгууллагатай хамтран тогтооно.

3. Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурхи сургалт-хүмүүжлийн ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Цэцэрлэг, сургуулийн удирдлага

21 дүгээр зүйл. Цэцэрлэг, сургуулийн удирдлага

1. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, бага, дунд сургуулийг сум, дүүргийн Засаг даргын томилсон эрхлэгч, захирал удирдана.

2. Өмчийн бусад хэлбэрийн цэцэрлэг, бага, дунд сургуулийг сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийн дагуу үүсгэн байгуулагчийн томилсон эрхлэгч, захирал удирдана.

3. Төрийн болон орон нутгийн, ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, өмчийн техникийн болон мэргэжлийн сургуулийг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн сум, дүүргийн Засаг даргын томилсон захирал удирдана.

4. Өмчийн бусад хэлбэрт үндэслэсэн ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулийг аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийн дагуу үүсгэн байгуулагчийн томилсон захирал удирдана.

22 дугаар зүйл. Цэцэрлэг, сургуулийн хамтын удирдлага

1. Цэцэрлэг, сургуульд удирдах зөвлөл, сурган хүмүүжүүлэх зөвлөл, заах аргын нэгдэл ажиллана.

2. Цэцэрлэг, сургуульд эцэг, эх, асран хамгаалагчийн болон суралцагчдын байгууллага ажиллаж болно.

3. Цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөл нь суралцагч, эцэг эх асран хамгаалагч, багш, цэцэрлэг, сургуулийн ажилтан, ахахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй хамтын удирдлагын байгууллага мөн.

4. Цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхтэй:

1/ цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаа, эрхлэгч, захирлын ажилд үнэлэлт, дүгнэлт өгч үүсгэн байгуулагчид танилцуулах, зохих арга хэмжээ авахыг шаардах;

2/ эрхлэгч, захиралд өөрийнх нь үйл ажиллагаатай холбоотой болон цэцэрлэг, сургуулийн хэтийн төлөв, сургалт-хүмүүжлийн ажлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал дэвшүүлэх, зөвлөх, дэвшүүлсэн санал, зөвлөмжийн талаар тайлбар авах;

3/ сургалт-хүмүүжлийн ажлын үр дүн, хөрөнгийн ашиглалт төсвийн зарцуулалтад үнэлэлт гаргуулах, шалгалт хийлгэх талаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах;

4/ эрхлэгч, захирлыг үүрэгт ажлаа хангалтгүй гүйцэтгэж байна гэж дүгнэвэл тэднийг огцруулах тухай хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах, тайлбар авах.

5. Цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөлийг сонгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

6. Цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөлийн ажиллах журмыг зөвлөлийн гишүүдийн хурлаар батална.

7. Цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал тухайн цэцэрлэг, сургуулийн удирдах зөвлөлийн дарга байж болохгүй.

8. Сурган хүмүүжүүлэх зөвлөлийн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9. Заах аргын нэгдлийн ажиллах журмыг цэцэрлэг, сургуулийн захиргаа тогтооно.

23 дугаар зүйл. Цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирлын нийтлэг эрх, үүрэг

1. Цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал нь дараахь нийтлэг эрх эдэлнэ:

1/ боловсролын талаархи хууль, тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;

2/ багш, ажилтныг сонгон авч ажиллуулах, өөрчлөх, чөлөөлөх;

3/ сурган хүмүүжүүлэх зөвлөл, улсын шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн суралцагчдыг анги дэвшүүлэх болон алгасуулан суралцуулах, улируулах, сургууль төгсгөх, сургуулиас хасах, хөөх;

4/ суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, зохих байгууллагад сургалт-хүмүүжлийн ажилтай холбогдох асуудлаар шаардлага тавьж шийдвэрлүүлэх;

5/ гадаадын болоод дотоодын цэцэрлэг, сургууль, аж ахуйн нэгж, байгууллагатай хууль тогтоомжийн дагуу гэрээ, хэлцэл хийж хамтран ажиллах;

6/сургалт-хүмүүжлийн ажлын дэвшилт арга, хэлбэрийг өөрийн сургууль дээр турших.

2. Цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал нь дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

1/ боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

2/ цэцэрлэг, сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3/ цэцэрлэг, сургуулийг багш, ажилтнаар бэхжүүлэх, тэдний хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийг нь дээшлүүлэх;

4/цэцэрлэг, сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, материаллаг баазыг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

5/ цэцэрлэг, сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээ, тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах ажлыг зохион байгуулах;

6/ суралцагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

7/ багш, ажилтны хөдөлмөрийн үр дүнг нь үнэлэх, урамшуулах, дэмжих;

8/ хүүхдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх, иргэдэд нийтийн боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах;

9/ багш, суралцагч, ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Цэцэрлэг, сургуулийн багш

24 дүгээр зүйл. Цэцэрлэг, сургуулийн багшийг бэлтгэх

1. Цэцэрлэг, сургуулийн багшийг багш бэлтгэх их, дээд сургууль, коллежоор бэлтгэнэ.

2. Багшийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалтад хамруулсны дараа багшлуулна.

3. Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгоно.

4. Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах тухай журмыг Засгийн газар тогтооно.

25 дугаар зүйл. Багшийн эрх, үүрэг

1. Багш нь боловсролын тухай хуульд заасан үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

1/ Үндсэн хууль, Боловсролын тухай болон холбогдох бусад хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг мөрдөх, тэдгээрийг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах, шавь нараа хуулийг хүндлэн дээдэлж, сахин биелүүлдэг үзлээр хүмүүжүүлэх;

2/ бага, дунд боловсролын стандартыг мөрдөж, заах арга, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

3/ сургалт-хүмүүжлийн ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөх, хичээлийн хуваарь, үргэлжлэх хугацааг мөрдөх;

4/ хичээлийг багш, суралцагчийн хамтын бүтээлч үйл ажиллагаа болгон зохион байгуулах, суралцагчийг сэтгэн бодох, бие даан ажиллах чадвар, дадалд сургах, тэдний мэдлэг, чадвар, дадлыг бодитой зөв үнэлэх;

5/ хүүхдийн авьяас, чадвар, сонирхлыг нээн илрүүлж, чиг зорилготой хөгжүүлэх, тэдний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөлгөө, туслалцаа үзүүлэх;

6/ сургалт-хүмүүжлийн ажлын явцад эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангах;

7/бага насны хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн байдлыг хянаж, сургуулийн эмч болон эцэг, эх, асран хамгаалагчид нь шаардлагатай зүйлийг мэдээлэх.

2. Багш нь боловсролын тухай хуульд заасан эрхээс гадна дараахь эрхийг эдэлнэ:

1/ сургууль болон багш, суралцагчдын сургалт- хүмүүжлийн ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг таслан зогсооход биечлэн оролцох, хориглох;

2/ сургалт- хүмүүжлийн ажлыг эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан орчинд жигд, тогтвортой явуулах зохцол бололцоогоор хангуулах;

3/сурган хүмүүжүүлэх хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх, нийгмийн зохих хангамж, хөнгөлөлт эдлэх.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Бага, дунд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчдөд Боловсролын тухай хуульд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их
Хурлын Дарга **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хууль / шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Боловсролын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Боловсролын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их
Хурлын Дарга **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

5 дугаар зүйлийн 13 дахь заалт;

"13/үнэт цаасны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, бүртгэх;"

17^1 дүгээр зүйл:

"17^1 дүгээр зүйл. Үнэт цаасны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Үнэт цаасны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/үнэт цаас худалдахаар гаргах зөвшөөрөл олгож, бүртгэхэд 15000 төгрөг;

2/тендер санал гаргах зөвшөөрөл олгоход 10000 төгрөг;

3/үнэт цаасны үйл ажиллагаа дагнан эрхлэх зөвшөөрөл олгоход 10000 төгрөг."

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 5 дугаар зүйлийн 13 дахь заалтыг "14/" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Их Хурлын Дэд Дарга **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд дараахь заалт нэмсүгэй.

"9/хуульд тусгайлан заасан тохиолдолд байгаль хамгаалагч"
2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их
Хурлын Дэд Дарга **Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "дүрмийн сангийнхаа хэмжээгээр" гэснийг "өөрийн хөрөнгөөр" мөн зүйлийн 4 дэх хэсэгт "тэнцүү үнэлгээ" гэснийг "нэрлэсэн үнэ" гэж тус тус өөрчилсүгэй.

Монгол Улсын Их
Хурлын Дэд Дарга **Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр — Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "улс төрийн болон" гэсний дараа "Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаас бусад", мөн зүйлийн 5 дахь хэсгийн "төрийн захиргааны болон" гэсний дараа

"энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан албан хаагч" гэж тус тус нэмсүгэй.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 30-наас эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их
Хурлын Дарга **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАРЛИГ, ЗАРЛИГИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэнтий аймагт шинээр Хэрлэн сум байгуулсантай холбогдуулж дор дурдсан зарлиг, зарлигийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

1/"Орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 129 дүгээр зарлигийн Хэнтий аймагт гэсэн хэсгийн 17, 19 дэх заалт;

2/"Өндөрхаан сангийн аж ахуйн төвд сум байгуулах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1963 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 98 дугаар зарлиг;

3/"Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын Хэрлэн суманд хамаарах 289 дүгээр заалт;

4/"БНМАУ-ын хотуудын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 252 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 1-д заасан "Өндөрхаан хот" гэсэн хэсэг.

Монгол Улсын Их
Хурлын Дарга **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙН ТУХАЙ БОЛОН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийн тухай болон Хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх

1.Нөхөрлөл, компанийн тухай болон Хоршооны тухай хуулийг эдгээр хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш үүсэн байгуулагдсан нөхөрлөл, компани, хоршоо дагаж мөрдөнө.

2.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу байгуулагдан ажиллаж байгаа хоршоо, компани нь Нөхөрлөл, компанийн тухай болон Хоршооны тухай хуулийн дагуу тус тус гэрээ, дүрмээ шинэчлэн өөрчилж, уг өөрчлөлтөө улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэлх хугацаанд Аж ахуйн нэгжийн тухай хуулийн зохих заалтыг дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Гэрээ, дүрэм болон аж ахуйн нэгжийг шинэчлэн бүртгүүлэх

1.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу байгуулагдан ажиллаж байгаа хоршоо, компани нь өөрийн гэрээ, дүрэмдээ Нөхөрлөл, компанийн тухай болон Хоршооны тухай хуульд нийцүүлэн зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, уг нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хоршоо, компани Иргэний хууль, Нөхөрлөл, компанийн тухай хууль болон Хоршооны тухай хуулийн дагуу хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдвал улсын бүртгэлд шинээр бүртгүүлнэ.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх нөхөрлөл, компани, хоршоог улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

3 дугаар зүйл. Улсын бүртгэлд бүртгүүлэх хугацаа

1. Гэрээ, дүрмээ шинэчилсэн буюу өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгжүүд энэхүү өөрчлөлтөө 1996 оны 5 дугаар сарын 1-ний дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор улсын бүртгэлд бүртгүүлээгүй хоршоо, компанийг эрх бүхий байгууллага татан буулгаж, улсын бүртгэлээс хасна.

4 дүгээр зүйл. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх, дүрмийн сан бүрдүүлэх хугацааг тогтоох

1.Үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлж байгаа болон өөрчлөн байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжүүд энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэхийн өмнө үндсэн хөрөнгийнхөө дахин үнэлгээг засгийн газраас батлагдсан аргачлал, журмын дагуу хийнэ. Энэхүү үнэлгээнд үндэслэн гишүүдийн эзэмшиж буй хувь хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтооно.

2.Энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрээ, дүрэмдээ зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн боловч дүрмийн сан нь Нөхөрлөл, компанийн тухай хуульд заасан хэмжээнд хүрээгүй компанийн дүрмийн санг бүрдүүлэх хугацааг 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр тогтооно. Энэхүү хугацаанд багтааж дүрмийн санғаа бүрдүүлээгүй компанийг эрх бүхий байгууллага татан буулгаж, улсын бүртгэлээс хасна.

5 дугаар зүйл. Бусад зүйл.

1.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа хоршоо, компанийн байгуулсан гэрээ хэлцэл, төлбөр тооцоотой холбогдсон эрх, үүрэг ийнхүү шинээр өөрчлөн байгуулагдсан нөхөрлөл, компани, хоршоонд шилжинэ.

2.Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4, 42 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д заасан хянан шалгагч/хянан шалгагчдын зөвлөл/-аар 1998 оны 1 дүгээр сарын 1 хүртэл мэргэжлийн нягтлан бодогчийг сонгож болно.

3.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу байгуулагдан ажиллаж байгаа хувиараа эрхлэх аж ахуй, улсын үйлдвэрийн газар нь одгээртэй холбогдсон харилцааг хуулиар шинэчлэн зохицуулах хүртэл үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлнэ.

6 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг Нөхөрлөл, компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 7 дугаар сарын 4-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 177 дугаар зүйл, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 182 дугаар зүйл, 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Шүүгч шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах шаардлагатай гэж үзвэл дараахь арга хэмжээг хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа захирамж гарган авах эрхтэй.

1/хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх;

2/хариуцагчаас ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг хориглох;

3/хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох;

4/нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах."

2/82 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Шүүгч дор дурдсан хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтад заасан хэргийг дангаар хянан шийдвэрлэнэ:

1/Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 1,3,4,6 дахь заалт;

2/Хөдөлмөрийн хуулийн 92 дугаар зүйлийн 1,2,3,4,6,7,8,9,10 дахь заалт;

3/гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан;

4/тэтгэврийн харилцаанаас үүссэн маргаан;

5/Тэтгэмжийн хуулийн 27 дугаар зүйл;

6/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 136 дугаар зүйлийн 1,2,3,4,5,6 дахь заалт;

7/шүүх торгууль ногдуулахаар хуульд заасан асуудал;

8/бусад хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг."

3/177 дугаар зүйл:

"177 дугаар зүйл. Хяналтын журмаар эсэргүүцэл бичих

1.Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт; Улсын дээд шүүхийн шүүгч сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй хүчин төгөлдөр болсон шийдвэр, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй.

2.Улсын ерөнхий прокурор давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй.

3.Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч бичсэн эсэргүүцлээ хяналтын журмаар хянан хэлэлцэхээс өмнө буцаан авч болно."

4/178 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт Улсын дээд шүүхийн шүүгчийн бичсэн эсэргүүцлийг зохих аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар; давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорын бичсэн эсэргүүцлийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан хэлэлцэнэ."

5/182 дугаар зүйл:

"182 дугаар зүйл. Хэрэг хянан хэлэлцэх хугацаа Эсэргүүцэл бичигдсэнээс хойш 21 хоногт багтаан аймаг, нийслэлийн болон Улсын дээд шүүхэд хяналтын шүүх хуралдаанд хэргийг хэлэлцүүлнэ. Энэ хугацааг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч сунгаж болно."

6/184 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гарна. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах, хяналтын

журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, түүнд бичсэн эсэргүүцэл, прокурорын дүгнэлтийн агуулга, гаргаж буй шийдвэр, түүний үндэслэлийг тусгана."

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 94 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

1/43 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай, төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, түүний албан тушаалтан гаргаж өгөх үүрэгтэй."

2/94 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган, зохих шатны өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд олонхи шүүгч нь оролцож байгаа шүүхээр хэргийг хянан хэлэлцүүлнэ."

3 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "30" гэснийг "10" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн дараа "Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна.", 102 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн сүүлчийн өгүүлбэрийн дараа "Нэхэмжлэгч өөрөө болон төлөөлөгч, өмгөөлөгчийнхөө эзгүйд шүүх хуралдааныг хийх талаар бичгээр хүсэлт ирүүлсэн бол тэдгээрийг оролцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэж болно." гэж тус тус нэмсүгэй.

5 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 181 дүгээр зүйлийг хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их
Хурлын Дарга **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дор дурдсан мэдээ, баримт бичиг, биет зүйлийг Монгол Улсын төрийн нууцад хамаарууулна:

д/д	Төрийн нууцын жагсаалт	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа /жилээр/
		онц чухал маш нууц	маш нууц	нууц	
0	А	1	2	3	4
	Нэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хүрээнд				
1.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлол, улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбоотой, хуулиар төрийн нууцад хамаарууулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, биет зүйл	нууцалсан зэргээр		байнга	

0	А	1	2	3	4
2.	Улсын Их Хурлын чуулган, Үндсэний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн, хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, биет зүйл	нууцалсан зэргээр			байнга
3.	Аливаа улс оронтой харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн баримт бичиг	нууцалсан зэргээр			30
4.	Гадаад бодлогын асуудлаар боловсруулж байгаа баримт бичиг, гадаад орон, олон улсын санхүүгийн болон олон улсын банкны байгууллагатай байгуулах боловсруулалтын шатны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөр, төслийн тооцоо үнийн мэдээлэл	нууцалсан зэргээр			хугацааг тусгайлан заагаагүй бол хүчин төгөлдөр болтол
5.	Төрийн дээд, өндөр хэмжээний айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээрийн сэдэв, илтгэл, тэмдэглэл, тэдгээрт холбогдох бусад баримт бичиг			+	талууд өөрөөр тохироогүй бол хэлэлцээр дуусга

0	А	1	2	3	4
6.	Үндэсний аюулгүй байдлын асуудлаар гадаад орны Засгийн газар, байгууллагатай байгуулсан хоёр талын болон олон Улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаархи мэдээ, баримт бичиг, биет зүйл	нууцалсан зэргээр			талууд өөрөөр тохирооогүй бол 60
7.	Монгол Улсаас гадаад оронд суугаа бүрэн эрхт болон байнгын төлөөлөгчийн газар, ерөнхий консулын газруудын ажлын удирдамж, төлөвлөгөө	нууцалсан зэргээр			10
8.	Олон улсын хурал, зөвлөлгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж	нууцалсан зэргээр			10
9.	Онцгой байдалд Монгол Улсын бүрэн эрхт болон байнгын төлөөлөгчийн газар, ерөнхий консулын газруудын ажиллах төлөвлөгөө	нууцалсан зэргээр			10
10.	Төрийн тусгай болон дипломат шуудан:				байнга
1/	битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл		+		
2/	бүртгэл нь			+	

0	А	1	2	3	4
11.	Улсын онц чухал обьектын хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг, биет зүйл		+		40
12.	Төр, Засгийн удирдагч, гадаадын дээд, өндөр хэмжээний зочны байнгын болон цаг үеийн хамгаалалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээ, бусад баримт бичиг			+	10
13.	Улсын дайчилгааны даалгавар, бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө, улсын нөөцийн хэмжээ, тэдгээрийн санхүүжилттэй холбогдсон мэдээ, баримт бичиг:	+			40
1 /	яам, тусгай газар, аймаг, хотын дайчилгаа, бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө		+		30
2/	сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын дайчилгаа, бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө			+	20

)	А	1	2	3	4
4.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа	нууцал-сан зэргээр			30
5.	Иргэний хамгаалалтын оператив болон онцгой үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглахтай холбогдсон баримт бичиг, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл, биет зүйл	нууцал-сан зэргээр			
6.	Төрийн шифр-харилцааны тусгай техник хэрэгсэл, түүний зураглал, заавар, техникийн өгөгдөхүүн, шифрийн код, түлхүүр, тэдгээртэй холбогдсон баримт бичиг, шифр, ашиглах арга, ажиллагаа	+			20 байн
7.	Төрийн шифр-мэдээ	нууцал-сан зэргээр			60

0	А	1	2	3	4
18.	Төрийн нууцлал бүхий холбоо, тоон мэдээллийн систем, сүлжээ, түүний бүтэц, зохион байгуулалт, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, программ хангамж, түлхүүрийн баримт бичиг, холбооны системийн монтаж, техникийн өгөгдэхүүн, ашиглалт, үйлчилгээний заавар, техникийн баримт бичиг, радио долгионы үелзлэлийн хуваарилалт, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл	+			60
19.	Хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан, устгасан тухай мэдээ, баримт бичиг			+	40
20.	Хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад холбогдох баримт бичиг	нууцалсан зэргээр			25

0	А	1	2	3	4
	Хоёр. Батлан хамгаалах хүрээнд				
21.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн талаархи бодлого, үзэл баримтлал, цэргийн номлолын нууцалсан хэсэг, заалт	нууцалсан зэргээр			40
22.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн орон тоо, дэлгэрэнгүй төсөв, түүний гүйцэтгэл, зэвсэглэл, материал техникийн хангалтын нэгдсэн захиалга, тооцоо, мэдээ	+			40
23.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн оперативын болон дайчилгааны бэлтгэл, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтийн мэдээ, тооцоо, зэвсэгт хүчин, бусад цэргийг бэхжүүлэх, ашиглах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, операци, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт тэмцэл явуулах арга, ажиллагааны тактик, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл		+		40

0	А	1	2	3	4
24.	Монгол Улсаас гадаад улстай батлан хамгаалах, аюулгүй байдлын талаар байгуулсан гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээ, баримт бичиг	нууцалсан зэргээр			40
25.	Оперативын удирдамж, байлдааны тушаал, захирамж, оперативын мэдээ		+		10
26.	Байлдааны ажиллагааны газар орныг оперативын хувьд төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээ, баримт бичиг		+		60
27.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн анги, нэгтгэл, байгууллагын тоо, зохион байгуулалт, бүтэц, жинхэнэ нэр, байршлын зурагналын нэгдсэн мэдээ, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлын түвшинг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт				
28.	Цэргийн анги, нэгтгэл, байгууллагыг нэрээр, эсхүл дугаараар зэвсэгт хүчний болон бусад цэргийн хэмжээнд нэгтгэн гаргасан мэдээ		+		60
				+	20

0	А	1	2	3	4
29.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн цэрэгт татагдах болон цэргээс халагдах хүний тооны тухай нэгдсэн мэдээ, баримт бичиг:				
1/	улсын хэмжээнд		+		20
2/	аймаг, хотын хэмжээнд			+	15
30.	Зэвсэгт хүчин бусад цэргийн автоматжуулсан болон далдуур удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалт, тэдгээрт холбогдох мэдээ, бусад баримт бичиг		+		60
31.	Байлдааны техник, зэвсэг, галт хэрэгслийн хангалт, захиалга, нөөцийн нэгдсэн мэдээ		+		30
32.	Цэргийн нууц техник хэрэгслийн нэр төрөл, техникийн өгөгдэхүүний тухай мэдээ, баримт бичиг	нууцалсан зэргээр			60
33.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн удирдлагын командын байршил, холбооны зангилгаа, радио үелзлэлийн хуваарилалтын нэгдсэн мэдээ, баримт бичиг	+			60

0	А	1	2	3	4
34.	Үнэмлэхүй солбилцолтой 1:5000-аас 1:200000 масштабтай байр зүйн зураг, улсын геодезийн болон тусгай сүлжээний цэгийн каталоги, Монгол Улсын нутаг дэвсгэрийн гравиметрийн зураглалын бүх төрлийн зураг, геодези, байр зүй, агаарын зураглал, гравиметрийн ажлын тайлан	нууцалсан зэргээр			байнга
35.	Цэргийн онц чухал объектын байршил, зориулалт, байлдааны жижүүрлэлтийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, баримт бичиг	+			10
36.	Цэргийн тусгай ачаа тээвэрлэлт, түүний зохион байгуулалт, харуул хамгаалалттай холбогдсон мэдээ, бусад баримт бичиг			+	5
37.	Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүний сэтгэл санааны байдлын тухай нэгдсэн мэдээ			+	5

0	А	1	2	3	4
38.	Хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл ашиглаж бэлтгэсэн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээ-судалгааны ажил, хичээлийн тэмдэглэл, лекц ярианы сэдэв, цэргийн сургууль төгсөгчдийн дипломын ажил, тэдгээрт холбогдох баримт бичиг	нууцалсан зэргээр			20
39.	Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулж явуулахтай холбогдсон баримт бичиг		+		15
40.	Улсын хил хамгаалалт, хангалтын зохион байгуулалт, арга ажиллагаа, оперативын төлөвлөгөө, тэдгээрт холбогдох нэгдсэн мэдээ, баримт бичиг		+		50
	Гурав. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологийн хүрээнд				
41.	Улс орны эдийн засаг, салбар бүс нутагт нийгмийг хөгжүүлэх жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, баримт бичгийн хуулиар төрийн				

0	А	1	2	3	4
	нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан хэсэг		+		20
42.	Улс, хот хоорондын холбоо, мэдээлэл дамжуулах систем болон кабель шугамын нэгдсэн сүлжээ, дэлгэрэнгүй зураглал	нууцалсан зэргээр			20
43.	Улсын эрдэнэсийн сан, мөнгөн тэмдэгтийн нөөцийн сангийн байршил, тэдгээрийн хамгаалалттай холбогдох мэдээ, баримт бичиг		+		байнга
44.	Улсын эрдэнэсийн сан, мөнгөн тэмдэгтийн нөөцтэй холбогдсон нэгдсэн мэдээ, бүртгэл, баримт бичиг		+		30
45.	Улсын төсвийн дэлгэрэнгүй тайлангийн хуулиар төрийн нууцад хамаарууулсан мэдээлэл агуулсан хэсэг		+		20
46.	Алт эрдэнэсийн зүйл, бэлэн мөнгө, валют тээвэрлэх зам, цаг хугацаа, хамгаалах хүч, хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг		+		5

0	А	1	2	3	4
47.	Шинжлэх ухаан, технологийн ололтыг дотоод, гадаадад дамжуулах лицензийн гэрээтэй холбоотой баримт бичиг	нууцалсан зэргээр			гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол 10
48.	Хуулиар төрийн нууцад хамааруулсан тусгай объектуудад олгосон газрын нэр, байршил, газар олголтын зураг		+		20
	Дөрөв. Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд				
49.	Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, туслах хүч, тэдгээрийг халхавчлахтай холбогдолтой мэдээ, баримт бичиг, биет зүйл	+			байнга
50.	Гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан, мэдээ, судалгаа, тусгай сангийн баримт бичиг	+			байнга
51.	Гүйцэтгэх ажлын мэдээллийн сан, тусгай зориулалтын техник хэрэгсэл, тэдгээрийн заавар, холбогдох баримт бичиг, биет зүйл, мэдээлэл зөөгч, программ, нэвтрэх түлхүүр		+		60

0	А	1	2	3	4
52.	Бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих гүйцэтгэх ажил, тагнуул, сөрөх тагнуулын байгууллагын салбар нэгж, тэдгээрийн байр, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл		+		60
53.	Гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн баримт бичиг, холбогдох бусад зүйл		+		60
54.	Холбогдох байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан тушаал, заавар, бусад баримт бичиг		+		60
55.	Гүйцэтгэх ажилтнууд үйл ажиллагаандаа удирдамж болгох үндсэн чиглэл, төлөвлөгөө, тайлан, ажил үүргийн хуваарь, тэдгээрт холбогдох бусад баримт бичиг		+		60
56.	Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон				

0	А	1	2	3	4
	тоо, дэлгэрэнгүй төсөв, боловсон хүчний хангалт, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг		+		60
57.	Тусгай албаны болон гүйцэтгэх ажилтны хувийн хэрэг, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар, тэдний албан ажилтай холбогдсон мэдээ, баримт бичиг		+		60
58.	Гүйцэтгэх ажлын эрдэм шинжилгээ, түүх судалгаа, сургалтын холбогдотой бүтээл, ном, сэтгүүл, хичээлийн хөтөл бөр, төлөвлөгөө, тэдгээрт холбогдох баримт бичиг, биет зүйл		+		60
59.	Тагнуулын байгууллагаас улсын аюулгүй байдалтай холбогдуулан төр, засгийн дээд болон бусад байгууллагад илгээсэн мэдээ, илтгэх хуудас, танилцуулга		+	+	60
60.	Тусгай архивын данс, карт, маягт, биет зүйл		+	+	60
61.	Гүйцэтгэх ажлын төсөв, зардал, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг		+		60

0	А	1	2	3	4
62.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах журам, заавар, арга хэрэгсэл, холбогдох баримт бичиг, биет зүйл		+		50
63.	Тагнуулын байгууллагын тусгай хэрэгслийн болон галт зэвсгийн хангалт, нөөц, бэлэн байдалд шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөө			+	30
64.	Тагнуулын байгууллагын төв, орон нутгийн албадын болон тусгай объектын хамгаалалтад холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл		+	+	20
65.	Гүйцэтгэх ажил болон төрийн тусгай хамгаалалтад ашиглаж байгаа радио холбооны үелзлэлийн хуваарилалт, тусгай албаны телефон утасны жагсаалт			+	5
	Тав. Бусад зүйл.				
66.	Төрийн байгууллагын хаалттай хуралдаанаар хэлэлцсэн асуудал, түүнд холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл	нууцалсан зэргээр			20

А	1	2	3	4
7.Цаазаар авах ял гүйцэтгэх журам, ажиллагаа, гүйцэтгэсэн тухай баримт бичиг		+		байнга
8.Цагдаагийн болон хорих байгууллага, дотоодын цэргийг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг гарсан үед ажиллах төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио		+		20
9.Цагдаагийн болон хорих байгууллага, дотоодын цэргийн галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, тоо хэмжээ, хуваарилалтын тухай мэдээ, баримт бичиг			+	10
0.Цагдаагийн болон хорих байгууллага, дотоодын цэргийн шуурхай удирдлагын суурин, хөдөлгөөнт командын байр, холбооны зангилгаа, радио, техник хэрэгслийн зохион байгуулалт, байршил, үелзлэлийн хуваарилалтын тухай мэдээ, баримт бичиг		+	+	10

0	А	1	2	3	4
71.	Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, холбогдох мэдээ, баримт бичиг		+		10
72	Цагдаа, тагнуулын байгууллагын өндөржүүлсэн бэлтгэлтэй тусгай ангийн сургалтын хөтөлбөр, түүний биелэлтийн тухай мэдээ, баримт бичиг			+	10
73	Дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, холбогдох мэдээ, баримт бичиг, биет зүйл	+			40

Тайлбар: Нууцын зэрэглэлийг /+/ гэж тэмдэглэв.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 32 | Улаанбаатар хот

Харьяатын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Харьяатын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Иргэний харьяаллын асуудлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сайд нарын Зөвлөлийн тогтоол, бусад шийдвэр, журмыг харьяатын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

Дэд Дарга **Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 42 | Улаанбаатар хот

Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг хавсралтын ёсоор батлалсугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны удирдах албан тушаалын ангилал, зэрэглэл

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны удирдах албан тушаалын		Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Шүүхийн Тамгын газар	Улсын Ерөнхий прокурорын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба
ангилал	зэрэглэл						
Төрүүн түшмэл	АА-1	Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч	Дэд дарга	Дэд дарга	Дэд дарга		
	АА-2	Хэлтэс, албаны дарга		Хэрэг эрхлэх газрын доторхи газрын дарга		Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга	
	АА-3		Хэлтэс, албаны дарга	Хэлтэс, албаны дарга	Хэлтсийн дарга, Шүүхийн судалгааны төвийн захирал	Хэлтсийн дарга	
Эрхэлсэн түшмэл	АА-4	Ахлах зөвлөх	Тасгийн дарга	Тасгийн дарга	Тасгийн дарга	Тасгийн дарга	
	АА-5	Ахлах зохион байгуулагч, зөвлөх, ахлах программч	Ахлах референт	Засгийн газрын ахлах референт	Ахлах референт	Ахлах референт	Ахлах референт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот

"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүр тооцож ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

3.Монголын ард түмний соёлын өв болсон үндэсний бичгээ идэвх чармайлт гарган суралцахыг нийт ард түмэнд уриалсугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 43 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг зүйл

Монгол улс бичиг үсгийн мянган жилийн түүхтэй эртний соёлт улсын нэг билээ. Монгол бичиг нь монголын ард түмний соёл, мэдлэгийн санг олон үеийн турш тээж ирсэн бичиг юм.

Монголчууд эртний монгол бичгээ монгол хэлнийхээ авианы тогтолцоонд тохируулан, тодотгож, сайжруулсаар ирсэн бөгөөд сүүлийн 300 жилд үгсийн сан, хэлний зүйн дүрмийн хувьд улам боловсронгуй болж уг бичгээр иргэний ба орчуулгын олон зохиол гарч бичгийн сонгодог хэлбэр бүрэлдэн хөгжсөн түүхтэй билээ.

XIII зууны үеэс 1946 он хүртэл Монгол улсад албан хэргийг монгол бичгээр хөтөлж иржээ. Сүүлийн 40 гаруй жилд улсын албан хэрэг, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа, хүн амд боловсрол олгох ажлыг үндсэнд нь шинэ үсгээр явуулж байгаа боловч монгол бичгийг ахмад үеийнхэн маань хэрэглэж, олон эрдэмтэд соёлын үнэт бүтээлийг хэвлэн нийтэлж, ерөнхий боловсролын сургуулийн 7,8 дугаар анги, их дээд сургуулийн мэргэжлийн ангиудад зааж байв.

1991 онд Улсын Бага хурлаас "БНМАУ-д төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэлийг хангах тухай" 36 дугаар тогтоол гаргасан байна.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр бүх шатны сургуулийн сурагч, оюутнууд, нийт иргэдэд монгол бичгийг зааж сургах, багш бэлтгэх, ном, сурах бичиг зохион хэвлүүлэх, заах арга боловсруулах, зөвлөгөө өгөх, хяналт шалгалт явуулах зэрэг нэлээд далайцтай ажил зохиогдов.

Монгол бичгийн сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан Улсын Их Хурал 1994 оны 7 дугаар сард Улсын Бага Хурлын 36 дугаар тогтоолын биелэлтийг хэлэлцээд гаргасан 66 дугаар тогтоолдоо албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангагдаагүйг тэмдэглээд албан хэрэг болон сургалтыг кирилл бичгээр явуулахаар заасны дээр, монгол бичгийн талаар сүүлийн 3 жилд хийсэн ажлыг улам эрчимжүүлэх зорилгоор "Уйгаржин монгол бичгийн үндэсний хөтөлбөр" боловсруулан батлуулахыг Засгийн газарт даалгасан байна.

Монгол Улсын Их Хурал үндэсний соёлын баялаг өвийг танин мэдэх, судлан дэлгэрүүлэх, ардынхаа ёс заншлыг уламжлуулах нэг нөхцөл бол монгол бичиг мөн гэж үзэж монгол бичгийн үндэсний хөтөлбөр /цаашид "Үндэсний хөтөлбөр" гэх/-ийг дэвшүүлэн тавьж байна.

Хоёр. Үндэсний хөтөлбөрийн бүтэц

А. Үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт

Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн зорилго нь монгол бичгийн сургалтыг суурь боловсролын агуулгад багтаан зохион байгуулж, бүх нийтийг сургах, монгол бичгийг хэрэглэх орчин бий болгоход оршино.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

1/монгол бичиг сурах идэвхийг өрнүүлж албан ба албан бус сургалтад бүх нийтийг хамруулах;

2/бүх шатны сургуульд монгол бичиг заах багш бэлтгэх, давтан бэлтгэх, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, монгол бичгийг телевиз, радио, хэвлэлээр заах болон насанд хүрэгчид, түүний дотор төрийн албан хаагчдад зааж сургах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

3/төв, орон нутгийн хэвлэх үйлдвэрийг компьютержүүлж, тэдгээрийг монгол бичгийн хөтөлбөр, түүнийг эзэмшсэн боловсон хүчнээр хангах, монгол бичгээр сурах бичиг, гарын авлага хэвлэж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг төрөөс дэмжин туслах;

4/монгол бичигт бүх нийтийг сургах, түүнийг өргөн хэрэглэх хэрэгцээ, орчин бий болгоход чиглэсэн санаачилга, ажиллагааг бүх талаар хөхүүлэн дэмжих.

Үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар монгол бичгийн сургалтыг бүх шатны сургуульд тасралтгүй байх зарчмаар зохион байгуулж, иргэдийн монгол бичгийн мэдлэгийн түвшинг кирилл бичгийн мэдлэгийн түвшинд хүргэх бодлогыг баримтална.

Б.Үндэсний хөтөлбөрийн бүрэлдэхүүн

Үндэсний хөтөлбөр нь энэ бүлгийн А хэсэгт заасан зорилтуудыг шийдвэрлэх арга хэмжээг багтаасан дараахь хэсгээс бүрдэнэ:

1/монгол бичгийн сургалтын удирдлага, зохион байгуулалт;

2/монгол бичгийн бүх нийтийн сургалт;

3/монгол бичгийн орчин бүрдүүлэх;

4/хэвлэх үйлдвэрийн техник, технологийг шинэчлэх;

"Монгол бичгийн сургалтын удирдлага, зохион байгуулалт" гэсэн хэсэгт монгол бичгийн бүх нийтийн сургалтыг зохион байгуулах асуудлыг хариуцах, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны түүнчлэн мэргэжлийн байгууллагуудын үүрэг, хариуцлага, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хамаарна.

"Монгол бичгийн бүх нийтийн сургалт" гэсэн хэсэгт бүх шатны сургуулийн оюутан, сурагчдыг албан ёсны сургалтын хүрээнд, нийт хөдөлмөрчдийг албан бус сургалтын хүрээнд хамруулан

монгол бичгийн сургалт зохион байгуулахад чиглэсэн арга хэмжээ хамаарна.

"Монгол бичгийн орчин бүрдүүлэх" гэсэн хэсэгт бүх нийтийг монгол бичигт сургах, монгол бичгийг хэрэглэх орчин бий болгоход чиглэсэн арга хэмжээ хамаарна.

"Хэвлэх үйлдвэрийн техник, технологийг шинэчлэх" гэсэн хэсэгт төв, орон нутгийн хэвлэх үйлдвэрүүдэд монгол бичгээр хэвлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хамаарна.

В.Олон улсын хамтын ажиллагаа

Хөрөнгө санхүүгийн нөөц, үндэсний эдийн засгийн чадавхи хязгаарлагдмал байгаа өнөөгийн нөхцөлд үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэгтэйг үндэс болгон олон улсын байгууллага, дэмжигч зарим улс оронтой хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх тодорхой чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах зэргээр хамтран ажиллана.

Үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гадаадын тусламж, хандив, хөрөнгийг зохистой хуваарилан, оновчтой зарцуулахад онцгой анхаарна.

Г.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Үндэсний хөтөлбөрийг 1995-2005 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Монгол бичгийн сургалтын удирдлага, зохион байгуулалт

А.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах байгууллага, түүний үүрэг

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газар хариуцан зохион байгуулна.

Засгийн газар нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулахдаа дараахь үүрэг хүлээнэ:

1/үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, боловсрол, соёлын

үндэсний бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, Засгийн газрын шийдвэрт тусгах;

2/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, үндэсний хөтөлбөрт тодотгол, өөрчлөлт оруулах санал бэлтгэн Улсын Их Хуралд оруулан шийдвэрлүүлэх;

3/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байх;

4/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан олгож байгаа төсөв, гадаадын тусламж, хандивын хөрөнгийг төв, орон нутагт хуваарилах, тэдгээрийн зарцуулалтад хяналт тавих;

5/аймаг, нийслэлд монгол бичгийн сургалтыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

6/үндэсний хөтөлбөрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, нийтийн хүртээл болгох, иргэдийн монгол бичиг сурах идэвх, санаачилгыг өрнүүлэх ажлыг зохион байгуулах.

7/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа төр, олон нийтийн байгууллага, нутгийн захиргааны ба олон улсын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

Засгийн газар үндэсний хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулахдаа энэ ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөн оролцуулна.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдах, монгол бичгийн сургалтыг зохион байгуулах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцаж өөрийн харъяа мэргэжлийн нэгжээр дамжуулан гүйцэтгэнэ.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь үүрэг хүлээнэ:

1/монгол бичгийн бүх нийтийн сургалтыг мэргэжил, арга зүйн талаас удирдан зохион байгуулах;

2/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийгэм, соёлын бусад арга хэмжээтэй уялдуулан зохицуулах;

3/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд оролцогчдыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах;

4/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа орон нутгийн байгууллагын ажилд хяналт тавах, зөвлөгөө өгөх, ажлын ололт туршлага, санаачлагыг судлах, сурталчлах;

5/ монгол бичгийн сургалтыг эрчимжүүлэх, бэрхшээлийг арилгах, хөрөнгө нөөцийг хуваарилах талаар Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6/ үндэсний хөтөлбөрийн зарим хэсгийг тодорхой төслийн хэлбэрээр төв, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх.

Шинжлэх Ухааны Академийн холбогдох хүрээлэнгүүд, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахад онол арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Б.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах байгууллага, түүний үүрэг

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэхүү хөтөрбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа дараахь үүрэг хүлээнэ:

1/ монгол бичгийн сургалтыг зохион байгуулах, эрчимжүүлэх талаар нутаг дэвсгэрийнхээ түвшинд шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөж ажиллах;

2/ үндэсний хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутагт удирдан зохион байгуулах, хяналт тавих, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал тутам дүгнэх;

3/ үндэсний хөтөлбөрийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, түүний дагуу санхүүжилт хийх, зарцуулалтад нь хяналт тавих;

4/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ, мэдээллийг бэлтгэж холбогдох байгууллагад хүргэх;

5/монгол бичгээр хэвлэсэн ном, сурах бичиг, гарын авлага, бусад материалыг нийтэд хүргэж сурталчлах.

Сум, дүүргийн Засаг дарга үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа дараахь үүрэг хүлээнэ:

1/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, улирал тутам дүгнэх;

2/иргэдийг монгол бичигт сургах судалгаа гаргаж, сургалтад хамруулах;

3/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн мэдээ гаргаж, холбогдох байгууллагад хүргэх.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үндэсний хөтөлбөрийг тухайн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

Аймаг, нийслэлийн боловсролын төв, бүх шатны сургууль, багш нар орон нутагт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг онол, арга зүйн талаар болон сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, шаардлагатай мэдээллээр хангах, бие дааж монгол бичиг сурахад нь иргэдэд туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Монгол бичгийн бүх нийтийн сургалт

А.Бүх шатны сургуулийн сурагч, оюутныг сургах

Бүх шатны сургуулийн сургалтын төлөвлөгөөнд монгол бичгийн хичээлийг оруулж, зарим хичээлийн сургалтыг монгол бичгээр явуулна.

1. Ерөнхий боловсролын сургуулийн 1-4 дүгээр ангид монгол бичгээр хичээллэсэн сурагчдад 1995-1996 оны хичээлийн жилээс эхлэн 5-10 дугаар ангид нийгмийн ухааны зарим хичээлийг монгол бичгээр заана.

2.1995-1996 оны хичээлийн жилээс сургуульд орж, кирилл бичгээр сургалтаа эхэлж байгаа сурагчдад 3 дугаар ангиас суурь боловсролын агуулгад багтаан монгол бичгийг бие даасан хичээл болгон заахын зэрэгцээ 5-10 дугаар ангид нь нийгмийн ухааны зарим хичээлийг монгол бичгээр заана.

3.Техникийн болон мэргэжлийн сургуульд тусгай хөтөлбөрөөр монгол бичгийн хичээл заана.

4.Их, дээд сургууль, коллежид монгол бичгийн хичээлийг сургалтын төлөвлөгөөнд багтаан үргэлжлүүлэн заана.

5.Багш бэлтгэдэг сургуульд судлах монгол бичгийн хичээлийн цагийг нэмэгдүүлэн, төгссөний дараа мэргэжлийн хичээлийг заахдаа монгол бичгийг хэрэглэх чадвар эзэмшүүлнэ.

Б.Насанд хүрэгчдийг сургах

Насанд хүрэгчдийг монгол бичигт сургах асуудлыг албан бус сургалтын хүрээнд хамруулж шийдвэрлэнэ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн аль ч шатны сургууль нь насанд хүрэгчдийг монгол бичигт сургах сургалт, арга зүй, зохион байгуулалтын төв байна.

Монгол бичгийн анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалтыг радио, телевиз, тогтмол хэвлэлээр явуулна.

Иргэдийг оршин буй нутаг дэвсгэр, эрхэлж байгаа ажил хөдөлмөрийн нь онцлог байдлыг харгалзан түр сургалт, бүлгэм дугуйлан, шавь сургалтын болон бие дааж суралцах хэлбэрээр зохион байгуулна.

Ажил эрхэлж байгаа хүмүүсийг дараахь дөрвөн бүлэгт хувааж сургана:

1/төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчид, төсвийн бусад байгууллагын ажиллагчид;

2/аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын ажилтан, ажиллагчид;

3/хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллагчид, малчид, тариаланчид;

4/хугацаат цэргийн алба хаагчид.

Төр, олон нийтийн байгууллагын болон архивын ажилтан, албан хаагч, ажилчдыг сургахдаа албан газар дээр нь түр сургууль, дугуйлангаар шаталсан сургалт зохион байгуулна.

Бичээч, бичиг хэргийн ажилтан бэлтгэх ажлыг төрөлжсөн түр сургуулиар гүйцэтгэнэ.

Малчид, тариаланчдыг сургахдаа тухайн орон нутгийн нөхцөл байдалд зохицуулан ерөнхмй боловсролын сургуулийн багш нар, иргэд, оюутан, сурагчдын хүчийг ашиглан бололцоотой бүх арга хэлбэрээр зохион байгуулна.

Цэрэг дайчдыг хугацаат алба хааж байгаа үед нь зохион байгуулалттайгаар монгол бичигт сургах арга хэмжээ авна.

Хот, суурин газрын хөдөлмөр эрхэлдэггүй буюу өндөр настан, гэрийн ажилтай хүмүүс, чөлөөт худалдаачдыг сургах ажлыг нутгийн захиргааны байгууллага хариуцаж, тэдний саналыг харгалзан сургалтыг бололцоотой бүх хэлбэрээр зохион байгуулна.

В.Багшлах боловсон хүчнийг бэлтгэх

Монгол бичгийн бүх нийтийн сургалтыг зохион байгуулах, түүнийг хэрэгжүүлэх гол хүч нь их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн бусад хүрээлэн, институт, тэнхим, сектор, тэдгээрийн

эрдэмтэн багш нар, нийслэл, аймгийн боловсролын төвүүд, тэдгээрийн мэргэжилтэн, арга зүйчид, бага, дунд сургууль, тэдгээрийн багш нар байна.

2001 онд багтаан бүх шатны сургуулийн багш нарт монгол бичгийг зохих түвшинд эзэмшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авна:

1/дунд сургуулийн багш нарыг 1995 оноос эхлэн тодорхой үе шаттайгаар монгол бичигт гүнзгийрүүлэн сургах;

2/их, дээд сургууль, коллежийн монгол хэл, түүх, нийгмийн ухааны багш нарыг монгол бичигт сургах.

Г.Монгол бичгийн заах арга зүйг боловсронгуй болгох

Монгол бичгийн сургалтад уламжлалт заах арга зүйг орчин үеийн заах аргаар баяжуулан хэрэглэнэ. Сургалт, арга зүйн судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн хүчээр гүйцэтгэн, нийтийн хүртээл болгож, сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хариуцан олон хувилбартайгаар боловсруулж мөрдүүлнэ.

Монгол бичиг заах арга зүйг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, энэ ажилд өөрийн орны эрдэмтэд, судлаачид болон дэлхийн монголч эрдэмтэд, судлаачдыг өргөн оролцуулна.

Т.в.Монгол бичгийн орчин бүрдүүлэх

Монгол бичиг хэрэглэх орчин бүрдүүлэх асуудлыг дараахь арга, хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1/радио, телевизээр нийт хөдөлмөрчдөд монгол бичгийн анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалт явуулах;

2/зарим тогтмол сонин хэвлэлд тэдгээрийн нэр, хаяг, телевизийн хөтөлбөр, зар сурталчилгааг монгол бичгээр гаргахын хамт монгол бичгийн нүүр, буланг дугаар бүртээ хэвлэх, монгол бичгээр дагнан гарч байгаа аливаа сонинд бүх талын дэмжлэг үзүүлэх;

3/бүх нийтэд зориулсан ном, сурах бичиг, гарын авлага, толь бичиг, түүх, уран зохиолын номыг монгол бичгээр хэвлүүлэх ажлыг үргэлжлүүлэх;

4/ажиллагчдыг монгол бичигт сургах ажлыг зохион байгуулж, тодорхой амжилтад хүрсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгыг дэмжиж, урамшуулах, сурталчлах.

Зургаа. Хэвлэх үйлдвэрийн техник технологийг шинэчлэх

Хэвлэх үйлдвэрийг компьютержүүлж, монгол бичгээр хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх ажлыг дараахь арга хэлбэрээр зохион байгуулна:

1/төв, орон нутгийн хэвлэх үйлдвэрүүдийг компьютер, цахим бичүүрээр хангаж, монгол бичгээр хэвлэх техник, технологийг нэвтрүүлэх;

2/монгол бичгээр хэвлэлийн эх бэлтгэх, компьютерийн хөтөлбөрийг боловсронгуй болгох, дэлгэрүүлэх;

3/монгол бичгийн редактор, хянагч, бичээч, компьютер, цахим бичүүрийн операторчин, хэвлэлийн үйлдвэрийн бусад мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх;

4/монгол бичгийн хэвлэх үйлдвэр, монгол бичгээр хэвлэсэн номын төрөлжсөн дэлгүүр зэргийг шинээр байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Долоо. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуурууд, үр дүнг гаргах

Ойрын 10 жилд ард иргэдийн монгол бичигт суралцсан байдал, мэдлэг, чадварын түвшингээр үндэсний хөтөлбөрийн үр дүнг тооцно. Ингэж тооцохдоо дараахь шалгуур үзүүлэлтийг хэрэглэнэ. Үүнд:

1/насанд хүрсэн хүн амын доторхи монгол бичигтэй /чөлөөтэй уншиж, бичдэг/ болсон хүний эзлэх хувь;

2/монгол бичгээр сургалт явуулах түвшинд хүрсэн багшийн хангамж;

3/монгол бичгээр ном, сурах бичиг, сонин сэтгүүлийн эх бэлтгэх боловсон хүчний болон техникийн нөхцөл бүрдсэн байгууллага, хэвлэлийн газрын эзлэх хувь;

4/монгол бичгээр хэвлэсэн сурах бичиг, гарын авлага, толь бичиг, сургалтын ном зохиолоор хангагдсан байдал;

5/монгол бичгээр хэвлэж байгаа сонин хэвлэлийн тоо, чанар;

6/монгол бичгийн хэрэглээ, орчин бий болгох талаар хийсэн ажил, түүний үр дүн.

Монгол Улсын Засгийн газар "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг дээрх шалгуур үзүүлэлтээр нэгтгэн дүгнэж цаашид авах арга хэмжээний тухай саналаа Монгол Улсын Их Хуралд оруулан шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 44 | Улаанбаатар хот

Хуучин Югославын Бүгд Найрамдах Македони Улстай дипломат харилцаа тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хуучин Югославын Бүгд Найрамдах Македони Улстай дипломат харилцаа тогтоосугай.

Дэд Дарга **Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

Улсын төвлөрсөн төсвийн 1994 оны гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 1994 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын гүйцэтгэлийг 65456450,3 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 78201116,7 мянган төгрөгөөр баталсугай.

Дэд Дарга Ж.ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

Монголбанкны 1994 оны тайлан, тэнцэл, ашгийн хуваарилалт батлах тухай

Банкны хуулийн 21, 26 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголбанкны 1994 оны тайлан тэнцлийн 1994 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн үлдэгдлийг 179197658103 төгрөг 55 мөнгөөр, ашгийг 300999942 төгрөг 56 мөнгөөр тус тус баталсугай.

2.Монголбанкны 1994 оны ашгийг дор дурдсанаар хуваарилсугай. Үүнд:

а/Улсын төвлөрсөн төсөвт 177076000 төгрөг;

б/Монголбанкны нийгмийн хөгжлийн санд 23923942 төгрөг 56 мөнгө;

в/Моснарбанкинд төлөх өрийн эх үүсвэр 100000000 төгрөг.

Дэд Дарга Ж.ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Төрөөс баримтлах мөнгөний бодлогыг хэрхэн биелүүлж байгаа тухай

Монголбанк Улсын Их Хурлаас батлсан жил бүрийн "Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын чиглэл"-ийн хүрээнд мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, зээл, хадгаламжийн хүүгийн нэгдсэн бодлого явуулах, арилжааны банкуудад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг зээлийн хэлбэрээр олгох, баримт эргэлтийг түргэтгэх талаар зохих арга хэмжээ авч, хэрэгжүүлж байна.

Монголбанкнаас авч байгаа мөнгө, зээлийн бодлогын чанартай арга хэмжээ нь улс орны эдийн засгийн байдлыг тогтворжуулах нэг нөхцөл мөн бөгөөд үүний үр дүнд инфляцийн түвшин буурч тогтворжих хандлагатай болж улсын валютын нөөц нэмэгдэж байна.

Гэвч төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын чиглэлийн хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь үндсэндээ зээлийн лимит клирингийн зээл, бэлэн мөнгөний нийлүүлэлтийн зохицуулах хүрээгээр хязгаарлагдаж, гүйлгээнд байгаа бэлэн мөнгийг бараа, үйлчилгээгээр баталгаажуулах, байгууллагад болон иргэдийн гар дээр байгаа бэлэн мөнгийг татан авч, эргэлтийг түргэтгэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдлыг хангаж худалдан авах чадварыг дээшлүүлэх, дотоодын өр авлагыг барагдуулах, зээл, хүүгийн бодлогоор үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд мэдэгдэхүйц үр дүн гарахгүй байна. Зээлийн өрийн болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн өсөлт, нийт мөнгөний өсөлтөөс түрүүлэх, хөрөнгийн баталгаагүй зээлийн хэмжээ өсөх, арилжааны банкууд эх үүсвэрээсээ хэтрүүлж зээл олгох зэрэг зохисгүй байдал гарч байна.

Монголбанкны өөрийн нь болон арилжааны банкуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурлаас урьд гаргасан тогтоолын дагуу дорвитой арга хэмжээ

авахгүй байна. Монголбанкнаас арилжааны банкуудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

Монгол Улсын Валютын зохицуулалтын хуулийн болон түүнийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлаас гаргасан тогтоолын зарим заалтыг хэрэгжүүлэх ажил удааширснаас дотоодын мөнгөний зах дээр гадаад орны валютын гүйлгээ хийгдэж, энэ нь зарим тохиолдолд төгрөгийн ханшийг бууруулах нөлөөлөл болох байдал гарч байна.

Монголбанкны системд дотоодын хяналт, санхүүгийн сахилга ихээхэн сулруулсны гадна банкны хуулийг чанд сахин мөрдөх талаар дутагдалтай байна.

Монголбанкны үйл ажиллагаанд оршиж байгаа ажлын дээрхи доголдол, дутагдлыг тус банкны удирдлагын хариуцлагатай холбон заан тэмдэглэж Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрөөс мөнгөний бодлогын талаар 1995 онд баримтлах чиглэл"-д тусгагдсан асуудлуудын хэрэгжилт удааширснаас зээлийн өр болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нэмэгдэж гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өсөлт нийт мөнгөний өсөлтөөс түрүүлэх, эдийн засаг дахь мөнгөний эргэлт удаашрах зэрэг сөрөг үзүүлэлтүүд гарч байгаад хариуцлагатай дүгнэлт хийж Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 1995 оны 9 дүгээр зөвлөмжид тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх талаар Засгийн газартай хамтран шуурхай арга хэмжээ авч дүнг 1995 оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хурлын намрын чуулганд илтгэхийг Монголбанк /Н.Моломжамц/-нд даалгасугай.

Дэд Дарга **Ж.ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

Төрийн хяналт шалгах хорооны төсвийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол улсын төрийн хяналт шалгах хорооны 1995 оны төсвийг 14524,1 мянган төгрөгөөр, үүнээс цалингийн санг 5718,1 мянган төгрөгөөр баталсугай.

2.Төрийн хяналт шалгах хорооны төсөвт зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

Дэд Дарга **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

Хууль зүйн байгууллын хорооны тавьсан саналын дагуу авах арга хэмжээний тухай

Сүүлийн жилүүдэд урьдчилан хорих байр, хорих ангиудад хоригдогсод тураал, өвчний хүндрэлээр нас барах явдал нэмэгдсэн нь хоригдогсдын нөхцөлийг зохих ёсоор бүрдүүлэх, тэдний эмнэлгийн үйлчилгээг зохион байгуулах талаар холбогдох хууль тогтоомжийн заалтыг биелүүлэх, түүнд хяналт тавих үүргээ хууль зүйн яам, хорих ял эдлүүлэх болон цагдаа, Прокурорын байгууллага хангалтгүй биелүүлсэн, эл байдлыг таслан зогсоох талаар чиглэсэн зорилготой, оновчтой, үр нөлөө бүхий ажлыг Засгийн газраас зохиож чадаагүй, ажлын хариуцлага, гүйцэтгэх сахилга шат шатандаа суларч Улсын Их Хурлын болон Засгийн

газрын тогтоолоор өгөгдсөн үүрэг хэрэгжээгүй байгаа нь дутаг дал, доголдол гүнзгийрэх шалтгаан болсон байна.

Хууль зүйн байнгын хорооноос тавьсан саналыг хэлэлцээ Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газарт дор дурдсан арга хэмжээ авахы даалгасугай:

1/хорих ангид болон урьдчилан хорих байранд хоригдогсо тураалаар нас барж байгаа шалтгааныг арилгах;

2/хууль хамгаалах байгууллагуудын ажлын уялдааг сайж руулах, тэдгээрийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох;

3/хорих ангид болон урьдчилан хорих байранд хоригдогсо тураалын шалтгаанаар нас барж байгаа ноцтой дутагдлыг тасла зогсоох талаар тодорхой арга хэмжээ авааагүй, Улсын Их Хурлаа болон Засгийн газрын тогтоолоор өгсөн үүргийг хэрэгжүүл ажиллаагүй холбогдох албаны тушаалтантай хариуцлага тооцох дүнг Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулганд танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хуулъ зүй байнгын хороонд даалгасугай.

ДАРГА **Н. БАГАБАНД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуул батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруул тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Хурлаас ТОГТООХ нь:

Цагдаагийн ерөнхий газрын болон Тагнуулын төв газрын орон гоо, зохион байгуулалтад холбогдох өөрчлөлт оруулах асуудлыг 1995 оны 8 дугаар сарын 1-ний дотор шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА **Н БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1-р сарын 04-ний өдрийн 01 тоот дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн 01 тоот дүгнэлтэд дурьдсан Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хэсгийн гурав, дөрөв, тав дахь заалтуудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцийн зарим дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулганд хэлэлцүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

1995 онд гүйлгээний сангаас аж ахуйн нэгжүүдэд худалдах алт, мөнгөний хэмжээг батлах тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрдэнэсийн гүйлгээний сангаас 1995 онд аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд худалдах алтыг 140 /нэг зуун дөчин/, мөнгийг 750 /долоон зуун тавин/ килограммаар тогтоосугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Хэрлэн, Өндөрхаан сумдыг нэгтгэж Хэрлэн сум байгуулах тухай

Хэнтий аймгийн Хэрлэн, Өндөрхаан сумдын иргэд, эдгээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчид, Засаг даргаас ирүүлсэн болон Засгийн газрын саналыг харгалзан Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Хэрлэн, Өндөрхаан сумдыг нэгтгэж, шинээр Хэрлэн сум байгуулж төвийг нь Өндөрхаан гэж нэрлэсүгэй.

2.Хэнтий аймгийн Хэрлэн сумын хилийн цэсийг хавсралтын ёсоор баталсугай.

3.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/шинээр байгуулагдсан Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох, түүний Гамгын газрыг эмхлэн байгуулах ажлыг 1995 оны 7 дугаар сард багтаан зохион байгуулах.

2/Хэрлэн сумын хуучин төвд байгуулагдсан барилга байгууламжийг байнгын ашиглалттай байлгаж, өмч хөрөнгө эзэнгүйдэж үрэгдэх явдлаас урьдчилан сэргийлэх.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралт

ХЭРЛЭН СУМЫН ГАЗАР НУТГИЙН ХИЛИЙН ЦЭС

Хэрлэн: Тал булгийн толгой, Тахилгын овоо /1516,2/, 1521,1; 387,3; 1421,5; 1377,6; 1295,5; 1418,6; 1290,3; 1369,0 тоотууд, Уртын булаг, Уртын голын зүүн эргээр уруудаж, Уртын гол, засмал замын гүлзвар, засмал замын урд захаар явж, Булган точка /271 км/, Шар хад /1228,3/, Сэрвэн /1230,0/, Хөх өндөр, Бор хушуу /1073,4/, Хэрлэн голын урд эргээр өгсөж 1028,0; 1035,2 тоотууд, Гүн нуурын зүүн эрэг /2 дугаар шон/, Хоолойн худаг, хуучин Землянка /3 дугаар шон/, Баянмөнх толгой, 1082,0 тоот, Царигийн голын зүүн эргээр өгсөж, Урт худаг, дунд худаг, 1411,8 тоот тал булгийн толгой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Хотын нэрийг өөрчлөх тухай

Хэнтий аймгийн иргэд, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Хэрлэн хотын захирагч, оршин суугчдын санал хүсэлтийг харгалзан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Хэрлэн" хотын нэрийг "Бор-Өндөр" гэж өөрчлөн нэрлэсүгэй.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

Нийслэлийн өдөр тогтоох тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын нийслэлийн өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 29-ний өдөр тэмдэглэж байхаар тогтоосугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 57 | Улаанбаатар хот

Шүүх байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсад шүүх байгуулагдсаны 70 жилийн ойг 1996 оны 4 дүгээр сарын гурав дахь долоо хоногт тэмдэглэхээр тогтоосугай.

2.Шүүх байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахтай холбогдсон зардлыг шүүхийн 1996 оны төвлөрсөн төсөвт тусгахыг Монгол Улсын Засгийн газар, Шүүхийн Ерөнхий зөвлөлд даалгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот

Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийг төр, олон нийт, шашны байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн нэгдэл, иргэдийн үүсгэл санаачилга, дэмжлэгт үндэслэн төр, нийгмийн болон соёл, шинжлэх ухаан, шашны зүтгэлтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Зөвлөлийн тэргүүн нь Монгол Улсын Ерөнхий сайд байхаар тогтоосугай.

3.Хууль тогтоомжид нийцүүлэн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлахыг Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвшөөрсүгэй.

4.Зөвлөл, түүний салбаруудбайгуулах ажлыг дэмжиж, цаашдын үйл ажиллагаанд бүх талын туслалцаа үзүүлж, харилцан ажиллахыг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 59 | Улаанбаатар хот

Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийг татан буулгах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийг татан буулгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот

Нийгмийн дэг журам хангах зарим арга хэмжээний тухай

"Нийгмийн дэг журмыг хангахад төрийн бүх шатны байгууллагын үүргийг дээшлүүлье" сэдэвт улсын зөвлөлгөөний үзэл санааг хэрэгжүүлэх нь онцгой ач холбогдолтой болохыг тэмдэглэж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн дэг журам хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор батлсугай.

2.Нийгмийн дэг журам хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлэхийг Засгийн газар, төрийн бүх шатны байгууллага, тэдгээрийн удирдлагад даалгасугай.

ДАРГА **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 60-р тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас нийгмийн дэг журам хангах үйл ажиллагааг сайжруулах талаар

1.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын ажил эрхлэх чадвар, идэвхэлэг, хариуцлага, санаачилгыг дээшлүүлж, төрийн байгууллагуудыг Төрийн албаны тухай хуулийн шаардлагад нийцсэн боловсон хүчнээр хангах, төрийн мэргэшсэн байгын

аппарат бий болгох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх

1995 оны YII сараас, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нар

2.Нийгмийн дэг журам хангах талаар тухайн жилд хийх ажлын төлөвлөгөө гарган мөрдөж, үр дүнг улирал бүр дүгнэж ажиллах

1995 оны YII сараас, Яам, тусгай газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга

3.Гэмт хэрэг, зөрчилгүй байгууллага, хамт олон, аж ахуйн нэгжийг шалгаруулан дүгнэж байх.

Жил бүр, Яам, тусгай газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга

4.Нийгмийн дэг журам хангах талаар тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх чиглэл, зорилтыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд хамт олон, иргэдийг зохион байгуулж оролцуулах

Жил бүр, Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид

5.Хууль тогтоомжид нийцүүлэн сахилгын дүрэм боловсруулан батлаж мөрдүүлэх.

1995 оны YII сараас, Яам, тусгай газар,

Хоёр. Хуулийн байгууллагуудын ажлыг сайжруулах талаар

1.Хуулийн байгууллагуудын бүтэц, тогтолцоог хянан үзэж шинэчлэх.

1995 оны IY улиралд, Хууль зүйн яам /холбогдох бусад байгууллагатай хамтран/

2.Хуулийн байгууллагуудын хамтран ажиллах чиглэл, хэлбэрийг тогтоох.

1995 оны IY улирлаас, Улсын Дээд шүүх, Ерөнхий Прокурорын газар, Хууль зүйн яам

3.Хуулийн байгууллагуудын боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх талаар журам тогтоож хэрэгжүүлэх

1995 оны YIIсараас, Хууль зүйн яам, Шинжлэх ухаан, боловсролын яам

4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг бүрт хяналт тавих, шүүхээр таслан шийдвэрлэгдэх эрүүгийн хэрэг нэг бүрт оролцох, иргэний хэрэгт прокурорын оролцоо, чанарыг сайжруулах арга хэмжээ авах

1995 оны YII сараас, Ерөнхий прокурорын газар

5.Өмгөөллийн үйл ажиллагааны ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх талаар нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

1995 оны IY улирлаас, Өмгөөлөгчдийн холбооны төв зөвлөл

6.Шүүхээр ял шийтгүүлэгчид, захиргааны хариуцлага хүлээгчдийн тухай болон эрх зүйн мэдээллийг багтаасан мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах.

1996 оны 1 улиралд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар

7.Гэм буруутай этгээдэд ял шийтгэл ногдуулж байгаа байдлыг тодорхой хугацаагаар судлан үзэж ялын бодлогыг боловсронгуй болгох арга хэмжээ авах

Жилд 2 удаа, Дээд шүүх

8.Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг тусгайлан байгуулсан сангаас онцгой тохиолдолд урьдчилан нөхөн төлж, цаашид гэм буруутай этгээдээр төлүүлэх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн үндсийг боловсруулж хэлэлцүүлэх

1996 оны 1 улирлаас, Улсын дээд шүүх, Хууль зүйн яам

9.Хуулиар тогтоосон хугацаанд хэргийг шалган, шийдвэрлэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээ авах.

Жилд 1-ээс доошгүй удаа, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах газар, хэрэг бүртгэх бусад байгууллага

10.Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж буй этгээдийг цаг тухайд нь илрүүлэх ажлын арга барилыг оновчтой болгох асуудал боловсруулах, энэ ажилд туслалцаа авах зорилгоор эзэн тогтоогдоогүй хэргийг нийтэд мэдээлж, тэднээс туслалцаа авах журмыг тогтоож хэрэгжүүлэх.

1995 оны YII сараас, Засгийн газар

11.Гэмт хэргийн гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийнхний эрх ашгийг хамгаалах арга хэмжээний төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх,

1996 оны эхний хагаст, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

12. Нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг хэрэгжүүлэх одорхой арга хэмжээний талаархи журам боловсруулах.

1995 оны IY улирлаас,
Засгийн газар

13.Хоригдлуудын ёс суртахууны хүмүүжил, эрх зүйн мэдлэг, оловсролыг дээшлүүлэх, тэднийг хөдөлмөрлүүлэх, хорих айгууллагуудын харуул хамгаалалт, дэг журмыг чангатгах, орих байгууллагуудыг хамгаалалтын техник хэрэгслээр хангах рга хэмжээ авах.

1995 оны YII сараас, Хууль зүйн яам,
Сангийн яам Хорих байгууллагуудыг
удирдах газар

14.Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай өлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

1995 оны IY улирлаас, Цагдаагийн
ерөнхий газар, Тагнуулын төв газар

15.Захиргааны болон шүүн таслах ажлын бусад төрлөөр шүүхийг агнан байгуулах боломжийг судлан үзэж холбогдох саналыг Улсын Их Хуралд оруулах

1995 оны IY улиралд, Дээд шүүх

16. Дотоодын цэргийн болон гүйцэтгэх ажлын тухай хуулийн өөлийг хэлэлцүүлэх

1995, 1996 онд, Улсын Их Хурлын
Төрийн байгууллагын байнгын хороо

17.Хуулийн байгууллагуудыг орон тоо, боловсон хүчин, техник эрэгсэл, материаллаг баазын талаар бэхжүүлэх. Түүний дотор:

1/цагдаагийн байгууллагын криминалистикийн төвийг ргөтгөх, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагыг орчин үеийн олбоогоор хангах, гал түймэр унтраах машин техникийг инэчлэх

1995, 1996 онд, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар

2/хуулийн болон цагдаагийн дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх, өндөр мэргэшилтэй багш, эрдэм шинжилгээний ажилтнаар хангах элсэлтийг нэмэгдүүлэх, хууль зүйн сургалтын нэгдсэн шалгуур тогтоох;

1996 оноос, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар Шинжлэх ухаан, боловсролын яам

3/хорих ял эдлүүлэх байгууллагуудын үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох татварт хөнгөлөлт үзүүлэх, хорих байгууллагуудын үйлдвэрлэл, хоригдлын байр, бусад ахуйн нөхцөлийг сайжруулах, материал-техникийн баазыг бэхжүүлэх талаар үзүүлэх туслалцаа жийг ерөтгөх

1995, 1996 онд, Хууль зүйн яам, Сангийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нар

4/шүүх эмнэлэг, нягтлан бодох магадлах товчоо, шинжилгээний бусад байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, зохион байгуулалтын бүтцийг судалж үзэх

1996 оны 1 улирлаас, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, хуулийн төв байгууллагууд

5/шаардлагатай зарим аймагт урьдчилан хорих байр шинээр бий болгох

1996-1997 онд, Цагдаагийн ерөнхий газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, холбогдох аймгийн Засаг дарга нар

6/шүүгч, шүүхийн бусад ажилтны ажлын ачааллын норматив аталж, түүний дагуу орон тоог тогтоож байх журам бий болгох.

7/сум дундын шүүх, сумын болон дүүргийн шүүхийг шүүн аслах ажлын, аймаг, нийслэлийн шүүхийг тогтоол гүйцэтгэлийн жлын унаагаар, шаардлагатай зарим шүүхийг ажлын байраар ангах, шүүгчдийн мэргэжлийг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг ь хангахад шаардагдах хөрөнгө олгох арга хэмжээ авах

1995 оны 7-р сараас, Сангийн яам,
Дээд шүүх

Гурав. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар

А.Хуулийн байгууллагаас авах арга хэмжээ

1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг боловсруулж холбогдох байгууллагад оруулах

1995 оны IY улиралд Засгийн газар

2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт явдлыг таслан огсоох талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн ралдаан зарлаж шалгаруулах арга хэмжээ авах

1996 оны 1 улирлаас, Хууль зүйн яам,

3.Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, гэмт эрэгтэй тэмцэх арга хэлбэрийг боловсруулах чиг үүрэг бүхий эдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын оновчтой огтолцоог тогтоох асуудлыг боловсруулах

1995 оны III улиралд, Хууль зүйн яам,
Шинжлэх ухаан, боловсролын яам

4.Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчихтэй тэмцэх клыг эрчимжүүлэх арга хэмжээ авах

1995 оны III улирлаас,
Цагдаагийн ерөнхий газар, Дэд бүтцийн яам

5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль боловсруулж батлуулах

1996 оны IY улиралд,
Засгийн газар

6. Иргэд засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжих журмыг боловсронгуй болгох

1996 оны 1 улиралд, Нийслэл, аймгийн Засаг дарга нар

7.Эрх зүйн салбарт гадаад орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх

1995 оны III улирлаас, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

8.Улсын хилийн дэглэм зөрчихийг таслан зогсоох талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал боловсруулах

1995 оны III улиралд, Хууль зүйн яам, Тагнуулын төв газар

Б.Эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар

1.Үйлдвэрлэлийг дэмжиж, хөгжүүлэх талаар ойрын үед хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

1995 онд, Худалдаа, үйлдвэрийн яам

2.Банкны хугацаа хэтэрсэн, баталгаагүй зээлийн өрийг барагдуулах нэг жилийн ажил зохиох

1995 оны YII сараас, Монголбанк

Сангийн яам, Цагдаагийн Ерөнхий газар, Ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн Засаг дарга

3.Мөнгөн хадгаламж, зээл төлбөр, тооцооны болон векселийн тухай хуулийг батлуулж мөрдүүлэх

1995 онд, Монголбанк, Улсын Их Хурлын Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо

4.Банкны зээлийг хуурамч баримт бичгээр авсан, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглан үрэгдүүлсэн, түүнийг буцаан төлөхөөс зайлсхийсэн болон валютын зохицуулалт, төлбөр тооцооны журмыг зөрчиж бусдад хохирол учруулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар Эрүүгийн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх.

1995 оны IY улирлаас, Монголбанк, Хууль зүйн яам Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Төсөв санхүү, Мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо

5.Бараа, үйлчилгээний хомсдолыг арилгах, үүний дотор мах, гурилын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах

1995 оны III улирлаас, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Худалдаа, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

6.Орон нутагт хоршооны болон хэрэглэгчдийн хоршоодын көдөлгөөнийг өрнүүлэн, энэ талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн нэгдлийн суурь дээр үүсч бий болсон компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах

1995 оны 7-р сараас, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Худалдаа, үйлдвэрийн яам, аймгийн Засаг дарга нар /Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны ерөнхий зөвлөл, Монголын эд хэрэглээний хоршоодын холбооны төв зөвлөлтэй хамтран/

7.Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх, хэрэглэгчдийг ухаалаг хэрэглээнд сургах, тэднийг сэрэмжлүүлэх сургалт, сурталчилгаа явуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх

1995 оны IY улирлаас,
Үндэсний хөгжлийн газар

8.Худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад иргэдийн оролцоотой үзлэг явуулж тэдний удирдлага, эздийн хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах

1995 оны 7 дугаар сараас, Монголын хэрэглэгчдийн эрх, ашгийг хамгаалах нийгэмлэг, Худалдаа, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

9. Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх, гааль, татварын хуулийн биелэлтийг сайжруулах арга хэмжээ авах.

1995 оны сүүлийн хагасаас, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар

В.Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах талаар

1.Хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлж, ажилгүйдлийг бууруулах, хөрөнгө оруулалт хийж ажлын байрыг ергөтгөх хөтөлбөр боловсруулан батлуулж мөрдөх

1995 оны IY улирлаас, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам

2.Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу баривчлагдсан, эрүүлжүүлэгдсэн этгээд зардлаа төлөөгүй тохиолдолд албадан хөдөлмөрлүүлж зардлыг төлүүлэх эрх зүйн үндэс боловсруулж батлуулан мөрдөх

1995 оны IY улиралд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

3.Хорих ял эдлүүлэх байгууллагаар тодорхой үйлдвэрлэл эрхлүүлж, хоригдлуудыг ажлын байраар хангах арга хэмжээ авах

1995 оны IY улиралд, Хууль зүйн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

4.Улс, аймаг, нийслэлийн хэмжээний "Залуучууд, чөлөөт цаг" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

1995 оноос, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Соёлын яам, Шинжлэх ухаан, боловсролын яам, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

Г.Насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар

1.Насанд хүрээгүй хүмүүсийг хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу нас биеийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэх боломжоор хангах арга хэмжээ авах

1995 оны IY улирлаас, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

2.Хүүхдийн эрх ашгийг хохироож, түүнийг гэмт хэрэг, зөрчил гаргах замд оруулсан эцэг, эх, асран хамгаалагчид захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг боловсруулан гаргах

1995 оны IY улиралд, Хууль зүйн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам

3.Эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтаас гарч тэнүүчлэн яваа хүүхдийн асуудлыг шалган шийдвэрлэх, түр саатуулах байр байгуулах, түүний ажиллах журмыг боловсруулан батлуулж мөрдүүлэх

1995 оны IУ улиралд, Хууль зүйн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Цагдаагийн ерөнхий газар

4.Хүмүүжлийн талаар доголдож дахин хүмүүжүүлэх зайлшгүй шаардлагатай болсон хүүхдийг сургаж, хүмүүжүүлэх тусгай сургуулийг байгуулах.

1995-1996 онд, Шинжлэх ухаан боловсролын яам

5.Хүүхэд асрах байгууллагыг өргөтгөн бэхжүүлэх арга хэмжээ авах

1995 оны IУ улирлаас, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Шинжлэх ухаан, боловсролын яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

6.Монгол ёс заншлыг судлах, хөгжүүлэн дэлгэрүүлэх, хамгаалах төрийн бодлогыг боловсруулж мөрдүүлэх

1995 оны IУ улиралд, Соёлын яам, Хууль зүйн яам /Монголын өв уламжлал-ёс заншил хөдөлгөөн, Шинжлэх ухааны академитай хамтран.

7.Монгол айл өрхийн баримтлах дэг ёсны загвар /түүний дотор айл өрхөд "удмын бичиг", айл өрхийн "алдрын тэмдэглэл" хөтлөх асуудлыг тусгах/-ыг боловсруулан хэвлэж өрх бүрт хүргэн сурталчилж нийтэд хэвшүүлэх

1995 оны IУ улирлаас, Соёлын яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам/"Монголын өв уламжлал ёс заншил"хөдөлгөөн, Шинжлэх ухааны академитай хамтран/

8.Хүүхэд хүмүүжүүлэх талаар залуу гэр бүл, эцэг эхчүүдэд риулсан бүх нийтийн сургалтыг улсын хэмжээнд тусгай төлбөрөөр зохион явуулах

1995-1996 онд, Шинжлэх ухаан, боловсролын яам, Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам

9.Гэр бүлийн хуулийг шинэчлэн боловсруулж батлуулах

1996 онд, Хууль зүйн яам, Хүн амын бодлого хөдөлмөрийн яам

10.Садар самууныг сурталчлах, эмэгтэйчүүд биеэ үнэлэх далтай тэмцэх талаар Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын хай хуулийн заалтыг биелүүлэх арга хэмжээ авах, садар муунтай тэмцэх тухай хуулийг батлуулж мөрдүүлэх

1995 онд, Хууль зүйн яам

11.Эмэгтэйчүүдээс гаргаж буй гэмт хэрэг зөрчил, ёс суртахууны жуудлыг судлан үзэж, учир шалтгааныг тогтоон тэдгээрийг слан зогсоох, сэргийлэхэд чиглэсэн ажлыг тусгай лөвлөгөөний дагуу зохиох

1995 оны 7-р сараас, Цагдаагийн ерөнхий газар, Монголын эмэгтэйчүүдийн холбоо, аймаг, нийслэлийн Засаг дарга нар

Дөрөв. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар

1.Аж ахуйн нэгж, байгууллагын болон цэрэгжүүлсэн харуул мгаалалтын тухай хууль боловсруулах

1996 оны 1 улиралд, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

2.Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудал боловсруулах

1995 оны IY улиралд, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

3.Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг болон танхайн гэмт хэрэг, архидан согтуурахтай тэмцэх талаархи хуулийн заалтыг хянан үзэж боловсронгуй болгох

1995 оны IY улирлаас, Хууль зүйн яам, хуулийн бусад байгууллага

4.Төрөл бүрийн галт зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэсрэх дэлбэрэх, хүчтэй хордуулах бодис, хутга, мэс, бусад хүйтэн зэвсгийг биедээ авч явах журмыг шинэчлэх, уг журмын биелэлтэд тавих хяналтыг хүчтэй болгох, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах арга хэмжээ боловсруулж авах

1995 оны III улирлаас, Батлан хамгаалах яам, Тагнуулын төв газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний хамгаалалтын газар, холбогдох бусад байгууллага

5.Архидан согтуурахтай тэмцэх хөтөлбөр боловсруулан батлаж мөрдөх.

1995-1996 онд, Хууль зүйн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам

6.Архинд донтох өвчтэй, мансууруулах бодис хэрэглэдэг, орчиндоо аюултай сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх эрх зүйн үндэс бий болгох

1995 оны IY улиралд, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн Ерөнхий газар

7.Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортлолтод тавих хяналтыг чангатгах, зохицуулах механизмын үйлчлэлийг сайжруулах

тогтмол, Цагдаагийн ерөнхий газар, Худалдаа, үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Татварын ерөнхий газар

Тав.Эрх зүйн шинэчлэл хийх талаар

1."Эрх зүйн шинэчлэл хийх талаар төрөөс баримтлах бодлого, эрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулж атлуулах

1995 оны III улиралд, Засгийн газар

2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх :урмын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх

1995 оны III улиралд, Засгийн газар

3.Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон усад хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах

1995 оны IY улиралд, Хууль зүйн яам, Дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Ерөнхий прокурорын газар

4.Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт руулах, улмаар захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хууль оловсруулах

1995 оны IY улирлаас, Хууль зүйн яам, Төрийн хяналтын хороо

Зургаа. Нийгмийн дэг журам хангах ажилд олон түмний оролцоог өргөжүүлэх талаар

1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, аж ахуйн нэгж, байгууллага үр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй жиллах

Жил бүр, Бүх шатны Засаг дарга, Аж ахуйн нэгж байгууллагын дарга, удирдлага

2.Нийгмийн дэг журам хангах чиглэлээр ажиллаж буй олон нийтийн байгууллагуудыг дэмжих, тодорхой чиглэлээр тэдэнтэй гэрээ байгуулж ажиллуулан, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай бол тэдгээрийн үйл ажиллагааг хамгаалж, баталгаажуулах тухай хууль гаргах асуудлыг судлан боловсруулах

1996 оны 1-р улиралд, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар

3.Орон сууцны байшин, түүний орц, гудамжинд иргэдийн жижүүр, эргүүлийг ажиллуулах журам бий болгох

1995 оны YII сараас, Бүх шатны Засаг дарга, Цагдаагийн байгууллага

4.Цагдаагийн туслах ажилтны тоог нэмэгдүүлж, үр бүтээлтэй ажиллуулах

1995 оны YII сараас, Цагдаагийн ерөнхий газар

5.Хүүхэд, залуучуудыг сахилга журамтай болгон хүмүүжүүлэхэд ахмад хүмүүсийн оролцоог ергетгех

1996 оны YII сараас Хууль зүйн яам, Монголын ахмадын байгууллагатай хамтран

Долоо. Нийгмийн дэг журам хангах асуудлыг сурталчлах талаар

1.Монгол хүний сайхан сэтгэл, уужим ухаан, хүнлэг чанар, гэмт явдлын шалтгаан, түүнийг арилгах арга замын тухай мэдээлэл сурталчилгааг ергөжүүлэх.

1995 оны 7-р сараас, Хэвлэл,
мэдээллийн байгууллагууд

2.Аллага, хулгай, дээрэм, бусад хүч хэрэглэсэн гэмт хэрэг, пашны элдэв харгис урсгал, садар самууныг сурталчилсан кино, онин, хэвлэлийг хаах, хориглох арга хэмжээний эрх зүйн үндсийг боловсруулах

1995 оны YII сараас, Хууль зүйн яам,
Радио телевизийн Хэрэг эрхлэх газар

3.Эрх зүй, ёс суртахууны сургалт-суртал нэвтрүүлгийн нэгдсэн гогтолцоо тогтоож ажиллуулах

1995 оны IY улиралд,
Хууль зүйн яам

4.Сахилга, дэг журам бэхжүүлэх талаар хийх нэвтрүүлгийн хугацааг 7 хоногт радио, телевиз тус бүр 1 цагаас доошгүйгээр нэмэгдүүлж тэдгээрт энэ чиглэлээр тусгайлан ажиллах редакцийг байгуулах

1995 оны 7-р сараас, Радио,
телевизийн хэрэг эрхлэх газар

5.Нийгмийн дэг журам хангах, хүнийг хүндэтгэн хайрлах зохиол бүтээл туурвих, түүний тодор уран сайхны болон баримтат кино бүтээх ажлыг дэмжин тусалж өрнүүлэх, олон нийтэд нөлөөлсөн чанартай сайн бүтээл туурвисан хүмүүсийг урамшуулан шагнах

1995 оны III улирлаас, Төрийн төв, орон нутгийн болон хэвлэл, мэдээллийн байгууллагууд, уран бүтээлийн эвлэл холбоод хамтран

Найм. Хяналт шалгалтын ажлыг сайжруулах талаар

1.Захиргааны хяналтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт дүрмийг хянаж шинэчлэн, эрх, үүргийг нь тодорхой

болгон, материаллаг баазыг бэхжүүлэх, улсын байцаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах

1995 оны IY улирлаас, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

2.Санхүүгийн хяналт, нягтлан бодох бүртгэлийн итгэмжлэгдсэн хөндлөнгийн хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд туслах

1995 оны IY улирлаас, Сангийн яам

3.Зарим онцгойлон үзэх асуудлаар төрийн болон хуулийн байгууллагуудын нэгдсэн хяналт шалгалтын ажлыг уялдуулан явуулж байх

1995 оны III улирлаас, Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, хуулийн байгууллагууд

Ес. Бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах талаар

1.Иргэний эрх, үүрэг, хариуцлагын нэгдмэл байдлыг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, уул бодлогыг өргөн сурталчлах арга хэмжээ авах

1996 оны 1 дүгээр улирлаас, Засгийн газар

2.Энэ зөвлөлгөөний үзэл санааг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргэж танилцуулах, үүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар тодорхой шийдвэр төлөвлөгөө гаргах, хурал зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэх зэргээр түүний биелэлтийг зохион байгуулж хангах

1995 оны YI сараас, Төрийн болон хууль хяналт, олон нийт, аж ахуйн бүх байгууллага

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 109 | Улаанбаатар хот

Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг батлах тухай

1.Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

2.Энэ зарлигийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дугаар зарлигийн хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

1.Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх орохдоо төрийн захиргааны албан хаагчийн тангараг/ цаашид "тангараг" гэх/-ийг ёс төртэйгээр өргөнө.

2.Төрийн захиргааны албан хаагч төрийн захиргаанаасаа бусад төрийн албан тушаалд шилжин ажилласны дараа төрийн захиргааны албан тушаалд эргэж томилогдвол тангараг дахин өргөхгүй.

3.Тангараг өргөх ёслолыг энэ журамд өөрөөр заагаагүй бол тухайн албан хаагчийн ажиллах төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

4.Тухайн байгууллагын боловсон хүчний асуудал эрхэлсэн нэгжийн дарга буюу тухайн байгууллагын эрх баригчийн томилсон албан тушаалтан тангараг өргөх газар, хугацаа/ өдөр, цаг/-г

байгууллагынхаа эрх баригчтай зөвшилцөн тогтоож, тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангана.

5.Тангараг өргөх ёслолын ажиллагаанд төрийн захиргааны албанд анх орж буй ажилтныг шууд захиран удирдах албан тушаалтан заавал оролцох бөгөөд тухайн төрийн захиргааны байгууллагын бусад ажилтнуудыг оролцуулна.

6.Тангараг өргөх ёслолын ажиллагааны байрыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбаагаар хүндэтгэлтэйгээр байрлуулна.

7.Тангараг өргөх иргэн тогтоосон цагт тусгайлан бэлтгэсэн байранд хүндэтгэлтэйгээр орж Монгол Улсын Төрийн сүлд рүү харан цэх зогсоно.

8.Тангараг өргөх ёслолын ажиллагааг тухайн байгууллагын боловсон хүчний асуудал эрхэлсэн нэгжийн дарга буюу тухайн байгууллагын эрх баригчийн томилсон албан тушаалтан удирдана. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон хүмүүсийг танилцуулан тангаргийн бичгийг тангараг өргөгч бүрд гардуулна.

9.Тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд хамгийн ахмад нь Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчийн тангаргийг цээжээр дээдлэн дуудаж бусад нь дагалдана. Тангараг өргөж байх үед уг ёслолд оролцогчид босож хүндэтгэнэ.

10.Тангаргийг цээжээр дээдлэн дуудаж дууссаны дараа тангараг өргөгч Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёслож зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна.

11.Тангараг өргөсөн иргэн нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдтэй, түүний дор "Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчийн тангараг" гэсэн үгтэй, дотор талдаа Монгол Улсын Төрийн албаны тухайн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчийн тангаргийн бүрэн бичвэр бүхий тангаргийн бичигт тангараг өргөсөн он, сар, өдөр, газар, овог, нэрээ бичиж гарын үсэг зурна.

12.Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан төрийн захиргааны албан хаагчид баяр хүргэж тангараг өргөх ёслолын ажиллагааг хаана.

13.Тангаргийн бичгийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.

14.Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тодорхой эмдэглэл хөтөлнө.

15.Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын яамны төрийн нарийн бичгийн даргаар болон эдгээртэй адилтгах албан тушаалд ах томилогдогчдын тангараг өргөх ёслолыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 110 | Улаанбаатар хот

Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тайх уламжлалыг сэргээх санаачилгыг дэмжих тухай

1.Монголчууд эртнээс нааш Богд хан хайрхан уул, Хан Хэнтий ул, Отгонтэнгэр уулыг тайж ирсэн уламжлалыг сэргээн дээрх улсыг Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт аасныг харгалзан эдүгээ цагийн байдалд нийцүүлэн тайх талаар лон түмнээс гаргаж байгаа санаачилгыг дэмжсүгэй.

2.Хан Хэнтий уулыг тайхад Чингис хааны зарлигийг ламжлуулан дагаж Монгол Улсын бүх цэргийн хар сүлдийг энгүүлэн тахих ёслолыг хамтатган гүйцэтгэх нь зүйтэй гэж зсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

ТАНИЛЦУУЛГА

Монголчууд эрт дээр үеэс эхлэн Богд хан хайрхан, Хан Хэнтий, Отгонтэнгэр уулыг тахисаар иржээ. Судлаачдын үзэж байгаагаар 1778 онд Богд Жавзандамба хутагтын Их хүрээ Богд хан уулын тус газар буудаллаж энэ уулыг дархлан тахилгатай болгожээ. Бурхан Халдун уулыг Хияд боржигины өвөг Бодончарын үеэс тахиж, Чингис хааны үед хамаг монгол хийгээд монголын их гүрэн, бүх монгол туургатны сүлд уул болгосон бөгөөд Хан хэнтий уулыг 1818 оноос албан ёсоор тахидаг болжээ. Отгонтэнгэр уул нь Монголчуудын эртний өвөг дээдсийн тахилгын газар-Этүгэн буюу газар эх гэсэн нэртэй байгаад уг нэр нь хожим Отгонтэнгэр гэгдэх болсон ажээ.

1911 онд Монгол орон манжийн ноёрхлоос ангижирсны дараа Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын хууль зарлигаар Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг жил бүр тайхаар тогтоож энэ тайлгад төрийн ямар албан байгууллага, тушаалтан оролцох, улсаас ямар хөрөнгө зардал гаргаж байх зэрэг асуудлыг журамласан байна. Эдгээр тахилга нь Богд хаан таалал төгссөн 1924 оноос зогсож гагцхүү ламын шашны ёсоор тахих зан үйлийг алдаг оног хийсээр 1930-аад оноос бүрмөсөн зогсчээ.

1990-ээд оноос хойш улам жлал, зан заншлаа сэргээх гэсэн олны хүсэлт, Монголын ногоонтны хөдөлгөөний санаачилгаар 1992 онд Бурхан Халдун, 1994 онд Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 355 жилийн ойгоор Богд хан хайрхан уулын оргил Цэцээ гүнийг тахижээ. 1994 онд болсон Монгол туургатны овоо тахилгын сангийн олон улсын бага хурлаас Монгол түмний бахархал болсон домогт Бурхан Халдун буюу Хан Хэнтийн ноён оргил Хайрханыг монгол угсаатны сүлд хийморь болгон тогтмол тахиж байхыг санал болгожээ.

Монголын ногоонтны хөдөлгөөн, Дэлхийн монголчуудын холбооноос дээрхи гурван уулыг тахилгатай болгох хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчид тавьсан байна.

Ер нь уул овоог янз бүрийн хэмжээнд тахих явдал элбэгшиж байгаа энэ үед улс нийтийн болон аймаг, орон нутгийн чанартай тахилга үйлддэг ёс горимтой байсан түүхэн уламжлал зан заншлаа сэргээх нь чухал хэмээн үзэж байна.

Эдгээрийг үндэслэн Богд хан хайрхан, Хан Хэнтий, Отгонтэнгэр уулыг Монгол Улсын хэмжээгээр тайж ирсэн түүхэн уламжлалаа

сэргээх талаар гаргаж байгаа олон түмний санаачилгыг дэмжиж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гаргах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Энэ арга хэмжээ нь монгол төрт ёс, оюуны соёл, зан заншлынхаа үнэ цэнэтэй, дэвшилттэй бүхнийг өвлөн авах, байгаль орчноо хайрлан хамгаалдаг ардын уламжлал, ёс заншлыг сэргээж бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам хэмээн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үндсэн чиглэлд заасныг хэрэгжүүлэх үйлсэд чухалач холбогдолтой болох билээ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 113 | Улаанбаатар хот

Чүлтэмсүрэнгийн Жаргалсайханд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай

Хүүхдийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж есвөр үеийнхэнд бүжгийн урлагийн анхны мэдэгдэхүүн эзэмшүүлэх, тэдний авьяас билгийг нээж хөгжүүлэн мэргэжлийн чиг баримжаа олгох, гоо сайхны хүмүүжлийг төлөвшүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын хүүхдийн ордны бүжгийн дугуйлангийн багш Чүлтэмсүрэнгийн Жаргалсайханд Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот

Хүүхдийн соёл хүмүүжил, халамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Хүүхдийг амьдралд бэлтгэх, шинийг эрэлхийлсэн бүтээлч ухаанд сургах, үндэсний бахархал, зан үйл, нандин уламжлалаа өвлөн хөгжүүлэх шударга хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэх зан чанар төлөвшүүлэх нь маш чухал чиг үүрэг, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гол зорилт болж байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгох нь:

1. Хүүхдэд зориулан соёл урлагийн үйлчилгээ явуулдаг байгууллагыг аль болохоор төрийн ивээлд байлгаж, хүүхдийн хөгжил, хүмүүжил, гоо зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном хэвлэл, уран бүтээлийг олшруулах, чанарыг нь сайжруулах зорилгоор дор дурдсан нөхцлийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэсүгэй:

а/ Монгол телевизэд хүүхдийн нэвтрүүлгийн студи байгуулах, суваг шинээр нээх, радиогийн нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлэх;

б/ улсын хүүхдийн төв номын санг зориулалтын байраар хангах;

в/ сургуулийн өмнөх насны болон сургуулийн бага, дунд, ахлах насны хүүхдэд зориулсан "Оюун түлхүүр", "Залгамжлагч" сэтгүүл, "Хойчийг залгамжлагч" сонинг хэвлэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх;

г/ хүүхдийн театр, киноны хүрээлэн, Хүүхэлдэйн театр, номын сан, Радио, телевизийн нэвтрүүлгийн редакци зэрэг соёл урлагийн байгууллагын техник хэрэгсэл, төхөөрөмжийн хангамжийг сайжруулах;

д/ хүүхдэд зориулсан уран зохиол, шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон орчуулгын ном, хүүхдийн уран сайхны ба баримтат кино, мультфильм, дүрс бичлэгийн кино, драмын, хүүхэлдэйн, телевиз, радиогийн жүжиг зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагын бүтээлүүдийг улсын захиалгын дагуу Соёл, урлаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлж байх;

е/ хүүхдэд зориулсан соёл, урлагийн байгууллагуудад ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтарч олон улсын арга хэмжээ зохион байгуулах ажлыг төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байх.

2. Цэцэрлэгийн насны хүүхэд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд байгаль орчноо танин мэдэх, хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга ажиллагаа, дадлага, туршлага, мэргэжлийн баримжаа олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байх, түүнчлэн хүн амын дунд байгаль орчныг хамгаалах сурталчилгааны ажил явуулах арга хэмжээг Монголын байгаль орчныг хамгаалах холбоо, "Байгаль эх" төв зэрэг олон нийтийн болон бусад байгууллагатай хамтран авч ажилласугай.

3. Эцэг эхийн хараа, хяналтаас гарсан хүүхдийг халамжлан хүмүүжүүлэх, тэднийг амьдралд бэлтгэх, ажил мэргэжлийн ба-

римжаа олгох зорилгоор Хүүхдийн сургалт, хүмүүжил-үйлдвэрлэлийн төв зохион байгуулж ажиллуулахын хамт гэр орон, эцэг эхээсээ удаан хугацаагаар дайжсан, тодорхой хаяггүй хүүхдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах, тэдэнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон асуудлыг судалж шийдвэрлэсүгэй.

4. Хүүхдийн амралт, чөлөөт цагийг бүтээлч хэлбэрээр зохион байгуулах, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэхэд чиглэсэн хүүхдийн соёл, хүмүүжлийн ажлын материалаг баазын ашиглалтыг сайжруулах, өргөтгөх, шинээр бий болгох арга хэмжээ авахын хамт хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, урамшуулах арга хэмжээ авсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 6 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 122 | Улаанбаатар хот

Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай

Монгол Улсаас Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Ишцогийн Очирбалыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 6 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 123 | Улаанбаатар хот

Ишцогийн Очирбалыг элчин сайдаар томилох тухай

Монгол Улсаас Оманы Султант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Ишцогийн Очирбалыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 6 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 126 | Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгчдийг томилох тухай

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Базаррагчаагийн Оюунбилэгийг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчээр, Төмөрийн Өнөрийг Ховд аймгийн шүүхийн шүүгчээр, Бандийн Одонцэцэгийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г. Совд даргалж, гишүүн Г. Нямдоо, Л. Баасан /илтгэгч/, Ц. Цолмон, Н. Жанцан, Ж. Бямбаа, С. Жанцан, Д. Чилхаажав, Ч. Энхбаатар нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргад Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанаар: "1. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн . . . Улсын их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн,

2. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн,

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3 заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн,

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 45^2 дугаар зүйлийн Улсын Их Хурлаар Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхтэй холбоотой 1, 2, 3, 4 заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн,

5. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолын "Монгол Улсын Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй" гэсэн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн , 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн,

6. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 51, 54, 56 дугаар зүйлүүдийн 1 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна" гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01 тоот дүгнэлттэй маргааныг эцэслэн шийдвэрлэлцэв.

Цэцийн хуралдаанд маргагч талуудыг төлөөлөн улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Лүндээжанцан, Ё. Адилбиш, хамдол гаргагч иргэн Дондовын Ламжав нар оролцов.

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн иргэн Д. Ламжав Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

1. Улсын их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн ... Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ гэсэн заалт нь Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн "бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар дахин хэлэлцэж шийдвэрлэнэ, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх өгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ", 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн "... Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь дурдсан маргаан нь Үндсэн хууль, бусад хуулийг сахиулахтай холбогдон гарч болох өгөөд энэ тухай Цэцийн буюу аль нэг шатны шүүхийн шийдвэр гарч болно.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... Уг илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсоно", 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... хэрэв Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан

үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг заавал сонсоно" гэсэн заалт Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн Цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна" гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл гараагүй нөхцөлд Цэцээс дүгнэлт гарахгүй тул Цэцийн дүгнэлтийг шууд дуудан сонсох хууль зүйн үндэслэл байхгүй юм.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараахь шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх,

2. Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх,

3. Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх" гэсэн заалт Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт болон 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна" гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь Үндсэн хуулийн холбогдох заалтууд ёсоор Ерөнхийлөгчийг огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байгаа нь Цэцийн дүгнэлтээр нэгэнт тогтоогдсон үед л энэ асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцэх бөгөөд хэлэлцэх явцад Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх ёсгүй. Гэтэл хэлэлцэхээр хуульчилсан нь Үндсэн хуулийн дээрх хоёр заалтыг зөрчиж байна.

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 45[2] дугаар зүйлийн нэг дэх хэсгийн "Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гарсан ... Цэцийн дүгнэлтийг ... Цэцийн дарга түүний итгэмжилснээр ... Цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна" гэсэн заалтаас өөр Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай заалт энэ хуульд ороогүй байна.

Тодруулан хэлбэл Улсын Их Хурлын авч хэлэлцэх ёстой арван эрлийн Цэцийн дүгнэлтээс хууль, Улсын Их Хурлын бусад ийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал эрхэн авч хэлэлцэхийг дээрх зүйлд тодорхой заасан боловч лдсэн найман төрлийн дүгнэлтийг Улсын Их Хурлын тухай уульд заагаагүй байна. Улсын Их Хурлаар хэлэлцэх ёстой эцийн дүгнэлт ийнхүү өргөсгөл тусгагдсан атлаа Улсын Их урлаар хэлэлцэх ёсгүй Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 ахь хэсэгт /3, 4-т/ заасны дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг лсын Их Хурал хэлэлцэхээр хуульчилсан тухай дээр өгүүлсэн илээ. Улсын Их Хурлын байнгын хороо /Дотоод асуудлын/ 1994 ны 2 дугаар сарын 8-ны өдрийн хурлаараа гишүүн Ц. Төрмандах ндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн хай Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзэж энэ гнэлтээ Улсын Их Хуралд оруулжээ.

Гишүүд Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал үүн хэлэлцээд эцсийн шийдвэр гаргах эрхтэй эсэх талаар аргалдсан боловч ганц ч удаа санал хураагаагүй бегөөд дараа энэ асуудлаар тайлбар гаргахаар болж уг асуудлыг хаажээ.

Харин С. Зориг Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн нэг дэх эсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлийн талаар дахин хүчтэй маргаан өрнүүлсний эцэст санал хураж эцийн дүгнэлтийг зөвшөөрчээ. Ийнхүү Үндсэн хуулийн 66 дугаар йлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар цаашдаа Үндсэн улийн Цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх эх тухай санал хураж шийдэж байна гэсэн жишиг тогтлоо ж гишүүд үзжээ. Улсын Их Хурлаас Ерөнхий прокурор Н. нбаяр Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн тухай Цэцийн гнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэсэн /88 дугаар/ тогтоол ргасан нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их ралд зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн ийдвэр гаргана гэдгээ эрх зүйн ахтын хэмжээнд албан ёсоор эрхийлсэн анхны тохиолдол юм.

Үндсэн хууль зөрчсөн шийдвэрт хүрэх тулгуур нь Улсын Их рлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 3 дахь заалт болсон дээрх хоёр баримтаас харагдаж байна.

5. Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Дараахь тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна. 1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон. 2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасан,

... 5. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргана" гэсэн заалтаас өөр Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах тухай заалт энэ хуульд байхгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын үйлчилгээг зогсоож эсхүл 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт зөрчигдөж байна. Учир нь Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу Улсын Их Хурлын даргыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Цэцээс дүгнэлт гаргах шаардлагатай болох үед Улсын Их Хурлын тухай хуулиас баримтлах заалт олдохгүй тул Цэц Үндсэн хуулийг сахиулах баталгаа болохынхоо хувьд Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, Үндсэн хууль болон зарим хуулийн заалтыг төсөөтэй хэрэглэн огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байна гэж тогтоогоод Улсын Их Хуралд оруултал энэ өргөдлийн 4-т дурдсан тохиолдолтой адил Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд Цэц Улсын Их Хурлын тухай хууль зөрчжээ гэсэн дээр санал хураж баталгаажуулаад энэ санал хураалтаа эрх зүйн баримт болгон үйлдэх шаардлагагүй гэж үзэж болох юм.

Ийм тохиолдолд Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт зөрчигдөж байгаа нь ойлгомжтой бөгөөд энэ санал хураалтын дүнг Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хүрээнд хамрахгүй бол Үндсэн хууль зөрчигдсөн хэвээр хоцорч Үндсэн хуулийг сахиулах баталгаанд хохирол учирна. Хэрэв хамааруулбал Үндсэн хууль зөрчигдсөнийг залруулах боломж үлдэнэ.

6. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалт Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна, Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт

нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн зааltыг зөрчиж байна. Учир нь Улсын Их Хурлын тухай хуульд заасан ёсоор Улсын Их Хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах албан тушаалыг цалингүйгээр эрхэлж болохоор заажээ.

7. Улсын Их Хурлын тухай хуулийн 45.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана" гэсэн зааltыг би урьд нь уг зүйлийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн тухай гарсан Цэцийн дүгнэлтийн тухай асуудал гэж ойлгосон нь буруу байжээ. Учир нь Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх зааltын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн шийдвэр гаргаж болох эрх зүйн үндэслэл нь чухамхүү 45.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болох нь Улсын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс тодорхой байна. Ийнхүү 45 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг ... хянан шийдвэрлэнэ" гэсэн зааltуудыг зөрчиж байна.

8. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын "Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зааltыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй" гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зааltуудыг тус тус зөрчиж байна.

9. Улсын Их Хурлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна.

Ил санал хураалтыг гар өргөж эсхүл цахим тооцоолууураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоо-

цоолуур ашиглан явуулна. Тухайн хуралдаанд оролцсон 5-аас доошгүй гишүүний шаардсанаар эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хурааж болно. Ийнхүү нэрээр санал хураахдаа хуралдаан даргалагч цахим тооцоолуур дээр бичигдсэн эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг танилцуулна" гэсэн заалт Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь цахим тооцоолуураар санал хураахыг ил санал хураалт ч, мөн нууц санал хураалт ч мөн гэж үзээд хурал даргалагчийн хувьд хэн яаж саналаа өгсөн нь мэдэгдэж байдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Энэ нь нэрээр санал хураах гэсэн ойлголт, түүнтэй холбогдсон заалтуудаар /Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 6 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг/ нотлогдож байна.

10. Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4-ийн "хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн саналыг" хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ заавал тусгахаар заасан нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчиж байна. Учир нь зөвхөн нэрээр санал хураахад гишүүдийн санал өгсөн байдал гишүүн бүрээр гарч байхаар заасан, цаг хожихын тулд санал хураалт үндсэндээ компьютероор явагдсан санал хураалтын дүнг хуралдааны явцын тэмдэглэлд тусгахгүй байгаа нь Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрт гишүүн хэрхэн санал өгч байгаагаа мөн чанартаа нууц болгож байна.

Ингэснээр тухайн гишүүн өргөсөн тангарагтаа хэр зэрэг үнэнч байгааг сонгогчдын зүгээс бодитой хянах хамгийн чухал хөшүүргийг ажиллахгүй болгожээ. Үүгээр төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад үл хамаарах асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг Монгол Улсын иргэн баталгаатай эдэлнэ гэсэн Үндсэн хуулийн заалт зөрчигджээ. Улсын Их Хурлын гишүүний санал өгөлтийн талаар бодитой мэдээ цацагдахгүй байгаа нь нам болон түүний зүгээс сонгогчдын элдвээр төөрөгдүүлэх өргөн бололцоо бий болгож улмаар засгийн эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалт эцсийн дүнд хоосон уриа болоход хүрнэ. Мөн Улсын Их Хурлын үй

ажиллагаа сонгогчдынхоо өмнө ил тод байх тухай ардчилсан ёсны хамгийн чухал зарчим алдагдаж байна.

11. Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ" гэсэн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан иргэдийн төр, түүний байгууллагаас хууль ёсоор хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хийх, хүлээн авах эрхийг зөрчиж байна.

12. Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан "хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг зөвхөн уг ажлыг эрхлэх ажилтан эсхүл архивчийн дэргэд үзэж сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно" гэсэн заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус зөрчжээ.

Учир нь Улсын Их Хурал болон Байнгын хороодын хуралдааны явцын тэмдэглэлийг хориг саадгүй үзүүлдэг байлаа ч гэсэн уг тэмдэглэлийн талаар эргэлзээ гарч болно. Энэ тохиолдолд сонирхсон иргэн, зохих албан тушаалгүй бол эргэлзээгээ тайлах бололцоо Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан ёсоор бүрэн хаагдсан байгаа нь Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг албан тушаалаар нь ялгаварлаж болохгүй гэсэн Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт зөрчигдөж байна гэжээ.

Нийслэлийн иргэн Ц. Цэрэнжав Цэцэд хандаж гаргасан гомдолдоо: Шинэ Үндсэн хуулиар төрийн дээд байгууллагуудын эрх, үүргийг зааглан өгч, гагцхүү хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байхаар тогтоосон.

1. Монгол Улсын үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-ын гурав дахь хэсэгт "Ерөнхийлөгч, улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх дүгнэлтийг" гагцхүү Үндсэн хуулийн Цэц гаргах эрхтэй. Өөр ямар нэг байгууллага, түүний дотор Улсын Их Хуралд энэ эрх хуулиар олгогдоогүй юм.

2. Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг энэ тогтоол зөрчлөө. Уг зүйлд "прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж шүүх хуралдаанд төрийн өмнөөс оролцоно" гэжээ. Улсын Их Хурал тогтоол гаргаж, Улсын прокурорын газраас явуулсан мөрдөн байцаах ажиллагааг хамгаалснаараа Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчлөө. Иймд Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын талаар зохих шийдвэр гаргаж өгнө үү" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01 тоот дүгнэлтээрээ:

Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "... Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ" гэсэн заалт нь Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бүх шатны шүүх, хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шийдвэр, шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ". Мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэсэн заалтуудыг;

Хоёр. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах, бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн заалтыг;

Гурав. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараахь шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна.

1. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2. Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн үндэслэл шалтгааныг зөв тогтоосон эсэх.

3. Ерөнхийлөгч бүрэн эрхээ зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар огцруулна" гэсэн заалтыг;

Дөрөв. Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн Цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Үндсэн хуулийн Цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна" гэсэн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч, санал дүгнэлт гаргаж болно".

3 дахь хэсгийн "Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана".

4 дэх хэсгийн "Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Үндсэн хуулийн Цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.

1. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2. Ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал түүний гишүүнийг ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв

байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэх байгаа эсэх" гэсэн заалтыг;

Тав. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын "Монгол Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй" гэсэн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн", уг хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зургаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 51, 54, 55 дугаар зүйлүүдийн 1 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байх тул иргэн Д. Ламжавын энэ талаарх гомдлыг хэрэгсэхгүй болгосугай гэж шийдвэрлэжээ.

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 01 тоот дүгнэлтийн нэг, хоёр дахь хэсгийг хүлээн зөвшөөрч, гурав, дөрөв, тав дахь хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзжээ. Уг тогтоолд Цэцийн дүгнэлтийн 6 дахь хэсгийг хэрхэн үзэж байгаа талаар дурдаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга 1995 оны 8 дугаар сарын 5-ны 8 дугаар тогтоолоороо Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын хоёр дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж магадлан шийдвэрлэх ажиллагаа үүсгэжээ.

Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Л. Баасан 1995 оны 9 дүгээр сарын 1-нд 12 тоот тогтоол гарган уг маргааныг Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдаанд шилжүүлжээ.

Гомдол гаргагч иргэн Д. Ламжав Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Цэцээс дүгнэлт гаргасны дараа би өөрийн хүсэлт хангагдсан эсэхийг шалган тулгахад Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 1-ээр нэхэмжлэл гаргаагүй, 55-ын 2 ба 3 дугаар зүйлийн 1-ээр нэхэмжлэл гаргасан, 54 дүгээр зүйлийн 4-ийн 4-өөр нэхэмжлэл гаргасан, 55 дугаар зүйлийн 2, 3-ын заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлтэд дурдаагүй, Цэцээс дүгнэлт гаргаагүй байна. Энэ талаар байнгын хорооны дүгнэлтэд үндэстэй дурджээ.

Би Улсын Их хурлын тухай хуулийн 45^2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдох асуудлаар өргөдөл гаргасан юм. Би өргөдлийнхөө шаардлагыг тодруулах зорилгоор үүнийг тайлбарлаж байна гэв. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ё. Адилбиш тайлбарлахдаа: Иргэн Д. Ламжав Үндсэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой чухал асуудлууд хөндөж тавьсанд талархалтай байгаагаа илэрхийлье.

1. Үндсэн хуулийн Цэцээс 1994 оны 12 дугаар сарын 16-нд Улсын Их Хурлын даргын нэр дээр ирүүлсэн албан бичиг, түүнд иргэн Ламжавын зарим өргөдлийг хавсарган ирүүлсэн. Тэр өргөдөлд Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн талаар гомдол гаргаагүй юм билээ. Гэтэл Цэц дүгнэлт гаргасан харагдсан байна.

2. Цэцийн дүгнэлтийн 6 дахь хэсгийн талаар Улсын Их Хурал хэлэлцсэн боловч Үндсэн хуулийн Цэц нэгэнт хянан шийдвэрлэсэн. Иймд энэ асуудлаар тусгайлан тогтоол гаргах, тогтоолд заалт оруулах шаардлагагүй гэж үзсэн. Гишүүн Ж. Бямбадорж санал гаргасан. Гишүүдийн саналаар тусгайлан акт гаргахгүйгээр дээрх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэсэн болно.

3. Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуульд зааснаар 21 асуудлаар дүгнэлт гаргах ёстой. Энэ дотроос зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар Цэц дүгнэлт гаргасан үед Улсын Их Хурал түүнийг яаж хэлэлцэх вэ гэдэг журмыг Улсын Их Хурлын тухай хуулийн 45^2 дугаар зүйлд заасан. Энэ зүйлд Цэцээс дүгнэлт гаргах бүх асуудлыг багтаагаагүй. Энэ бол Улсын Их Хурлын тухай хуульд оруулах өөрчлөлтөөр зохицуулагдах зүйл юм. Энэ талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан.

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийн 35-р зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй. Учир нь Цэц дүгнэлт гаргасан үед Улсын Их Хурал түүнийг сонсоод Ерөнхийлөгчийг огцруулна гэдэг асуудал байж болохгүй.

5. Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэдэг асуудал бий. Энэ талаар Улсын Их Хуралд гурван янзын практик бий. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-ын 3, 4-т заасан асуудлаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэрхэн хэлэлцэх вэ? эсхүл хэлэлцэхгүй байх уу? гэдэг асуудал одоогоор эрх зүйн зохицуулалтгүй байгаа болно. Энэ бол хуулиар зохицуулбал зохих асуудал болно. Энэ талаар Улсын Их Хуралд оруулсан Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан болно.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Лүндээжанцангаас:

1. Адилбиш гишүүний тайлбарыг дэмжинэ. Үндсэн хуулийг амьдралд хэрэгжүүлэх асуудлаар иргэн Д. Ламжав олон удаа хүсэлт гаргасан Цэц хэд хэдэн удаа дүгнэлт гаргажээ. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан механизм ажиллаж байгаагийн илрэл болно.

Гэхдээ Улсын Их Хурлын тухай хуулийг боловсронгуй болгох асуудал бий. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйл Үндсэн хуулийг зөрчөөгүй юм шүү. Яагаад гэвэл Улсын Их Хурал бол Үндсэн хууль тайлбарлах эрхийнхээ дагуу Үндсэн хуулийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийг Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлд дэлгэрүүлэн тодотгосон байна.

Мөн хуулийн 45^2 дугаар зүйл, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоол аль аль нь Үндсэн хуулийг тодотгох зорилгоор гарсан зүй ёсны актууд мөн. Нэгэн зүйл нэмж тайлбарлахад Ерөнхийлөгчийг огцруулах тухай Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал сонсоод асуудал шийдвэрлэнэ гэвэл Их Хурал маань компьютер болно биз дээ.

2. Монгол Улсын Үндсэн хуулиар тогтсон төрийн тогтолцоо бол бат бэх байх ёстой. Үүнийг бэхжүүлэх талаас нь Цэц цаашид дүгнэлт гаргахдаа бодолцоно байх гэдэгт найдаж байгаагаа илэрхийлье гэв.

Хянавал:

Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн материалаас үзвэл Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын 2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн болох нь тогтоогдов.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар үүссэн маргааны талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж уг дүгнэлтийн хууль зүйн үндэстэй эсэхийг шийдвэрлэх тухай заалт Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Мөн хуулийн 45[2] дугаар зүйлд тусгагдсан ба эл зохицуулалтын дагуу Улсын Их Хурлын гишүүн С. Зориг, Улсын ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж, Улсын ерөнхий прокурор Н. Ганбаяр Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, мөн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоол гаргажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1-д буй "Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг сахиулах баталгаа мөн" гэсэн заалт; мөн зүйлийн 2-т буй "Үндсэн хуулийн Цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна" гэсэн заалт; мөн хуулийн 35 дугаар зүйлийн 2-т буй "Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна" гэсэн заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 3-т буй "Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн Цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана" гэсэн заалтаас үзэхэд Үндсэн хуулийн Цэцээс Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэхгүй нь тодорхой байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т дурдсан асуудлаар гарах Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж зөвшөөрөх эсэх тухай асуудал бол Цэцээс Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрхийг үгүйсгэх буруу практик тогтож байна.

Хоёр. Улсын Их Хурлын тухай хуулийн 45^2 дугаар зүйлд Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай заахдаа зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаарх Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх агуулга тусгагдсан байна. Гэвч уг зүйлийн гурав дахь хэсэг нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 4-т заасан асуудлаар гаргасан Үндсэн хуулийн Цэцийн бүх дүгнэлтүүдийг хэлэлцэхэд хэрэглэх практик тогтох үндэслэл болсон нь Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны явцад нотлогдов.

Гурав. Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01 тоот дүгнэлтэд иргэн Д. Ламжавын Цэцэд хандаж тавьсан хүсэлт буюу Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн талаар тодорхой шийдэлт гаргаагүй байна. Иймд Цэцийн 01 тоот дүгнэлтийн 6 дахь хэсэгт зохих өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Дөрөв. Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолд Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 01 тоот дүгнэлтийн 6 дахь хэсгийг хүлээн авсан эсэхийг заагаагүй байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3, 4 Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, мөн хуулийн 45^2 дугаар зүйлийг бүхэлд нь;

2. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын хоёр дахь заалтыг; Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хоёр дахь заалтуудыг тус тус хүчингүй болгосугай..

3. Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний дрийн 01 тоот дүгнэлтийн "зургаа" гэсэн хэсгийг "Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1 мөн хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна" гэж өөрчлөн найруулсугай.

4. Энэхүү тогтоол нь гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГА **Г. СОВД**

ГИШҮҮД **Г. НЯМДОО**
Л. БААСАН
Ц. ЦОЛМОН
Н. ЖАНЦАН
Ж. БЯМБАА
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ч. ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 8 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

Цагдаагийн байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 1995 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 14.00 цагт зөвлөлдөх тасалгаанд /Төрийн ордны 251 дүгээр өрөөнд/ үйлдэв. Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Н. Жанцан даргалж, гишүүдэд Л. Баасан, Ж. Бямбаа /илтгэгч/, Д. Чилхаажав, Ч. Энхбаатар нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Тус хуралдаанд маргагч талыг төлөөлж иргэн А. Энхбат, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн С. Нарангэрэл нар оролцов.

Иргэн А. Энхбат 1995 оны 4 дүгээр сарын 26-нд Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх /тагнах/ ажлын журмыг Цагдаагийн төв байгууллага цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх журмыг Монгол Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллага батална гэж тус тус заасан нь "Иргэний болон улс төрийн эрхийн тухай" олон улсын пактын "... хэнийг ч дур мэдэн баривчилж буюу цагдан хорьж болохгүй ... хуулиар тогтоосон үндэслэл, журмаас бусад аль ч технолдолд хэнийг ч хорьж болохгүй ... хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, түүний орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууцад дур мэдэн, хууль бусаар халдах, мөн түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй; түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн "... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно

... иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэсэн заалтууд зөрчиж байна.

2. Хуулийн 45 дугаар зүйлд "... хамгаалах тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийн жагсаалт, бүх төрлийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг Цагдаагийн төв байгууллагын дарга дангаараа буюу Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн батална" гэсэн заалт нь хүний эрх, эрх чөлөөг тодорхой тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болох, түүнчлэн хууль тогтоох эрхийг зөвхөн Улсын Их Хуралд хадгалах тухай Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна. Ингэснээр Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дугаарт "... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно". Монгол Улсын үндсэн хуулийн 20 дугаар зүйл "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэсэн тодорхой заалтууд зөрчигдөж байгаа юм гэжээ.

Энэхүү өргөдлийн утгатай Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн С. Нарангэрэл тодорхой танилцаад дараахь тайлбарыг 1995 оны 6 сарын 10-нд гаргаж өгөв. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг урьд нь зарлиг, тогтоол, тушаалаар зохицуулж байсан бол 1993 онд Улсын Их Хурлаас баталсан хууль нь анхны хууль болж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуультай нийцүүлэхэд чухал алхам болсон. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж иргэн А. Энхбатын гаргасан өргөдөл үндэстэй бус болох нь дараахь байдлаар нотлогдож байна.

1.1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх /тагнах/ ажлын журмыг Цагдаагийн төв байгууллага батална" гэсэн үг байхгүй. /Төрийн мэдээлэл, 1993, N8, 944 дэх тал/, атал тэр нэмж бичээд Монгол Улсын үндсэн хуулийн Цэцэд явуулсан.

2/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлыг хуулиар зохицуулна" гэсэн үгийг иргэн А. Энхбат "Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх /тагнах/ ажлын журмыг Цагдаагийн төв байгууллага батална" гэж өөрчлөн найруулсан.

2.1. Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах үндэслэл, журмыг эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хариуц-

лагын тухай хуулиар зохицуулдаг нь хэн хүнд ойлгомжтой баймаар.

2. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь "Цагдаагийн байгууллага нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас дээр дурдсан хуульд заасны дагуу цагдан хорих, баривчлах, албадан саатуулахаар шилжүүлсэн хүмүүсийг хүлээн авч, холбогдох шийдвэрийг биелүүлэх агуулгатай юм. Харин хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэг нь зөвхөн шийдвэрийг биелүүлэх, тухайлбал, байр сууц, хоол унд, ариун цэвэр, эрүүл мэнд, хувцас, харуул хамгаалалт, төлбөрт үйлчилгээ, ном хэвлэл ашиглах, телевиз, радио, хүлээн авагчтай байх, тоглоом тоглох зэргийг эл журмаар тогтоосон байна.

Эдгээрээс үзэхэд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь "... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байна.

3.1. Иргэн А. Энхбат хуулийн 45 дугаар зүйлд "... хамгаалах тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгслийн жагсаалт, бүх төрлийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга дангаараа буюу Улсын Ерөнхий Прокурортой зөвшилцөн батална" гэсэн заалт нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзжээ. Гэтэл энэ нь хуулийн заалтаас өөр болсон.

2. Хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэж заажээ.

Хуулийн 40, 41, 42, 43, 44, 46 зэрэг зүйлд цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэл, тавигдах хууль ёсны шаардлага, журмыг нарийвчлан тогтоож зохицуулсан юм. Харин галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалах зэрэг техникийн шинжтэй асуудлыг энэ хуулийн хүрээнд зохицуулах эрхийг Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын даргад олгосон. Хүлэг, ороох цамц, усан хөөрөг, гар хуруувы гав, бороохой гэх мэт нь ямар стандартчилал, технологитой байх нь хууль тогтоох бус харин цэвэр техникийн шинжтэй асуудал билээ.

3. Хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг Цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэж заажээ. Энэ нь "Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэлтэй хамт ороогүй, зөвхөн хамгаалах тусгай хэрэгсэл. Хуулийн 41 дүгээр зүйлд цагдаагийн тусгай хэрэгслийн нэгэн төрөл нь хамгаалах тусгай хэрэгсэл болохыг тогтоожээ. Иногснээр хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдах учиргүй бөгөөд шаардцхүү амь дүйсэн үед цагдаа өөрийгөө гэмт хэрэгтний халдлагаас довтолгооноос хамгаалахад зориулагдсан юм. Өнөөдөр соёлт хүн төрөлхтөн цагдаагийн амь нас, эрүүл мэнд зэлиослогдохоос аврахад чиглэгдсэн бамбай, өмсгөл зэрэг олон арга хэрэгслийг бий болгожээ. Иймэ хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг батлах байх эрхийг хуулиар Цагдаагийн төв байгууллагын даргад олгосон. Энэ нь Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлээ бусдад шилжүүлсэн гэж үзэх үндэслэл болж чадахгүй гэв.

Иргэн А. Энхбат Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Би Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан гомдолдоо хуульд огт байхгүй зүйлийг нэмж бичээгүй ч төсөл байхаас өөрчлөгдсөн шарим заалтуудыг андуу ташаарсан талтай. Иймэ ч учраас өргөдөлд дурдсан цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэсэн нэхэмжлэлээсээ татгалзаж байна. Харин хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 болон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай" олон улсын пактын холбогдох заалтуудыг зөрчжээ. Ер нь хүний эрх, эрх чөлөөнд халдсан гэмарваа харилцааг хуулинд тулгуурласан нэрийдлээр заавар, журмаар зохицуулж болохгүй байх. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу гарсан заавар, журмуудад нэр бүхий заалтуудаас агуулгын хувьд хальсан гэж үзэх зүйлүүд цөөнгүй гохиолдож байна. Энэхүү баримтаас ч үзсэн Цагдаагийн байгууллагын хууль Үндсэн хууль зөрчиж байгаа юм биш үү. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1-д заасан заалтууд хуультай адил хэм хэмжээ тогтоож өгчээ. Төрхүү заврууд нь техник, технологийн бит, агуулгын шинж чанартай болжээ гэв.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Нарангэрэл Цэцийн хуралдаанд тайлбарлахдаа нэхэмжлэл гаргагч иргэн А. Энхбат зарим нэхэмжлэлээсээ татгалзаж байгаа юм байна. Гэтэл тэр үндэслэл нь төвийн сонин хэвлэлд нийтлэгдсэн учраас олон түмний дотор Цагдаагийн байгууллагад дураар аашилдаг тухай ойлголт төрөхөд нэмэрлэсэн. Энд, цэцийн хурал дээр нэхэмжлэлээсээ татгалзах нэг хэрэг. Хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд Үндсэн хууль зөрчиж байна, зөрчих үүд хаалгыг нээж өглөө гэсэн гомдлыг үндэслэлгүй зүйл гэж үзэж байна. Хуулинд хорих, баривчлах, албадан саатуулах, зэвсэг хэрэглэх бүхий л үндэслэлийг зааж өгсөн байдаг. Тэрхүү шийдвэр, үндэслэлд тулгуурлан цагдаагийн байгууллага зөвхөн биелүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Тэр нь тодорхой журамд орж байна. Боловсронгуй болох үүднээс цааш нь хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага нэлээд зүйл хийх нь ойлгомжтой. Ялангуяа УИХ-ын гаргасан хуулийн дагуу гаргаж байгаа журмууд хууль зөрчиж байгаа эсэхэд сайн хяналт тавьж байх шаардлагатай болох нь хуралдааны явцад ажиглагдлаа. Дээрх хуулийн заалтууд Үндсэн хууль зөрчөөгүй гэв.

Хянавал:

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалт нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гагцхүү хуульд тулгуурлан цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэр гаргаж шилжүүлсэн хүмүүсийг цагдаагийн байгууллага хүлээн авч тэрхүү шийдвэрийг хэрхэн биелүүлэх нийтлэг журам тогтооход чиглэгдсэн учраас Монгол Улсын Үндсэн хууль, "Иргэний болон улс төрийн эрхийн тухай" олон улсын пактыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Иргэн А. Энхбат Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь заалт болон Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх, тагнах ажлын талаар гаргасан нэхэмжлэлээс Цэцийн хуралдаан дээр татгалзсан учраас тэрхүү маргааныг тухайлан авч хэлэлцэн шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзэв.

3. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх заалтыг мөн хуулийн 40, 41, 42, 43, 44, 46 зүйлүүдтэй уялдуулан авч үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоосонгүй гэж үзэв.

4. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу Цагдаагийн Ерөнхий газраас гаргасан журам зааврууд Монгол Улсын үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хэм хэмжээ тогтоосон зарим заалт байгаа боловч уг журам заавар нь Үндсэн хуулийн Цэцийн хяналтын объект биш учир хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах дүгнэлт:

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

ДАРГА Н. ЖАНЦАН

ГИШҮҮД Л. БААСАН

Ж. БЯМБАА

Ч. ЭНХБААТАР

Д. ЧИЛХААЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Албан хэрэг хөтлөх үйл ажиллагаандаа энэхүү зааврыг ашиглахыг нам, олон нийт, шашны байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж болгосугай.

3. Албан хэрэг хөтлөхөд компьютер болон орчин үеийн бусад техник хэрэгслийг ашиглахад баримтлах зөвлөмж болон зохион байгуулалт-захирамжлалын баримт бичгийн стандарт /Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвтэй хамтран/-ыг шинэчлэн боловсруулж 1996 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлэхийг Хууль зүйн яам /Н. ЛУВСАНЖАВ/-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "БНМАУ-ын улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын бичиг хэргийн үндсэн зааврыг батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 276 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд Н. ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 53
дугаар тогтоолын хавсралт

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1. Монгол Улсын төр, захиргааны байгууллага болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага /цаашид "байгууллага" гэх/ энэхүү зааврын дагуу албан хэргээ хөтлөнө.*

2. Байгууллага нь энэ зааврын үндсэн дээр өөрийн онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн зааврыг боловсруулан мөрдөж болно.

3. Энэхүү зааврын зорилго нь удирдлагын баримт бичиг зохион бүрдүүлэх ба албан хэрэг хөтлөх арга, хэлбэрийг боловсронгуй болгоход оршино.

4. Зааврын хэрэгжилтэд хяналт тавих, зааварт холбогдох гарын авлага, зөвлөмж боловсруулах ажлыг Хууль зүйн яамны харьяа Улсын архивын хэрэг эрхлэх газар гүйцэтгэнэ.

5. Бичиг хэргийн ажилтан нь архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан хууль тогтоомж, дүрэм, зааврыг хэрэгжүүлэн ажиллаж, харьяа байгууллагадаа албан хэрэг хөтлөлтийн талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Хоёр. Баримтжуулалт

Баримт бичиг зохион бүрдүүлэх

6. Байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор албан бичиг, акт, гэрээ, дүрэм, журам, заавар, илтгэх хуудас, илтгэл, тайлан, тогтоол, захирамж, тушаал, протокол, хуралдааны тэмдэглэл, төлөвлөгөө, удирдамж, тодорхойлолт зэрэг зохион байгуулалт-захирамжлалын баримт бичгийг гаргана.

7. Зохион байгуулалт-захирамжлалын баримт бичгийг улсын стандартаар тогтоосон хэмжээний цаасан дээр үйлдэнэ.

---

* Нууц баримт бичгийг зохион бүрдүүлэх, тэдгээртэй харьцах ажлын журмыг тусгай зааврaар тогтооно.

8. Баримт бичгийн бүрдэлд: төрийн сүлд, соёмбо, байгууллагын бэлгэдэл тэмдэг, нэр, баримт бичгийн нэр, огноо, дугаар, байгууллагын оршиж буй хот, суурин газрын нэр, шуудангийн индекс, факс, телексийн дугаар, бичиг хэргийн ажилтны телефон утасны дугаар, хүлээн авах байгууллагын нэр, тэргүү бичвэр, санал, хавсралтын тухай болон баримт бичгийн хувийг явуулсан тухай тэмдэглэл, албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, тамга, тэмдгийн дардас, баталсан, зөвшөөрсөн болон баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэл тус тус орно.

Гадаадад явуулах албан бичгийг тухайн байгууллагын нэр, оршиж буй хот, суурин газрын нэр, шуудангийн индекс, факс, телексийн болон телефон утасны дугаар зэргийг монгол болон аль нэг гадаад хэл дээр бичсэн хэвлэмэл хуудсан дээр монгол хэлээр үйлдэж, шаардлагатай бол орчуулгыг хавсаргана.

Гадаадад явуулах баримт бичиг нь тухайн байгууллагаас явуулах бусад баримт бичигтэй нэгдсэн дугаартай байна.

9. Баримт бичгийн бүрдлийг толгойн, бичвэрийн болон баталгааны гэсэн гурван хэсэгт хуваана.

Баримт бичгийн толгойн хэсэг

10. Баримт бичгийн хэвлэмэл хуудсыг зохион байгуулалт-захирамжлалын баримт бичгийн стандартын дагуу хэвлүүлнэ.

11. Албан бичгээс бусад баримт бичигт тэдгээрийн нэрийг бичнэ.

12. Баримт бичгийн огноог он, сар, өдөр гэсэн дарааллын дагуу зөвхөн араб тоогоор тэмдэглэнэ. Жишээ нь: 1995 оны 5 дугаар сарын 9-ний өдөр г.м.

13. А5 хэмжээний хэвлэмэл хуудасны огноог дараахь байдлаар бичнэ. Жишээ нь:

1995.05.25
1995.10.01 г.м.

14. Албан бичгийн дугаар нь тухайн зохион байгуулалтын нэгжийн индекс болон бүртгэлийн дугаараас бүрдэнэ. Жишээ нь:

2/155
Үүнд: -2 -нэгжийн индекс
-155 -бүртгэлийн дугаар

15. Тогтоол, тушаал, захирамж зэрэг баримт бичигт оны эхнээс дугаар өгнө.

16. Баримт бичигт тухайн байгууллагын оршиж буй хот, суурин газрын нэр, шуудангийн индекс, факсын дугаар, бичиг хэргийн ажилтны телефон утасны дугаарыг дараахь байдлаар бичнэ. Жишээ нь:

Улаанбаатар-210646
факс /976-1/ 324533
Утас 320555 г.м

17. Баримт бичгийг хаяглахдаа хүлээн авах байгууллага болон хүний нэрийг өгөх, оршихын албан тушаалын нэрийг нэрлэхийн гийн ялгаалаар тус тус бичнэ. Жишээ нь:

Эрүүл мэндийн яаманд
"Хүлэг" компанийн захирал С. Даваад г.м.

18. Тодорхой хүний нэрээр хаяглахдаа хүлээн авагчийн овгийн эхний үсэг тодорхойгүй бол "ноён", "хатагтай" гэсэн үгсийг хэрэглэж болно. Жишээ нь:

"Говь" компанийн захирал ноён Шаравт г.м.

19. Удирдах албан тушаалтанд илгээх бичигт "танаа" гэсэн үгийг хэрэглэж болно. Жишээ нь:

Хүнс, хөдөө аж ахуйн сайд С. Бямбаа танаа г.м.

20. Баримт бичгийг нэг төрлийн хэд хэдэн байгууллагын нэрээр хаяглахдаа тэдгээрийн нийтлэг нэрээр бичнэ. Жишээ нь:

Аймгуудын Засаг даргын Тамгын газарт г.м.

21. Тодорхой албан тушаалтны нэр заан хаяглаж болно. Жишээ нь:

Ховд аймгийн Булган сумын Засаг дарга Э. Зулд г.м.

22. Дугтуй дээр хүлээн авах байгууллагын хаягийг бичихдээ тухайн байгууллагын шуудангийн индексийг бичнэ. Жишээ нь:

Улаанбаатар -210649 Хууль зүйн яаманд г.м.

23. Баримт бичгийг хоёр байгууллагын нэр заан хаяглаж болно. Жишээ нь:

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар,
Дорнод аймгийн улсын архивт г.м.

24. Хаягт цэргийн ба бусад цолыг заан бичиж болно. Жишээ нь:

Батлан хамгаалахын сайд,
хурандаа генерал Б. Тулгад г.м.

25. Хэвлэмэл хуудсан дээр бичих баримт бичигт бичвэрийн үндсэн агуулгыг товч илэрхийлсэн тэргүү зохиож бичнэ. Тэргүүг нэг өгүүлбэрт багтаан үеэр таслалгүй бичнэ. Жишээ нь:

Статистик бүртгэлийг сайжруулах тухай г.м.

26. Хэрэв баримт бичигт хэд хэдэн асуудал тусгагдсан бол тэргүүг ерөнхий бичиж болно.

Баримт бичгийн бичвэрийн хэсэг

27. Баримт бичгийн бичвэр нь үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэгдэх хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлсэн үндэслэл, хоёрдахь хэсэгт санал, дүгнэлт, шийдвэрийн тухай бичнэ. Зарим тохиолдолд бичвэр нь зөвхөн хоёрдахь хэсгээс бүрдэж болно. Тухайлбал, тэмдэглэх хэсэггүйгээр зөвхөн тушаах хэсгээс бүрдэж болно.

28. Баримт бичгийн хэл найруулга нь утга төгөлдөр, товч тодорхой, засваргүй этгээд болон бүдүүлэг үг хэллэг хэрэглээгүй, зөв бичих дүрмийн дагуу бичигдсэн байна.

29. Шаардлагатай тохиолдолд бичвэрийг бүлэг, дэд бүлэг, зүйл, дэд зүйл, заалтад хуваан тоо буюу үсгээр дугаарлаж болно.

30. Баримт бичиг хавсралттай бол бичвэрийн зохих хэсэгт "хавсралт"-ыг зааж бичнэ. Хэрэв хэд хэдэн хавсралттай бол хавсралт тус бүрийг дугаарлана. Жишээ нь:

1 дүгээр хавсралт

2 дугаар хавсралт г.м.

31. Захирамжлалын баримт бичгээр батлагдсан хавсралтын баруун дээд өнцөгт ямар байгууллагын, хэдэн оны, хэддүгээр тогтоол, захирамж, тушаалын хавсралт болохыг зааж бичнэ. Жишээ нь:

Үндэсний хөгжлийн газрын даргын 1995

оны 30 дугаар тушаалын хавсралт г.м.

32. Бичгийн хувийг өөр байгууллагад явуулсан тухай тэмдэглэлийг бичвэрийн эцэст бичнэ. Жишээ нь:

Хувийг Сангийн яаманд г.м.

Баримт бичгийн баталгааны хэсэг

33. Баримт бичиг нь эрх мэдэл бүхий албан тушаалтны албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, байгууллагын

гамга буюу тэмдгээр батлагдсан байна. Тамга, тэмдгийг баримт бичигт гарын үсэг зурагдсаны дараа албан тушаалын нэрийн эхний үсгүүдийг оруулан бүтэн, тэгш, тод дарна. Харин гадаад орнуудтай харилцах албан бичигт тамга, тэмдэг дарахгүй.

34. Хэвлэмэл хуудас бүхий албан бичигт байгууллагын дарга, орлогч, зохион байгуулалтын нэгжийн дарга гарын үсэг зурна.

35. Байгууллагын дарга эзгүй үед албан тушаалын нэр, гарын үсгийн тайллыг даргын нэрээр бичиж түүнийг албан ёсоор орлож байгаа хүн албан тушаалын нэрийн ард холбох зураас татаад даахын тийн ялгалын дагавар хэрэглэн гарын үсгээ зурна. Жишээ нь:

Дарга	-ыг	С. Бат
Захирал	-ыг	Ц. Бор г.м.

36. Хэрэв байгууллагыг "үүрэг гүйцэтгэгч" толгойлж байгаа бол албан тушаал, гарын үсэг, гарын үсгийн тайллыг үүрэг гүйцэтгэгчийн нэрээр бичнэ. Жишээ нь:

Даргын үүрэг гүйцэтгэгч Ү. Долгор г.м.

37. Хэвлэмэл хуудас хэрэглээгүй тохиолдолд бичгийн нүүрийг хуудасны зүүн дээд өнцөгт дарж стандартын шаардлагын дагуу бусад бүрдлийг бичнэ.

38. Адил эрхтэй байгууллагууд баримт бичиг хамтран гаргавал тус тусын байгууллагын нэр, албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлалыг уг ажлыг зохион байгуулахад гүйцэтгэж байгаа үүргийн дарааллаар бичиж, тамга буюу тэмдэг дарна. Жишээ нь:

Монгол Улсын Хууль зүйн сайд	Монгол Улсын Эрүүл мэндийн сайд
А. Дорж	Л. Цог г.м.

39. Нэгдсэн удирдлагатай байгууллагын тушаал, захирамж зэрэг баримт бичигт байгууллагын дарга гарын үсэг зурна. Харин илтгэх хуудас зэрэг лавлагаа-мэдээллийн шинжтэй баримт бичигт боловсруулсан ажилтан гарын үсэг зурна.

40. Хамтын удирдлагатай байгууллагын тогтоол, шийдвэр зэрэг баримт бичигт байгууллагын дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

41. Аливаа зөвлөл, комисс, ажлын хэсгээс гаргасан баримт бичгийн баталгааны хэсэгт дарга, гишүүд, нарийн бичгийн дарга,

тэдний овгийн эхний үсэг, нэр, албан тушаалыг заан бичнэ. Гарын үсгийг гарын үсгийн тайллын өмнө зурна. Жишээ нь:

Комиссын дарга С. Гэндэн /дэд дарга/
Гишүүд Д. Цог /инженер/
Л. Бат /механик/
Г. Сувд /нярав/
Нарийн бичгийн дарга А. Янжин /ня-бо/ г.м.

42. Баримт бичгийн хуулбар хувийг байгууллагын удирдлага, зохион байгуулалтын нэгжийн даргын зөвшөөрлөөр олгох бөгөөд тэр нь уг байгууллагын зөвхөн өөрийнх нь үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хуулбар байна. /энэ заалт архивын байгууллагад үл хамаарна/.

43. Баримт бичгийн хуулбар хувийг тухайн байгууллагын хэвлэмэл хуудсан дээр үйлдэнэ. Баталгааны бүрдэлд "хуулбар үнэн" гэсэн тэмдэглэл, албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, байгууллагын тамга, тэмдгийн дардас орно. Жишээ нь:

Хуулбар үнэн
Тамгын газрын дарга Н. Сэлэнгэ г.м.

44. Баримт бичгийг баталсан, зөвшөөрсөн тухай тэмдэглэлд "Батлав", "Зөвшөөрөв" гэсэн үг, байгууллагын нэр, албан тушаал, гарын үсэг, гарын үсгийн тайлал, огноо, тамга, тэмдгийн дардас орно. "Батлав" гэсэн үгийг хуудасны зүүн болон дээд ирмэгээс 20 мм зай авч бичээд бусад бүрдлийг бичнэ. Жишээ нь:

Батлав. Увс аймгийн Засаг дарга Д. Сүх
1995 оны 05.13. г.м.

Энэ нь байгууллагын дотоод журам, төлөвлөгөө, удирдамж зэрэг баримт бичигт гол төлөв хамаарна.

45. Хэрэв баримт бичгийг захирамжлалын баримт бичгээр баталсан бол уг баримт бичгээр гарсан он, дугаарыг дараахь байдлаар бичнэ. Жишээ нь:

Соёлын сайдын 1995 оны А/15 тоот
тушаалаар батлав. г.м.

46. Тухайн байгууллагад боловсрогдож байгаа баримт бичгийн төсөлд өгөх санал нь төслийг зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн тухай тэмдэглэл, огноо, санал өгч буй албан тушаалтны гарын үсгээс бүрдэнэ. Шаардлагатай гэж үзвэл санал өгч байгаа хүний албан тушаал, гарын үсгийн тайллыг бичнэ. Жишээ нь:

Зөвшөөрөв. Хуулийн зөвлөх А. Батсүх

1995 оны 05. 10 г.м.

Төсөлд өгөх нэмэлт санал, зөвлөмжийг хавсаргана. Жишээ нь:

Хуулийн зөвлөх

А. Батхүү Санал, зөвлөмжийг хавсаргав.

1995 оны 05.15 г.м.

47. Бусад байгууллагаас боловсруулж ирүүлсэн баримт бичгийн төсөлд өгөх саналыг тухайн байгууллагын хэвлэмэл хуудсан дээр бичиж, байгууллагын дарга гарын үсэг зурна.

48. Баримт бичгийн ноорог, түүнд оруулсан засвар, оруулга нь гаргацтай, утга найруулгын хувьд ойлгомжтой байна. Хэрэв энэ шаардлагыг биелүүлээгүй байвал бичиг хэргийн ажилтан, бичээч, компьютерийн операторч уг баримт бичгийг хүлээн авахаас татгалзана.

49. Хоёр ба түүнээс дээш хуудастай баримт бичгийн хоёрдугаар хуудаснаас эхлэн "2" гэж араб тоогоор дугаарлан хуудасны дээд ирмэгээс 10 мм-ийн зайд голлуулж бичнэ.

50. Байгууллагад үлдэх баримт бичгийн эцсийн хуудасны арын зүүн доод өнцөгт хуудасны зүүн захаас 30 мм-ийн зайд "Боловсруулсан", "Нийлсэн" гэсэн үг, бичгийн хувийн тоо, баримт бичиг боловсруулсан, нийлсэн, бичсэн ажилтны овгийн эхний үсэг, нэрийг бичнэ. Жишээ нь:

Боловсруулсан	Ц. Ганболд
Нийлсэн	С. Буд
3 хувь	Ц. Отгонбилэг г.м.

51. Удирдлагын үйл ажиллагааг баримтжуулахад төрөл бүрийн бичгийн машин, компьютер ашиглана. Компьютерийн программд энэ заавар болон зохион байгуулалт-захирамжлалын баримт бичгийн стандартын шаардлагыг тусгасан байна.

52. Түүх, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий байнга хадгалах баримт бичиг болон төр, засгийн удирдах дээд байгууллагад илгээх баримт бичгийг сайн чанарын бичгийн цаасан дээр нэг талд нь стандартын шаардлагын дагуу бичнэ. Түр хадгалах баримт бичгийг бичгийн цаасны хоёр талд бичиж болно.

53. Факс, телексээр ирсэн байнга хадгалах баримт бичгийг олшруулагч машинаар хувилж, байгууллагын архивт зохих заавны дагуу шилжүүлнэ.

Гурав. Баримт бичгийн эргэлтийн зохион байгуулалт

Баримт бичгийн эргэлт

54. Баримт бичиг зохион бүрдүүлсэн буюу хүлээн авсан мөчөөс архивт шилжүүлэх хүртэлх хугацаанд гүйцэтгэх ажлын дараалалыг баримт бичгийн эргэлт гэнэ.

55. Тодорхой хугацаанд гаднаас ирсэн, гадагш явуулсан ба тухайн байгууллагад боловсруулсан дотоодын баримт бичгийн нийт хэмжээг баримт бичгийн эргэлтийн хэмжээ гэнэ. Баримт бичгийн эргэлтийн хэмжээг хуудсаар тооцно. Олшруулсан хувийг эх бичгээс нь тусад нь тоолно.

Нийт баримт бичгийн эргэлтийн хэмжээг дараахь хүснэгтийн дагуу хуудасны тоогоор гаргана.

1. Байгууллагын нэр.
2. Огноо
3. Ирсэн бичиг
4. Явуулсан бичиг
5. Иргэдийн өргөдөл, гомдол
6. Төлөвлөгөө, тайлан, тушаал, протокол зэрэг дотоодын баримт бичиг

Тайлбар: Баримт бичгийн эргэлтийн хэмжээг бичвэр бүхий А4 хэмжээтэй хуудасны тоогоор гаргана. Хоёр талдаа бичвэртэй нэг хуудсыг 2 хуудсанд, А5 хэмжээний хоёр хуудсыг 1 хуудсанд тус тус тооцно.

Баримт бичиг хүлээн авах журам

56. Байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авч бүртгэх, ангилах, холбогдох ажилтанд шилжүүлэх ажлыг бичиг хэргийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

57. Бичиг хэргийн ажилтан ирсэн баримт бичгийг хүлээн авч зөв хаягласан, бүрдэл бүрэн эсэхийг шалгаж ирсэн баримт бичгийн

бүртгэл /1 дүгээр хавсралт/-д бүртгэнэ. Ирсэн баримт бичгийн бүртгэлийн 8 дугаар баганад зөвхөн хариутай бичигт хөтлөх бүртгэл-хяналтын карт /загварыг 7 дугаар хавсралтаар үзүүлэв/-ын дугаарыг оны эхнээс бичнэ.

58. Баримт бичиг буруу хаягласан, бүрдэл дутуу зэрэг зөрчилтэй бол 2 дугаар хавсралтад үзүүлсэн маягтын дагуу 2 хувь тодорхойлолт бичиж нэг хувийг ирсэн баримт бичгийн хамт буцаана.

59. "Нууц", "гарт нь" гэсэн баримт бичгийг дугтуйн гаднахь хаягаар бүртгэж холбогдох ажилтанд задлалгүй шилжүүлнэ.

60. Бичиг хэргийн ажилтан хүлээн авч бүртгэсэн яаралтай баримт бичгийг тухай бүрт нь, бусад баримт бичгийг ирсэн өдөрт нь багтаан холбогдох ажилтанд шилжүүлнэ.

61. Бичиг хэрэгт бүртгээгүй баримт бичгийг хүлээж авахыг хориглоно. Онцгой тохиолдолд бүртгэлгүй баримт бичиг хүлээн авсан хүн өөрийн биеэр бичиг хэргийн ажилтанд бүртгүүлнэ.

62. Байгууллагад ирсэн баримт бичгийн эцсийн хуудасны арын зүүн доод өнцөгт тэмдэг дарж 3 дугаар хавсралтад үзүүлсний дагуу бүртгэнэ.

63. Баримт бичгийг ирүүлсэн байгууллагын хаяг, явуулсан болон хүлээн авсан огноог зөвхөн дугтуйн дээр байгаагаар тогтоохоор байвал уг дугтуйг баримт бичигт хавсаргана.

64. Иргэдийн өргөдөл, гомдлыг 4 дүгээр хавсралтад заасны дагуу бүртгэж асуудлыг шийдвэрлэх ажилтанд шилжүүлнэ.

Баримт бичиг явуулах журам

65. Явуулах баримт бичгийг хүлээн авч шалгах, бүртгэх, ангилах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүргэх ажлыг бичиг хэргийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

66. Явуулах баримт бичгийн утга агуулга, хэл найруулга, бүрдлийг боловсруулсан ажилтан хариуцна.

67. Явуулах баримт бичгийг 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу явуулсан баримт бичгийн бүртгэлд бүртгэнэ. Явуулж байгаа баримт бичигт хариу ирүүлэхээр заасан бол "хариутай эсэх" гэсэн 8 дугаар баганад оны эхнээс дугаар өгч тэмдэглэнэ. Яаралтай баримт бичгийн дугтуйн баруун дээд өнцөгт "яаралтай" гэж бичнэ.

68. Явуулах баримт бичгийг шуудангийн салбарт шилжүүлэхдээ 6 дугаар хавсралтад заасан маягтаар бүртгэнэ.

Баримт бичгийн шийдвэрлэлтэд тавих хяналт

69. Баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтэд бичиг хэргийн ажилтан тогтмол хяналт тавина.

70. Баримт бичгээр тавьсан асуудлыг дараахь хугацаанд шийдвэрлэнэ. Үүнд:

-шууд шийдвэрлэж болох асуудлыг 1-3 хоногт;

-бусад байгууллагатай хамтран шийдвэрлэвэл зохих асуудлыг 5-30 хоногт;

-иргэдийн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацааны дотор.

71. Баримт бичигт асуудал шийдвэрлэх хугацааг заасан бол дурдсан хугацаанд нь, мөн яаралтай албан бичиг, цахилгааны хариуг тэр дор нь явуулна.

72. Шийдвэрлэлтэд нь хяналт тавих, хариу өгөх шаардлагатай баримт бичигт бүртгэл-хяналтын карт хөтлөн ирсэн баримт бичгийн бүртгэлд гарын үсэг зурж хүлээлцэнэ.

73. Хариутай баримт бичгийг зохион байгуулалтын нэг нэгжээс нөгөөд шилжүүлэх тохиолдолд бичиг хэргийн ажилтанд мэдэгдэж тийнхүү шилжүүлсэн тухай тэмдэглэлийг бүртгэл-хяналтын картад хийлгэнэ.

74. Хариутай баримт бичгийн бүртгэл-хяналтын картыг хоёр хувь хөтөлж нэг хувийг ирсэн баримт бичгийн хамт холбогдох ажилтанд шилжүүлнэ. Хоёрдахь хувийг бичиг хэргийн ажилтан хяналтад авна.

75. Холбогдох ажилтан ирсэн баримт бичгийг хэрхэн яаж шийдвэрлэснийг бүртгэл-хяналтын картын "хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн" гэсэн хүснэгтэд тэмдэглэж бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө.

76. Бүртгэл-хяналтын карт 210x148 мм, хяналтын карт 170x120 мм-ийн хэмжээтэй байна. Компьтерээр албан хэргээ хөтөлдөг байгууллагад энэ хэмжээ өөр байж болно.

77. Баримт бичгийн эргэлт багатай байгууллагад бүртгэл-хяналтын карт хөтлөлгүй ирсэн баримт бичгийн бүртгэлээр хяналт тавьж, биелэлтийг 11 дүгээр хавсралтад үзүүлсэн хүснэгтэд тэмдэглэнэ.

78. Бичиг хэргийн ажилтан нь шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг 8 дугаар хавсралтад заасан

хүснэгтээр; хугацаандаа хариу ирээгүй баримт бичгийн мэдээг 9 дүгээр хавсралтад заасан хүснэгтээр тус тус долоо хоног тутам гаргаж удирдлагад танилцуулна.

79. Тогтоол шийдвэрийн биелэлтийг 10 дугаар хавсралтад заасан хяналтын картад бичнэ. Хяналтын картыг хоёр хувь хөтөлж нэг хувийг шийдвэрийн биелэлтэд хяналт тавих ажилтанд шилжүүлж, хоёрдахь хувийг бичиг хэргийн ажилтан хяналтад авна.

80. Холбогдох ажилтан нь тогтоол, шийдвэрийн биелэлтийг хяналтын картын "биелэлтийн тухай тэмдэглэл" гэсэн хүснэгтэд тэмдэглэж, бичиг хэргийн ажилтанд шилжүүлнэ. Тогтоол, тушаал, захирамж зэргийг оны эхнээс 11 дүгээр хавсралтад үзүүлсэн маягтаар бүртгэнэ.

81. Иргэдийн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухайг 4 дүгээр хавсралтад үзүүлсэн хүснэгтийн 9-13 дахь баганад тэмдэглэнэ. Шаардлагатай гэж үзвэл бүртгэл-хяналтын карт хөтөлж хариутай баримт бичиг шийдвэрлэдэг журмаар гүйцэтгэнэ.

82. Бүртгэл-хяналтын болон хяналтын картыг лавлах санд байлгаж байгууллагын зохион байгуулалтын нэгж, харилцагч байгууллага болон шийдвэрлэгдсэн, шийдвэрлэгдээгүй асуудлаар ялгаж ангилсан байна.

Харин иргэдийн өргөдөл, гомдлын картын санг тусад нь хөтөлж, картыг цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулна.

Хөтлөх хэргийн жагсаалт

83. Байгууллагын зохион байгуулалтын нэгжид хөтлөх хэргийг тодорхой нэр төрөл, асуудлын сэдвээр төрөлжүүлсэн, хадгалах хугацаа, хариуцах албан тушаалтны нэрийг заасан лавлах, тоо бүртгэлийн баримт бичгийг "Хөтлөх хэргийн жагсаалт" /12 дугаар хавсралт/ гэнэ.

84. Байгууллагын зохион байгуулалтын нэгж бүр хөтлөх хэргийн жагсаалттай байна. Жагсаалтыг бичиг хэргийн ажилтан хариуцан холбогдох ажилтнуудын оролцоотойгоор нэгтгэн гаргаж гухайн жилийн эхэнд байгууллагын даргаар батлуулна.

85. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргахдаа тухайн байгууллагын эрх хэмжээ, баримт бичгийн бүрэлдэхүүн, тоо хэмжээг судалж, байгууллагын дүрэм, баримт бичиг хадгалах хугацааны

86. Байгууллага нь зохион байгуулалтын нэгжид хуваагддаггүй бол баримт бичгийг үйл ажиллагааны чиглэлээр ангилж, хөтлөх хэргийг ач холбогдлоор нь дараалалд оруулна.

87. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гаргахдаа тухайн нэгжийн ажилтан бүрийн хөтлөх хэргийг нэг бүрчлэн бүртгэж, нийт хэргийг тодорхой дараалалд оруулан хадгалах хугацаа, хариуцах албан тушаалтны нэрийг заана.

88. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хэрэг бүр индекстэй байна. Хэргийн индекс нь байгууллагын зохион байгуулалтын нэгжийн индекс болон жагсаалтад бүртгэгдсэн дугаараас бүрдэнэ. Жишээ нь:

3/15

Үүнд: -3 -санхүүгийн хэлтсийн индекс;

-15 -хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын 15 дугаарт бүртгэгдсэн хэрэг.

89. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын зүүн дээд өнцөгт баталсан тухай, баруун дээд өнцөгт зөвшөөрсөн тухай тэмдэглэл тус тус хийнэ. Нэрийн жагсаалтын хүснэгтийн 1 дүгээр баганад хөтлөх хэргийн дэс дугаарыг араб тоогоор тэмдэглэнэ. 2 дугаар баганад хэргийн индексийг, 3 дугаар баганад хэргийн гарчгийг бичнэ.

4 дүгээр баганад хэргийн хадгалах хугацааг бичих бөгөөд энэ хугацааг тогтоохдоо баримт бичиг хадгалах хугацааны ямар жагсаалт ашигласан, жагсаалтын хэддүгээр зүйлд хадгалах хугацааг заасныг бичнэ. Хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг ашиглавал "ҮЖ" гэж тэмдэглээд зүйлийн дугаарыг бичнэ. Жишээ нь:

ҮЖ-1065 байнга г.м.

Байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалтыг ашиглавал "БЖ" гэж тэмдэглээд зүйлийн дугаарыг бичнэ.

БЖ-103 5 жил г.м.

5 дугаар баганад уг хэргийг хариуцсан албан тушаалтны нэрийг бичиж 6 дугаар баганад хэргийн талаар тэмдэглэл хийнэ.

90. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 3 хувь үйлдэж, 1 хувийг зохион байгуулалтын нэгжид хөтлөх бөгөөд үлдэх 2 хувийг бичиг хэргийн болон архивын ажилтан тус тус хяналтад авна.

Хэрэг бүрдүүлэх

91. Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу хэрэг бүрдүүлэх үе атанд баримт бичгийг ач холбогдлоор нь үнэлэн хадгалах угацааг тогтооно.

92. Баримт бичгийг нэр төрөл, үүссэн он цаг, асуудлын сэдэв, йл ажиллагааны чиглэл, байгууллага, иргэдтэй харилцсан бай- ıл, газар нутгийн болон зохиогчийн нэр зэрэг үндсэн шинжүүдийн ıь нэгээр буюу хэд хэдийг хослуулан ангилан төрөлжүүлж эрэг бүрдүүлнэ.

93. Хэрэгт гарчиг бичиж хуудсыг дугаарлана. Хэрэг бүрдүү- эхэд дутагдаж байгаа баримтыг уг хэргийг хариуцсан албан /шаалтан сурвалжлан олж бүрдүүлнэ.

94. Хөтлөгдөж дууссан хэргийг байгууллагын архивын ажлын ıдсэн зааврын дагуу эмхлэн цэгцэлж архивт шилжүүлнэ.

Зааврын 1 дүгээр хавсралт

_____

_____
/байгууллагын нэр/

ИРСЭН БАРИМТ БИЧГИЙН БҮРТГЭЛ

_____он

Үргэлжлэл /хавсралт N 1/

Ирсэн баримт бичгийн

Дэс дугаар	Сар, өдөр	Дугаар	Хаанаас, хэнээс	Товч утга	Хуудасны тоо
1	2	3	4	5	6

Үргэлжлэл /хавсралт N 1/

Бүртгэж шилжүүлсэн						
Сар, өдөр	Картын N	Аль нэгж, хэнд шилжүүлсэн	Хүлээн авсан хүний нэр, гарын үсэг	Хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн	Хэргийн индекс	Тайлба
7	8	9	10	11	12	13

Зааврын 2 дугаар хавсралт

БАРИМТ БИЧИГ БУЦААХ ТОДОРХОЙЛОЛТ

ноо_____ Дугаар__

Ирүүлсэн байгууллага, хүний нэр_____

_____

_____

чгийн огноо_____

гаар_____Хуудасны тоо_____

Товч утга_____

_____

_____

Хэний шийдвэрээр, ямар шалтгаанаар буцаасан_____

_____

_____

_____


_____

_____

/албан тушаал, гарын үсэг, тэмдэг/

А5 /210х148 мм/

Зааврын 3 дугаар хавсралт



/50x40 мм/

Зааврын 4 дүгээр хавсралт

_____

_____

/байгууллагын нэр/

өргөдөл, ГОМДЛЫН БҮРТГЭЛ

А4 /210х297 мм/

Үргэлжлэл /хавсралт N 4/

Дэс дугаар	Өргөдлийн сар, өдөр	Өргөдөл гаргагчийн		Товч утга	Хуудасны тоо
		Овог нэр	Хаяг		
1	2	3	4	5	6

Үргэлжлэл /хавсралт N 4/

Бүртгэсэн		Хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн	Хариу явуулсан			Шийдвэрлэсэн хүний нэр, гарын үсэг
Сар, өдөр	Картын дугаар		Сар, өдөр	Дугаар	Хариуг эзэнд нь ямар журмаар мэдэгдсэн	
7	8	9	10	11	12	13

Зааврын 5 дугаар хавсралт

_____

_____

/байгууллагын нэр/

ЯВУУЛСАН БАРИМТ БИЧГИЙН БҮРТГЭЛ

А4 /210х297 мм/

Үргэлжлэл /хавсралт N 5/

Явуулсан баримт бичгийн

Ілэс ду- ·аар	Сар, едөр	Ду- гаар	Хаана, хэнд	Товч утга
1	2	3	4	5

Үргэлжлэл /хавсралт № 5/

Хуулсын тоо	Аль нэгжээс явуулсан	Харилцах эсэх	Ирсэн хариу		Ирүүлсэн хариуны товч утга	Тайлбар
			Сар, өдөр	Дугаар		
6	7	8	9	10	11	12

Зааврын 6 дугаар хавсралт

_____

_____
/байгууллагын нэр/

БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭЛЦЭХ ДЭВТЭР

_____он

А4 /210х297 мм/

Үргэлжлэл /хавсралт N 6/

Дэс дугаар	Хаана, хэнд	Явуулах бичгийн		Явуулсан		Хүлээн авсан хүний албан тушаал, нэр, гарын үсэг	Хүлээлгэж өгсөн хүний албан тушаал, нэр, гарын үсэг
		Сар, өдөр	Дугаар	Сар, өдөр	Цаг, минут		
1	2	3	4	5	6	7	8

Зааврын 7 дугаар хавсралт

өвөр тал/

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

Огноо_____

_____ _____

/байгууллагын нэр/

_____

/зохион байгуулалтын нэгж, ажилтны нэр/

үртгэсэн		Хаанаас ирүүлсэн	Баримт бичгийн		
ар, дөр	Карт N		Ду-гаар	Сар, өдөр	Хуудасны тоо

Товч утга_____

_____

_____

дирдлагын заалт_____Сар, өдөр_____

_____

_____

_____

А5/210х148 мм/

ар тал/

_____

Хэзээ,хэрхэн шийдвэрлэсэн_____

_____

_____

_____

_____

Шийдвэрлэсэн албан
тушаалтны нэр _____

гноо_____

_____

Зааврын 6 дугаар хавсралт

_____

_____

/байгууллагын нэр/

ҮЙЛДВЭРЛЭХ ХУГАЦАА ХЭТЭРСЭН БАРИНТ БИЧИГ,
ӨРГӨДӨЛ, ГОНДОЛЫН МЭДЭЭ

Огноо_____

Дэс дугаар	Төвч утга	Аль нэгж, хэнд байгаа	Хэтэрсэн хугацаа /хоногоор/	Удирдлагын шийдвэр
1	2	3	4	5

МЭДЭЭ ГАРГАСАН _____

-1263-

Зааврын 9 дүгээр хавсралт

ХАРИУ ИРЭЭГҮЙ БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭ

N	Хаанаас ирэх	Аль нэгжид ирэх	Товч утга	Саатах буй хугацаа	Тайлбар
1	2	3	4	5	6

МЭДЭЭ ГАРГАСАН_____

А4 /210х297 мм/

Зааврын 10 дугаар хавсралт

/өвөр тал/

ХЯНАЛТЫН КАРТ N_____

Тогтоол, захирамж, тушаал_____

Огноо	Дугаар	Гарчиг

Заалт_____

/170x120 мм/

/ар тал/

Он, сар, өдөр	Биелэлтийн тухай тэмдэглэл

Шалгасан _____

Зааврын 11 дүгээр хавсралт

ТОГТООЛ, ЗАХИРАМЖ, ТУШААЛЫН БҮРТГЭЛ

_____он

Дэс дугаар	Гарсан		Товч утга	Хуудасны тоо	Картын дугаар	Биелэлтийн тэмдэглэл, огноо
	Сар, өдөр	Дугаар				
1	2	3	4	5	6	7

А4/210х297 мм/

Зааврын 12 дугаар хавсралт

БАТЛАВ:

_____

_____

/байгууллагын дарга/

Огноо_____ _____

ЗӨВШӨӨРӨВ:

_____

_____

/архивын эрхлэгч/

Огноо_____

_____

/зохион байгуулалтын нэгжийн нэр/

ХӨТЛӨХ ХЭРГИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

Дэс дугаар	Хэргийн индекс	Хэргийн нэр	Архивт хадгалах хугацаа, жагсаалтын зүйлийн дугаар	Хариуцах албан тушаалтны нэр	Тэмдэглэл
1	2	3	4	5	6

_____онд хөтлөгдсөн хэргээс:
а/байнга хадгалах хэргийн тоо _____
б/түр хадгалах хэргийн тоо _____

_____

/албан тушаал, гарын үсэг/

Огноо _____

А4 /210х297 мм/

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

"Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтыг зохион байгуулах журам"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

2. Бүх шатны Засаг дарга нарт даалгах нь:

а) сургуульд элсээгүй үлдсэн болон сургуулиас завсардсан хүүхэд, түүнчлэн суурь боловсрол эзэмшээгүй насанд хүрэгчдийн бүртгэл судалгааг батлагдсан журмын дагуу хүн нэг бүрээр нарийвчлан гаргаж, мэдлэгийн түвшинг нь тодорхойлсны үндсэн дээр тэднийг зохион байгуулалттайгаар сургалтад хамруулж суурь боловсрол эзэмшүүлэх арга хэмжээг 1995/1996 оны хичээлийн жилээс авч хэрэгжүүлсүгэй;

б) суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалт зохион байгуулах бэлтгэлийг сургалтын хэлбэр, шатлалттай нь нягт уялдуулан зохих бүрт нь бүрэн хангах, сургалтыг чанартай явуулах арга хэмжээ авч байхын хамтаар сургалтын явцад байнга хяналт тавьж, үр дүнг тооцож байсугай;

в) хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар сургууль завсардсан хүүхдийг сургуульд нь буцаан оруулж суурь боловсрол эзэмшүүлэх арга хэмжээ авч байхын зэрэгцээ хүүхдийг сургууль завсардуулсан гэм буруутай эцэг, эх, асран халамжлагчидтай нь зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байсугай;

г) арга зүйч болон зөвлөх багш томилох, тэдний ажиллах хүрмыг батлан гаргах, хичээл, сургалтаа явуулах нөхцөл, боломжоор хангах, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтын ажилд оролцуулах арга хэмжээг шуурхай авч ажилласугай.

3. Бичиг үсэггүй болон суурь боловсрол эзэмшээгүй дайчдыг бичиг үсэгт сургах, суурь боловсрол олгох сургалтыг 1995 оноос эхлэн байнга зохион байгуулахыг Батлан хамгаалах яам (Ш. ЖАДАМБАА), Хилийн цэргийг удирдах газар (П. СҮНДЭВ), Цагдаагийн ерөнхий газар (Б. ПҮРЭВ)-т энэ ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлж байхыг Шинжлэх ухаан, боловсролын яам (Н. ӨЛЗИЙХУТАГ)-д тус тус даалгасугай.

4. Шинжлэх ухаан, боловсролын яам (Н. ӨЛЗИЙХУТАГ)-д даалгах нь:

а) суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн судалгаа, сургалтын тайлан гаргах маягт, тэдний боловсролын түвшинг тогтоох аргачлал, сургалтын төлөвлөгөө, заавал судлах хичээлийн үлгэрчилсэн сэдвийг 1995 оны эхний хагаст багтаан батлан гаргаж орон нутагт хүргүүлсүгэй;

б) ерөнхий боловсролын сургуулийн номын сангаар дамжуулан энэ тогтоолын дагуу сургалтад хамрагдсан иргэдийг сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган үйлчлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Шинжлэх ухаан, боловсролын сайд **Н. ӨЛЗИЙХУТАГ**

Засгийн газрын 1995 оны 55
дугаар тогтоолын хавсралт

СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШЭЭГҮЙ ИРГЭДИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтыг зохион байгуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтад дараахь иргэдийг хамруулна:

а/ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сургуульд элсэн ороогүй үлдсэн, сургууль завсардсанаас суурь боловсрол эзэмшээгүй хүүхэд, насанд хүрэгчид;

б/ хүндэтгэн үзэхээс бусад шалтгааны улмаас сургуульд элсэн ороогүй, сургууль завсардсанаас суурь боловсрол эзэмшээгүй хүүхэд, насанд хүрэгчид.

3. Суурь боловсрол эзэмшээгүй насанд хүрэгчдийн бүртгэлд 16-45 насны иргэдийг хамруулна.

4. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн бүртгэлийг батлагдсан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан энэ журмын 2 дугаар зүйлд зааснаар ангилан гаргах буюу шинэчлэн тодотгож байна.

5. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн бүртгэл, тэдний сургалтыг зохион байгуулах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, сургалтын ажлыг аймаг, нийслэлийн боловсролын төв, ерөнхий боловсролын сургууль хариуцна.

Хоёр. Сургалтын бэлтгэл, хөтөлбөр

6. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангахын тулд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

а) бүртгэгдсэн иргэдийн мэдлэгийн түвшинг батлагдсан аргачлалын дагуу шалган тогтоож бичиг үсэгт тайлах болон аль шатны сургалтад хамрагдахыг шийдэх;

б) сургалтад хамрагдах иргэдийн нас, боловсролын түвшин, эрхэлсэн ажлын чиг үүрэг, байршлыг харгалзан сургалтын хэлбэр /нүүдлийн болон суурин/, дамжааны тоог тогтоох;

в) сургалтын арга, хэлбэртэй уялдуулан хичээлийн болон цотуур байр, хоол хүнс, бусад бэлтгэлийг хангах арга хэмжээ авах;

г) иргэдийн сургалтын анги бүлгийг зохион байгуулах, тэдгээрийн эхлэх, дуусах хугацааг тогтоож, хичээллэх хуваарийг батлан гаргах;

д) хичээл заах багш нарыг томилж, тэдний хичээлийн бэлтгэлийг хангуулах, хөтөлбөрийг нь батлах.

7. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийг бүртгэх маягт, тэдний боловсролын түвшинг шалгаж тогтоох аргачлал, сургалтын төлөвлөгөө, хичээлийн үлгэрчилсэн хөтөлбөрийг Шинжлэх ухаан,

боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан гаргаж, тэдгээрийг боловсронгуй болгох арга хэмжээг байнга авч байна.

Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь дамжаагаар заавал судлах хийгээд бие дааж сурах хичээлийн агуулгаас бүрдэнэ.

8. Сургалтын хөтөлбөр нь анхан шатны болон суурь боловсролын агуулгатай уялдсан, суралцагчдын мэдлэг, чадварын түвшинд тохирсон байна.

9. Суралцагчдын авьяас сонирхол, хэрэгцээ, сурах аргатай нийцүүлэн батлагдсан хөтөлбөрийн агуулгын 30 хүртэлх хувьд нь тухайн сургууль нь зохицуулалт хийж болно.

10. Сургалтыг бэлтгэл сургалт, бага болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалт гэсэн шатлалттайгаар дамжааны хэлбэрээр зохион байгуулна. Бэлтгэл дамжаанд цагаан толгой, монгол хэл-унших, тоо бодлогын хичээлийг; бага боловсрол эзэмшүүлэх дамжаанд монгол хэл, унших, тоо бодлого, амьдрах ухааны хичээлийг; суурь боловсрол эзэмшүүлэх дамжаанд монгол хэл-уран зохиол, математик, хууль зүй, байгаль, нийгмийн болон амьдрах ухааны хичээлийг тус тус судлахаар тооцож хөтөлбөрт тусгана.

11. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтыг зохион байгуулахад туслах, зөвлөлгөө өгөх үүрэг бүхий арга зүйч багшийг аймаг, нийслэлд, зөвлөх /явуулын/ багшийг сум, дүүрэгт тухайн шатны Засаг дарга томилон ажиллуулна.

12. Арга зүйч багшийн ажиллах журмыг аймаг, нийслэлийн боловсролын төвийн захирал, зөвлөх багшийн ажиллах журмыг тухайн ерөнхий боловсролын сургуулийн захирал тус тус батлаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Гурав. Сургалтын зохион байгуулалт

13. Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтыг дор дурдсан чиглэлээр зохион байгуулна:

Сургалтын төрөл	Жилд хичээллэх хоног	Зорилго
Бэлтгэл дамжаа	36-52	бичиг үсэгт сургах
Бага боловсрол эзэмшүүлэх дамжаа:		

I	II	III
- 1 дэх шатны	36-52	унших, бичих, тоо бодлогын баттай дадал эзэмшүүлэх, амьдрах ухааны мэдлэг олгох
- 2 дахь шатны	52-74	ерөнхий боловсролын сургуулийн III-IY ангийн хөтөлбөрийн түвшинд байгаль, нийгмийн ухааны мэдлэг эзэмшүүлж, хөдөлмөрийн дадал олгох
Суурь боловсрол эзэмшүүлэх дамжаа	74-өөс цөөнгүй	суурь боловсрол эзэмшүүлж мэргэжилд бэлтгэх

14. Сургалтын үндсэн дамжааг суралцагчдын мэдлэг чадварын төлөвшлөөс хамааруулан хэд хэдэн шаттайгаар зохион байгуулж болно.

15. Сургалтын дамжаа тус бүрийн зорилго нь боловсролын зохих шатны түвшний агуулга /стандарт/-ыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

16. Сургалтын дамжаа бүрийн хичээлийн жилийн эцэст суралцагчдын мэдлэгийн түвшинг шалгалтаар тогтооно. Мэдлэгийн түвшинг тогтоох шалгалтын сэдвийн агуулгыг тухайн нутаг дэвсгэрийн сургууль тогтооно. Суралцагчдын шалгалтын үнэлгээний оноогоор дараагийн шатны дамжаанд дэвшин суралцах хүмүүсийг тодорхойлно.

17. Бие даан хичээллэж дээд шатны хөтөлбөрийн агуулгыг урьдчилан эзэмшсэнээ зохих журмын дагуу нотолсон суралцагчдыг сургуулийн захиргааны зөвшөөрлөөр дамжаа алгасуулан суралцуулж болно.

18. Хүн амын байршил, эрхэлсэн ажил, үйлчилгээний болон суралцагчдын насны онцлог, чадвар, байгаль цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан дамжаа тус бүрийн сургалтын эхлэх хугацаа,

үргэлжлэх хоног, өдөрт хичээллэх цагийг тухайн шатны Засаг дарга ялгавартайгаар тогтоож болно.

Дөрөв. Сургалтын удирдлага, хяналт, тайлан мэдээ

19. Аймаг, нийслэлийн боловсролын төв нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд явагдаж байгаа сургалтыг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, явцад нь хяналт тавьж шаардлагатай арга хэмжээ авна.

20. Суурь боловсрол эзэмшсэн иргэдэд зохих журмын дагуу үндсэн сургуулиас нь боловсролын гэрчилгээ олгоно.

21. Суурь боловсрол эзэмшээгүй байсан иргэдийн сургалтын тухай жил бүрийн тайланг дараахь хугацаанд гаргана:

а) сум, дүүргийн тайланг Засаг даргын Тамгын газраас 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх;

б) аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нэгдсэн тайланг 12 дугаар сарын 30-ны дотор гаргаж шинжлэх ухаан, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 59 | Улаанбаатар хот

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох хөдөлмөрийн нөхцөлийн тухай

"Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 61 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн стандарт болон хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт судалгааны ажлын үр дүнг харгалзан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийг тодорхойлон холбогдох жагсаалтыг баталж, мөрдүүлэхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ)-д даалгасугай.

2. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээг хориглох, хөдөлмөрийн хийгээд эрүүл ахуйн нөхцөлийг байнга сайжруулах, технологийн шинэчлэлт хийх замаар тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох ажил мэргэжлийг багасгахад чиглэсэн цогцолбор арга хэмжээг эрхэлсэн үйл ажиллагааны хүрээнд хамаарах болон нутаг дэвсгэртээ байрладаг өмчийн бүх төрлийн үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжээнд авч хэрэгжүүлэхийг сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалтын тухай" Засгийн газрын 1990 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолын 1, 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого,
хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар сарын 2-ны өдөр — Дугаар 60 — Улаанбаатар хот

Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

"Төрийн албаны тухай Монгол Улсын хууль"-д заасан төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтуудыг эелж дараатай хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4 түүнчлэн 4, 5 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг болон тэдэнд олгох нэмэгд-

лийн талаар бэлтгэсэн төслийг тодотгон холбогдох сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг тусган эцэслэн боловсруулж энэ оны 5 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Сангийн сайд Э. Бямбажав нарт даалгасугай.

2. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ бүхий хот, суурин газарт ажилладаг төрийн албан хаагчдад тухайн хот, суурины дотор ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг тэдний гүйцэтгэж байгаа ажил үүргийн онцлог байдал, байнга ажиллаж амьдардаг газрын байршил зэргийг харгалзан энэ оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн дор дурдсан эх үүсвэрээс нөхөн олгож байхыг төрийн өмчийн төсөвт байгууллагын эрх баригч нарт зөвшөөрсүгэй:

а) төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллагын ажилтнуудад тухайн байгууллагын төсөв болон өөрийн орлогоос;

б) боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн байгууллагын ажилтнуудад тухайн орон нутгийн төсвөөс болон тухайн байгууллагын өөрийн орлогоос;

в) эрдэм шинжилгээний байгууллагын ажилтнуудад тухайн байгууллагын төсөв, эрдэм шинжилгээний ажлын төслийн хөрөнгө болон өөрийн орлогоос.

3. Төрийн албан хаагчдыг төрийн байгууллагад удаан хугацаагаар тогтвор суурьшилтай ажиллахад Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасны дагуу төрөөс орон байраар хангах, аминдаа орон сууц барих, худалдан авахад нь зохих хөнгөлөлт, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх болзол журмын төслийг боловсруулж 1995 оны III улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Монгол Улсын шадар сайд, Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын дарга Л. Энэбиш, Дэд бүтцийн хөгжлийн сайд Р. Сандалхан нарт даалгасугай.

4. Дор дурдсан арга хэмжээг 1995 оны батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэхийг сайд, тусгай газрын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон төрийн өмчийн төсөвт байгууллагын эрх баригчдад даалгасугай:

а) Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөх

төрийн захиргааны албан хаагчдад мөн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

б) "Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуулийн 3 дугаар зүйлд заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөх төрийн жинхэнэ албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох.

5. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10-т заасны дагуу төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн нэг хүүхдийн сургалтын хардлыг 1995-1996 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын төрийн сангаас санхүүжүүлж байхаар тогтоосугай. Үүнтэй холбогдсон журмыг боловсруулж 1995 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Шинжлэх ухаан, боловсролын сайд Н. Өлзийхутагт даалгасугай.

6. Үйлдвэрлэл, үйлчилгээ, туслах аж ахуйнхаа орлого болон тухайн жилийн төсвөөсөө хэмнэсэн хөрөнгийг ажилтныхаа нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээ, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд зориулан зарцуулж байх эрхийг төрийн өмчийн төсөвт байгууллагын эрх баригч нарт олгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	**П. ЖАСРАЙ**
Монгол Улсын Шадар сайд	**Л. ЭНЭБИШ**
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд	**Э. ГОМБОЖАВ**
Сангийн сайд	**Э. БЯМБАЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

1995 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 61

Тэтгэвэр авагчдын нийтийн тээврийн унааны зардлын зарим хэсгийг нөхөн олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ бүхий хотод амьдарч байгаа бүх төрлийн тэтгэвэр авагчдад хотын дотор долоо хоногт 2 удаа нийтийн тээврээр зорчихоор тооцож унааны зардлыг нь энэ оны 6 дугаар 1-нээс эхлэн орон нутгийн төсвөөс сар бүр нөхөн олгож байхыг нийслэл, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

1995 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 62

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

"Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1995 оны 4 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлд заасан ёсоор төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа, Төрийн албаны тухай хуульд заасан нөхцөл, болзлыг хангасан төрийн албан хаагчийг Монгол Улсын төрийн албан хаагчид хамааруулахтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг энэ оны 6 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон төрийн захиргааны холбогдох бусад байгууллагын эрх баригч нарт даалгасугай:

а/ төрийн захиргааны албан тушаал одоо эрхэлж байгаа ажилтнуудын Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэг болон Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ерөнхий шаардлагын дагуу үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, уг хуульд заасан нөхцөл, болзлыг хэрхэн хангаж байгааг тогтоосны үндсэн дээр тэднийг төрийн жинхэнэ албан хаагчид хамааруулах асуудлыг шийдвэрлэх;

б/ Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх өдрөөс эхлэн уг хуульд заасан нөхцөл болзлыг хангасан төрийн захиргааны албан хаагчаар "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг" өргүүлж, тэднийг төрийн жинхэнэ албан хаагчид хамааруулсныг баталгаажуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах.

2. Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бие даасан байдалтай ажиллах Төрийн захиргааны албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг батлуулах, орон тооны гишүүдийг зохих журмын дагуу томилуулах асуудлыг Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх, уг зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд Л. Энэбишид даалгасугай.

3. "Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1995 оны 4 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хууль тогтоомж, Засгийн газрын болон холбогдох бусад байгууллагын шийдвэрийг төрийн албаны тухай хуульд нийцүүлэх саналыг боловсруулж энэ оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхийг Хууль зүйн сайд Н. Лувсанжавт даалгасугай.

4. "Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" Монгол Улсын хуульд заасны дагуу Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3-т заасан албан ажлын онцгой нөхцөл, төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхөх төлбөрийг 1996 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар олгох санал, үүнтэй холбогдон гарах зардлын тооцоог боловсруулж, энэ оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр 1996 оны улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Э. Бямбажав, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын Шадар сайд **Л. ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 230 | Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 1994 оны 207 дугаар тогтоолын 2-ын 14 дүгээр зүйлийн "Электроникийн салбарт аж ахуйн болон үйлдвэрлэл, технологийн зориулалттай төрөл бүрийн электрон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийг үйлдвэрлэх, угсрах", гэсний дараа ... хөдөлгөөнт холбооны сүлжээ байгуулах ашиглалт, үйлчилгээ явуулах салбар гэж нэмсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

ШҮҮГЧ **Д. ДАНЗАНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 245 | Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:

1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын "Гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн нэг хүүхэд" гэдэгт төрийн улс төрийн, захиргааны, тусгай болон үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа иргэний гэр бүлийн гишүүн болох төрсөн буюу үрчилж авсан хүүхдүүдээс боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан өмчийн аль ч хэлбэрийн их, дээд болон мэргэжлийн сургуульд элсэн суралцах эрхийг тогтоосон журмын дагуу олж авсан зөвхөн нэг хүүхэд хамаарна.

2. Мөн зүйл, хэсгийн "... сургалтын зардлыг дотоодын их, дээд, мэргэжлийн сургуулийн тус тус жишгээр тооцож төр хариуцах" гэдэгт Төрийн албаны тухай, хууль хүчин төгөлдөр болсон 1995 оны 6-р сарын 1-нээс хойш их, дээд болон мэргэжлийн сургуульд суралцаж байгаа хүүхдийн сургалтын шууд зардлыг тухайн иргэн төрийн албан тушаал эрхэлж байгаа бөгөөд түүний хүүхэд тухайн сургуульд суралцаж байгаа хугацаанд улсын төсвөөс буцалтгүй хэлбэрээр санхүүжүүлэхийг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

ШҮҮГЧ **Б. ЦОГНЯМ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Т. Баасансүрэн
	Ч. Бавуу
	Б. Ганбат
	Б. Янжинлхам
Техник редактор	Т. Сарантуяа
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан
	Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 9-р сарын 22-нд. Өрөлтөд 1995 оны 9-р сарын 22-нд. Хэвлэлтэд 1995 оны 11-р сарын 22-нд. Хэвлэлийн хуудас 13,0. Хэвлэсэн тоо 4450.

Манай хаяг: Улаанбаатар-12,
Төрийн ордон. Утас: 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр